

Д.Ариунаа, С.Баасандулам, О.Жавзансэлмаа
Г.Нямсүрэн, Х.Энхжаргал

ХӨГЖИМ

VIII-IX

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
8-9 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

DDC 373
HAA 74.2
X-545

Хөгжим 8-9: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 8-9 дүгээр ангийн сурах бичиг. /Ариунаа.Д, ба бус; Ред. Бүдхүү.Х, -УБ.2017. -136х

“Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал хүсэлтийг textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам

ISBN: 978-99978-61-19-1

ӨМНӨХ ҮГ

Хүн төрөлхтөн хоорондоо толь бичиггүйгээр шууд ойлголцож сэтгэл санаагаа илэрхийлдэг цорын ганц хэрэглүүр бол хөгжим билээ.

ЕБС-ийн “Хөгжим”-ийн хичээл нь хүн төрөлхтний оюуны салшгүй нэг хэсэг болсон хөгжмийн соёлтой танилцуулах, сурагчдын авьяас, бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилготой.

8 дугаар ангид хөгжмийн урлагийн хамгийн том төрөл болох сонгодог дуурь, симфони, бүжгэн жүжгийн гайхамшигт ертөнцөөр аялж, хөгжмийн хэл, дүрслэл, уран илэрхийллийн арга хэрэглүүр, хөгжмийн зохиолын төрөл зүйлүүдтэй танилцана.

9 дүгээр ангид “Хөгжим”-ийн хичээлээр орчин үеийн хөгжмийн урлагийн шинэ чиглэл урсгалуудтай танилцан, хөгжмийн уламжлал хэрхэн шинэчлэгдэн хөгжиж буйг сонирхон судлах боломж бүрдэнэ.

Ийнхүү дэлхийн болон монголын хөгжмийн зохиолчдын шилдэг бүтээлүүдийг сонсож, дуулж, хөгжимдөж сонирхон судлах арга замаар бие даасан бүтээлч чадварт суралцана.

XXI зуунд амьдарч буй хүүхдүүд та бүхэн хөгжмийн ертөнцөөр аялан, хөгжмийн хэлээр харилцан, хөгжмийг өдөр тутам бүтээлчээр хэрэглэн эрч хүчтэй амьдрахад тань энэхүү сурах бичиг тусална гэдэгт найдаж байна.

Зохиогчид

ТАНИХ ТЭМДГҮҮД



ДУУЛАХ



ХӨГЖИМ СОНСОХ



ХӨГЖИМДӨХ




ДАСГАЛ АЖИЛ,
ДААЛГАВАР



АЖИГЛАХ, УНШИХ,
ЯРИЛЦАХ



СОНСОХ ХӨГЖИМЙН
ЗОХИОЛЫН ДУГААР



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДУУЛАЛ

Үг. Ц.Дамдинсүрэн

Ая. Б.Дамдинсүрэн, Л.Мөрдорж

Хүндэтгэлтэй

Дар хаш-ма-шай тус-гаар у-лас Да-яар Мошго-лын а-риун го-ломт
5 Да-лай их дээд-сийн гэг-сээн үй - лэс Даг-даа энх-жнж үү - рд монх-жи - но
9 Ха - маг дэл-хийн шу-ларга улс - тай Хамт - ран нэгд-сэн э-вээ бэх - жүүл-жээ
13 Ха - тан зо - риг бү - хий чад - лаа - раа
15 Хайр-тай Мон-гол ор-шоо ман-дуул - яа 1. яа 2.

Өндөр төрийн минь сүлд ивээж
Өргөн түмний минь заяа түшиж
Үндэс язгуур, хэл соёлоо
Үрийн үрдээ өвлөн бадраая

Эрэлхэг Монголын золтой ардууд
Эрх чөлөө жаргалыг эдлэв
Жаргалын түлхүүр, хөгжлийн тулгуур
Жавхлант манай орон мандтугай

VIII АНГИ

БИД ЮУ
СУДЛАХ ВЭ?



ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДУУРЬ

Дуурийн урлагийн үүсэл	7
Г.Пёрселл “Дидона Эней хоёр” дуурийн Дидоны ари	9
К.М.Вебер “Шидэт харваач” дуурийн анчдын найрал дуу	11
Ж.Верди “Аида” дуурийн Ялгуусан марш	12
Д.Лувсаншарав “Шивээ Хиагт” дуурийн Онолтын ари	15
Өөрийгөө сориорой	17

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СИМФОНИ

И.Гайдн 94 дүгээр симфони “Сюрприз”	20
В.А.Моцарт 40 дүгээр симфони	21
Л.В.Бетховен 5 дугаар симфони	22
Ф.Шуберт “Төгсөөгүй симфони”	24
Өөрийгөө сориорой	28
Л.Мёрдорж “Миний эх орон” симфони	30
Б.Шарав “2 дугаар симфони”	34

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БҮЖГЭН ЖҮЖИГ

Бүжгэн жүжгийн үүсэл хөгжил	36
П.И.Чайковский “Цөмөөхэй” бүжгэн жүжиг	37
С.Прокофьев “Ромео Жульетта хоёр” бүжгэн жүжиг	39
Э.Чойдог “Шарилжин дундах цэцэг” бүжгэн жүжиг	40
З.Хангал “Эрдэнэсийн уулс” бүжгэн жүжиг	41
Ж.Чулуун “Уран хас” бүжгэн жүжиг	41
Сонсголын сорил	43
Өөрийгөө сориорой	44
Мэдлэг сорих асуулга	45

ДУУЛЪЯ	46
---------------------	----

ХӨГЖИМДЬЕ	56
------------------------	----

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДУУРЬ

ДУУРИЙН УРЛАГИЙН ҮҮСЭЛ

Дэлхийн урлагийн түүхэнд XVII-XVIII зууны дунд үед Барокко хэв маяг ноёрхож болжээ. Энэ үед хийл, альт, виолончель зэрэг хөгжмийн зэмсгүүд шинээр бий болжээ. Үүний зэрэгцээ дуурь, концерт, сюит зэрэг дуулаач, дан хөгжмийн шинэ төрлүүд үүсэж хөгжсөн. Энэ үеийн урлагийн гол шинж болсон нийгмийн хямрал зөрчлийг хүчдэлийн эрс тэс өөрчлөлт, гоцлол ба хамсраа хөгжмүүдийн ялгарлаар илүү нарийн дүрслэх болжээ.

Хөгжим, яруу найраг, театр, бүжиг, дүрслэх урлаг гэх мэт урлагийн олон төрлүүд нийлж бүтсэн дуурь хэмээх том төрөл Италид үүсжээ. Дэлхийн хөгжмийн түүхэнд анхны дуурь хэмээн тооцогддог бүтээл бол Флоренц хотноо 1597 онд тоглогдсон хөгжмийн зохиолч Якопо Пери, цомнол зохиогч Оттавио Ринуччини нарын “Дафна” дуурь юм. Улмаар Италийн Ром, Венец, Неаполь хотуудаар тархан хөгжихдөө дуурь нь жинхэнэ сонгодог төрхөө олжээ.

400 гаруй жилийн түүхтэй дуурь нь янз бүрийн салбарын, хамгийн олон мэргэжлийн хүнийг хамарч бүтдэг, хамтын бүтээл юм. Өгүүлэх утга агуулгын цар хүрээ, үзүүлэх дүрслэлийн нөхцөл боломж, хамрах үзэгчдийн тоо болон тэдний сэтгэл санаанд нөлөөлөх удвусаараа урлагийн хамгийн том төрөлд тооцогддог. Дуурь бий болсон нь урлагийн түүхэн дэх агуу их нээлт байсан билээ.



- Дээрх сэдвийг анхааралтай уншаарай.
- Уншаад ойлгосноо, загварын дагуу дэвтэртээ тэмдэглэл хийж, ярилцаарай.

V	Мэддэг зүйл байвал
+	Шинэ мэдээлэл авсан бол
-	Чиний мэддэгээс өөр байвал
?	Эргэлзээтэй буюу илүү ихийг мэдэхийг хүсвэл



- Дэлхийн томоохон дуурийн театруудын барилга, улсын далбаагаар Ковент Гарден, Большой театр, Сиднейн дуурийн театр, Метрополитен-опера, Ла Скала, Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн театрыг олоорой. Хэрхэн яаж олсноо тайлбарлаарай.





Дуурийн төрөл

Дуурь нь тус тусдаа орших урлагийн төрлүүдийг нэгтгэдгээрээ давуу талтай юм. Мөн цомнол зохиогч, хөгжмийн зохиолч, найруулагч, удирдаач, зураач, бүжиг дэглээч, найрал дууны удирдаач, дуучин, хөгжимчин, бүжигчин, тайзны гэрлийн техникч гээд олон мэргэжлийн хүмүүсийн хамтын хөдөлмөрийн үр дүнд бүтдэг. Дуурийн уран зохиолын эх материалыг дуурийн урлагийн онцлогт нийцүүлэн эмхэтгэснийг "Цомнол зохиол" гэж нэрлэдэг.

Италийн дуурь нь агуулга, хөгжмийн илэрхийлэх онцлогоосоо хамааран Сериа дуурь (төлөв), Буффа дуурь (хошин) гэсэн үндсэн 2 төрлөөр хөгжиж иржээ. Улмаар дэлхий даяар тархахдаа тухайн улс үндэстний онцлогоос хамааран өөр өөр нэрлэгдэж ирсэн байна. Тухайлбал, Францад "Уянгын эмгэнэлт драм", Германд "Зингшпиль", Англид "Ядуусын дуурь", Испанид "Сарсуэлла" гэх мэт. Үндэснийхээ ахуй соёл, ардын дуу хуурт түшиглэн хөгжсөн Итали, Герман, Франц, Орос, Монгол зэрэг дэлхийн улс орнуудын үндэсний дууриуд нь тухайн нийгэм, цаг үеийнхээ эрэлт хэрэгцээ, шаардлагаас хамааран өөрчлөгдөн шинэчлэгдсээр ирсэн байна. Тухайлбал, XVIII зууны үеийн 3-5 бүлэгт дууриуд XIX зууны сүүл үеэс 1 бүлэгтэй дуурь болтлоо авсаархан, цомхон болсны зэрэгцээ "Нэг хүний дуурь", XX зуунд Жазз хөгжмийн урсгал гарч ирснээр "Жазз дуурь", орчин үед "Рок дуурь" гэсэн шинэ төрөл ч бий болжээ.

Дуурь дахь дуулаачийн төрлүүд

Дуурийг ойлгохын тулд түүнийг бүрдүүлж буй хэсгүүдийн тухай мэдэх хэрэгтэй. Дуурийн үйл явдлыг дуулаачийн гоцлол, цөөхүүл, найрал дууны төрлүүдийн оролцоотойгоор дэс дараалуулан үзүүлдэг.



Дуурь дах гоцлол төрөл

Ари-бодрол дуу. Италиар "агаар, салхи" гэсэн утгатай үг. Дуурийн гол дүрийн зан төрх, дотоод сэтгэхүй, үзэл санааг илэрхийлсэн, симфони найрал хөгжимтэй хамсран дуулахад зориулсан гоцлол төрөл юм. Хэлбэр бүтэц, зохиомжийн нарийн шийдэл, өргөн цараатай өгүүлэмжээрээ ялгардаг, биеэ даасан хэсэг. "Ари" нь дуурийн амин сүнс бөгөөд дуучнаас хоолойн чадал чансаа, жүжиглэх нарийн ур дүйг шаарддаг.

Речитатив-үглэл дуу. "Уран унших" гэсэн утга бүхий латин үг. Ахуйн яриан хэллэгийг аялга хэмнэлд оруулсан дуулаачийн нэг төрөл. Яруу найргийн агуулга, хэмнэлд зохицуулан ярих мэт дуулах арга. Үглэл дууг хөгжмийн хамсраатай /найрал хөгжимтэй/ ба хамсраагүй /зөвхөн дарлалт хөгжимтэй/ гэж ангилдаг.



Генри Пёрселл
(1659-1695)

Генри Пёрселл

"Дидона Эней хоёр" дуурийн Дидоны ари

Энэхүү дуурь нь Эртний Ромын яруу найрагч П.Вергилийн алдарт "Энейда" найраглалаас сэдэвлэн бүтээгджээ. 1689 онд зохиогдсон уг дуурь 200 гаруй жил мартагдсаны эцэст 1895 онд сэргээгдсэнээр дэлхийн дуурийн урын санд дахин байр сууриа эзлэх болсон билээ. Ялангуяа, Дидоны ари нь дуурийн шилдэг номеруудын нэгд зүй ёсоор тооцогддог.

Уй гашуу, уйтгар гуниг бүхий гүн гүнзгий агуулгатай уг дуурийн Дидоны арид эгшгүүдийн хагас шатлалт аялгын хөдөлгөөнийг түлхүү ашигласан нь гол дүрийн сэтгэлийн их уй гашууг дүрслэхэд тохиромжтой гэж үзсэн байна.



- Дидоны арийн ноотыг анхааралтай ажиглан хөгжмөө сонсоорой.
- Ноотоо хараад, дагаад аялж үзээрэй. Хөгжмийн зохиолчийн санаа зөв байсныг өөрсдөө аялж туршсанаар нотлох юм.

Adagio

Thy hand Be-lin - da, dark ness shades me on thy bo- som let me
5 rest more I would - but death - in -
7 vades-me death - is now - a wel- come guest

* Аялга - лат. *intonatio*, интонация. Аялга нь дуудлагын, баяр бахдалын, заналхийллийн, гуниг гансралын, түгшүүрийн гэх мэтээр өөр хоорондоо ялгагдана.

Дуурь дах цөөхүүлийн төрөл

П.И.Чайковский

"Гилийн хатан" дуурийн хоршил Хоньчин бүсгүйн чин сэтгэл

Оросын нэрт хөгжмийн зохиолч П.И.Чайковский "Гилийн хатан" дууриа нэрт яруу найрагч С.Пушкины ижил нэртэй туужаас сэдэвлэн 1890 онд Италийн Флоренц хотноо асар богино хугацаанд зохиосон гэдэг.


Энэхүү дуурьт хөзрийн мөрийтэй тоглоомын золиос болсон цэргийн офицер Герман, гэнэн цайлган залуу бүсгүй Лиза хоёрын сэтгэл хөдөлгөм, эмгэнэлт хайрын түүхийг өгүүлдэг. Лиза, Герман хоёрын аз жаргалын төлөө хүсэл тэмүүлэл нь тухайн нийгмийн бодит байдалтай зөрчилдөн итгэл найдвар алдарч байгааг сэтгэл зүйн эмгэнэлт талаас нь гүн гүнзгий товойлгон харуулсан байдаг.

Дуурийн сонирхолтой хэсгүүдийн нэг нь үйл явдлын завсар оруулга маягаар нэмсэн жүжигчилсэн үзүүлбэр болох малчин бүсгүй Прилепа, түүний сүйт залуу Миловзор нарын "Хоньчин бүсгүйн чин сэтгэл" хэмээх хайрын хоршил юм.

Хоршил-Дуэт. Хоёр хүний бүрэлдэхүүнд зориулсан чуулга бүтээл. Хэдэн хүнд зориулсан гэдгээс нь шалтгаалан хоршил, гурвал, дөрвөл гэх мэтчилэн нэрлэдэг байна. Чуулгад зориулагдсан бүтээлийг дуулаачийн болон дан хөгжмийн хэмээн ангилна.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Ноотоо хараад дагаад аялаарай.



Дуурь дах найрал дуу

Дуурийг найрал дуугүйгээр төсөөлөхийн аргагүй. Дуулаачийн урлагт гоцлол, цөөхүүлээр дуулах төрлүүдээс гадна олон хүнийг хамарсан найрал дууны төрөл байдаг. Найрал дуу нь (хор) цуглаан, олуулаа гэсэн утгатай латин үгнээс гаралтай.

Дуурь, оратори, кантат (магтуу) зэрэг дуулаачийн төрлүүдэд найрал дуу зонхилох үүргийг гүйцэтгэнэ. Тухайлбал, дуурьт гоцлол, цөөхүүлээс гадна дуурийн гол тулгуур багана болсон найрал дууны хэсгүүд дуурийн үйл явдалд идэвхтэй оролцогч болдог. Мөн гол баатрын сэтгэл санааг хуваалцах, дэмжих, аливаа үйл явдлын зангилаа асуудлыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүгээрээ дуурийн найрал дуу нь ард түмний санаа бодлыг төлөөлдөг.

К.М.Вебер



К.М.Вебер
(1786-1826)

“Шидэт харваач” дуурийн анчдын найрал дуу

Хөгжмийн зохиолч К.М.Веберын хамгийн алдартай бүтээл болох “Шидэт харваач” нь анхны романтик дуурь юм. Дуурьт германы ард түмний уламжлалт ёс заншил, анчдын ахуй байдлыг гэрэл сүүдэр, сайн муугийн тэмцлийн дунд харуулна.



Анчдын найрал дуу нь дөрөвц (кварт) интервал бүхий бүрээн дуудлага маягийн өвөрмөц аялгаар эхэлдэг. Угалзан бүрээний яруу сайхан зөөлөн дуугаралтаар амар жимэр ойн төрх байдлыг дүрслэхийн зэрэгцээ анчдын дохио дуудлага, бугын урамдалтыг санагдуулдаг.

- Анчдын найрал дууг анхааралтай сонсоорой.

- Анчдын найрал дууны ноот бичлэгийг ажиглаад аялгуун дах дуудлагын аялга (интонаци) бүхий дөрөвц интервалыг олж тодорхойлоорой.
- Эхний болон төгсгөлийн айзмыг ажигла. Ноотоор дуулахдаа сул хувиас дараагийн хүчтэй хувь руу холбон угтвар айзмыг зөв илэрхийлж дуулаарай.

* Хөгжмийн хэмийн нэг хүчтэй хувиас дараагийн хүчтэй хувь хүртэлх зайг айзам гэнэ. Харин хөгжмийн зохиолын эхний айзам нь сул хувиас эхэлснийг угтвар айзам гэх бөгөөд эхний ба төгсгөлийн айзам нийлж бүтэн болно.

Дуурь дах дан хөгжим

Дуурт дан хөгжмийн хэсгүүд ч чухал үүрэгтэй. Удиртгал хөгжим, дуучдыг дагах хөгжим, үзэгдлийн эхлэл, завсарлага хөгжмүүд дуурийн үйл явдлыг тодотгож, өрнүүлэн хөгжүүлэх хэрэглүүр болж байдаг. Аливаа дуурь удиртгал хөгжмөөр эхэлдэг. Энэ удиртгал нь үзэгч сонсогчдыг дуурийн гол санаатай танилцуулж, дуурт өрнөх үйл явдалд урьдчилан бэлтгэх үүрэгтэй. Зарим тохиолдолд дуурийн зохиолчид дан хөгжмөөр дүрүүдээ бүтээдэг. Тухайлбал, М.И.Глинкийн “Руслан Людмила хоёр” дуурт баатрын аварга толгой, шидтэн одой Черномор гэх мэт үлгэрийн дүрүүдийг зөвхөн дан хөгжим, бүжгийн үйл хөдлөлөөр дүрсэлдэг байна.

Ж.Верди

“Аида” дуурийн Ялгуусан марш



Ж.Верди
(1813-1901)

Ж.Верди: “...хөгжимд зөвхөн аялгуу байж болохгүй. Хөгжимд аялгуунаас өөр чухал юм бий. Энэ бол хөгжим өөрөө!” гэж хэлдэг байсан нь “Аида” дуурт биеллээ олсон юм. “Аида” дуурт Египет Этиопуудын хоорондын тэмцлийн түүхэн үйл явдлыг өгүүлдэг. Ялагдал хүлээн олзлогдсон Этиопын хааны гүнж Аида, Египетийн цэргийн жанжин Радамес хоёрын хайр сэтгэлд Египетийн хааны охин Амнерис саад болсноор үйл явдал ээдрээтэй болдог.

Энэхүү дуурь нь нүсэр тайз засалт, дайчдын сүрлэг жагсаал, олныг хамарсан үзэгдлүүдээрээ онцлог юм.

“Аида” дуурь нь үнэнч хайр сэтгэл, энэрэнгүй, хүнлэг ёсыг дээдлэн тунхагласан агуулга бүхий “хүний сэтгэлийн дуулал” юм. “Аида” дуурийн Ялгуусан марш нь тулаанд ялсан баатруудын сүр жавхаа, эр зоригийг илтгэнэ.


Дуурийн гол дүрүүд





- Хөгжмөө анхааралтай сонсоорой.

Ялгуусан марш



Дууриас бүхнийг харж, бүгдийг сонсож болно. Нэг дуурь үзэхэд хөгжмийн болон дуулаачийн урлагийн бүхий л төрөл зүйлтэй танилцаад гарна. Удиртгал хөгжим, найрал хөгжмийн болон бүжгийн чуулбар хөгжим, дуу бусад төрлүүд хоорондоо хэрхэн найрч нэгэн цогц болж байгааг мэдэрнэ. Дуурь нь үзэгчдэд тэрхүү бүтээл бий болсон нийгэм цаг үеийн байдлын талаар мэдээлэл өгнө. Улс түмний түүх, соёл, зан заншил, амьдралын хэв маяг, харилцаа гээд бүгдийг мэдэх боломжтой. Чухам иймээс дуурийн урлаг агуу.

Дуурь бол тайзны урлагийн сонгомол хэлбэр юм.



- Сэдвийн агуулгад хамааралтай ойлголтуудын олон талт уялдаа холбоог илрүүлцгээе. Мэдсэнээ эмх цэгцтэй илэрхийлэх арга барилд суралцъя.



Монголын дуурийн урлаг

Монголд дуурийн урлаг үүсээд удаагүй боловч наяд жилийн хугацаанд эрчимтэй хөгжиж, үндэсний хэв шинжээ хэдийнээ олсон байна. Тэртээ 1832 онд Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн “Саран хөхөөний намтар” хэмээх туужийг Төвөд хэлнээс орчуулж, аялгуут жүжиг болгон тавьсан нь Монголд дуурийн урлаг үүсэх үндэс суурь нь болжээ. Уг дуулалт жүжгийг бүрэн хэмжээгээр нь тоглоход 30 хоног, товчилбол 15 хоног тоглодог байсан гэдэг.

1921 оны ардын хувьсгалын дараах жилүүдэд монголд аялгуут жүжгүүд тавигдаж байсан нь “дуурь” хэмээх төрөл бий болох бэлтгэл болсон юм. Зөвлөлтийн мэргэжилтэн Б.Смирнов, хөгжмийн зохиолч Б.Дамдинсүрэн нар 1942 онд “Учиртай гурван толгой” аялгуут жүжгийг дуурь болгосноор Монголын дуурийн урлагийн түүхэн хуудас эхэлсэн билээ.

“Учиртай гурван толгой” дуурийн зохиомж, хөгжмийн хэл хэллэг нь ардын харилцаа дууны уламжлалд тулгуурласан бол 1957 онд зохиогдсон С.Гончигсумлаагийн “Үнэн” дуурь нь сонгодог дуурийн гол төрлүүдийг хэрэглэснээр үндэсний онцлогийг сонгодог дуурийн уламжлалтай чадварлаг хослуулсан бүтээл болсон юм.

Эдүгээ монголын дуурийн урлаг төрөл зүйл болон сэдэв, агуулгын цар хүрээгээ тэлж, урын сан нь шилдэг бүтээлүүдээр арвижсаар байна.



- Сэдвийг анхааралтай уншаад, дэвтэртээ тэмдэглэл хийгээрэй.
- Дараах монгол дууриудын талаар мэдээлэл цуглуулж даалгаврыг гүйцэтгээрэй.

№	Зохиогчид	Дуурийн уран бүтээл	Агуулга
1	Д.Нацагдорж, Б.Дамдинсүрэн, Б.Смирнов	?	?
2	?	Үнэн дуурь	?
3	Д.Пүрэвдорж Д.Лувсаншарав		
4	?	Ламбугайн нулимс	?
5	?	?	Морин хуур хөгжмийн зэмсгийн үүсэлтэй холбоотой домгийн сэдэвт дуурь



Д.Лувсаншарав



Д.Лувсаншарав
(1926-2014)

“Шивээ Хиагт” дуурийн Онолтын ари

Ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн цомнолоор Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Ардын жүжигчин хөгжмийн зохиолч Д.Лувсаншарав 1971 онд “Шивээ Хиагт” гурав дахь дууриа бичжээ. “Шивээ Хиагт” дуурьт ардын хувьсгал ялж Хиагт хотыг гамин цэргээс чөлөөлсөн түүхэн үйл явдлыг харуулсан юм. Уг дуурийн нандин шигтгээ болсон Онолтын ари нь өвгөний шаналан зовсон сэтгэлийн дотоод ертөнцийг илэрхийлдэг.



- Үг, аялгууны харилцан хамаарал, дуурийн дуучин хүн жүжигчин байх ёстойн учир юу вэ?



- Доорх үгсийн хоорондын хамаарлыг тодорхойлж ярилцаарай.

Гол дүрийн дуу, Онолтын ари, бодрол дуу, өвгөний сэтгэлийн зовиур, гунигт аялга

- Хөгжмөө анхааралтай сонсоорой
- Онолт хэн бэ? Яагаад зовж шаналав? Дуурийн агуулга үйл явдалтай холбон ярилцаарай.



Онолтын ари

Музыкальная запись песни "Онолтын ари" (The Oath of the Old Man) from the opera "Shivee Khagt". The score is written in G major and common time (C). The lyrics are in Mongolian.

бу-ян үйл-лэж өр-гөл бар-ъя бур-хан минь таа- лаж хай-рла я-вах га - заргүй энэ хор-воод

яа-хиаг па-дал зааж еоё-рох бур-хал чи- бай- пуу-дгүй юу бур-хал гэ - дэг байх-гүй ю-муу



- Зохиолыг сонсож байх үедээ тэмдэглэл хөтлөөрэй.
- Тэмдэглэлийнхээ дагуу харьцуулан ярилцана уу.

Асуулт Бүтээлийн нэр	Төрөл	Аялга	Дүрслэл	Шинж төрх
К.Вебер "Шидэт харваач" дуурь	Найрал дуу	?	?	?
Ж.Верди "Аида" дуурь	?	?	Ёслол хүндэтгэл	?
Д.Лувсаншарав "Шивээ хиагт" дуурь	?	Гунигт аялга	?	?
П.И.Чайковский "Гилийн хатан" дуурь	?	?	?	Бүжгийн шинж төрхтэй

- Сонгодог хөгжмийн чиглэл, дуурийн төрлүүд, суут хөгжмийн зохиолчдын уран бүтээлтэй дараах вэб хаягуудаар аялж, дэлгэрүүлж судлаарай.



www.music.com
www.classicalarchives.com
en.wikipedia.org/wiki/Classical_music
beethoven.blog.banjig.net
www.baroque.it
www.musicmp3.ru
www.beemp3.com
www.mp3raid.com



Интернэт хөтөч дээрээ доорх хаягуудыг бичээд хөгжмийн цахим ертөнцөөр аялаарай.

Өөрийгөө сорiorой

Хөгжмийн урлагийн олон зуун жилийн түүхэнд янз бүрийн онцлог үйл явдлуудтай холбоотой он цаг, газар орны нэрс тэмдэглэгдэн үлдсэн байдаг.



- Анхааралтай уншаарай.
- Дараах он тоолол, газар орны нэр юу өгүүлж байна вэ?
 1. 1597 Италийн Флоренц
 2. XVII-XVIII зуун Итали
 3. 1945 оны Чөлөөлөх дайн. Б.Дамдинсүрэн
 4. 1832 он. Говийн ноён хутагт Данзанравжаа
 5. 1942 он. Д.Нацагдорж, Б.Дамдинсүрэн
- Уншаад дуурийн төрлөөр бичигдсэн зохиолуудыг ялгаж бичнэ үү.
 1. "Севилийн үсчин"
 2. "Фигарогийн хурим"
 3. "Жизель"
 4. "Учиртай гурван толгой"
 5. "Кармен"
 6. "Цэнхэр нүдэн бүсгүй"
 7. "Травиата"
 8. "Чио Чио сан"
 9. "Хөхөө Намжил"
 10. "Цөмөөхэй"
- Дуурийн дараах хэсгүүдийн тухай чи юу мэдэх вэ?
 1. Удиртгал
 2. Ари
 3. Үглэл дуу
 4. Найрал дуу
 5. Чуулга
 6. Антракт
- Гинжин хэлхээ үүсгэцгээе.

Эхний сурагч дуурь гэж хэлнэ. Дараагийн сурагч үг нэмж холбоо үг үүсгэнэ. Ийм байдлаар нэмэгдсээр гинжин холбоо үүсгэж ярилцаарай.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

СИМФОНИ

Symphony буюу симфони нь эртний грек хэлний нийцэл, дуурьсал гэсэн утгатай үг юм. Энэ нь дан хөгжмийн зохиолын хамгийн том төрөл билээ. Классицизмын (XVIII зуун) үед дан хөгжим хөгжих нөхцөл бүрдсэнээр сонат, симфонийн төрөл сонгодог хэлбэрээ олжээ. Хөгжмийн зохиолчид дан хөгжмийн чуулга, найрал хөгжимд зориулсан эдгээр бүтээлүүдийг тогтсон хэлбэр, бичлэгийн арга барилаар туурвих болсон. Зохиолыг бичсэн ноот тэмдэглэгээний дагуу хөгжмийн зохиолчийн санааг гажуудуулахгүй тоглох шаардлагыг хөгжимчдөд тавих болж зохиолын хурд, хүчдэл, хөгжимдөх арга барилын тогтсон дэгийг хатуу баримтлах болсон ажээ.

Дан хөгжмийн зохиол нь утга агуулга, төрөл, хэлбэрээрээ баялаг юм. Бэсрэг аязаас эхлээд симфони чуулбар, найраглал, зураглал, олон ангит симфони хүртэл олон төрөл байна. Байгаль, нийгэм болон хүний дотоод ертөнцийг бүхэлд нь илэрхийлэх увдис дан хөгжимд байдаг.

Сонгодог симфонийг үндэслэгчид нь И.Гайдн, В.А.Моцарт, Л.В.Бетховен нар юм. Сонгодог симфони нь 4 ангитай. Эдгээр ангиуд нь хүмүүний амьдралын олон талт үзэгдлийг дүрслэн илэрхийлэх бүрэн боломжтой.

I анги Хөгжил хөдөлгөөнтэй, идэвхтэй, хурдтай байдаг. Учир нь энэ ангид аливаа үзэгдлийг хөгжил хөдөлгөөн, зөрчил дунд нь дүрсэлдэг.

II анги Энэ удаан анги бол симфонийн уянгын төв. Ихэнхдээ гүн бодол бясалгалын шинжтэй байх нь элбэг. Тодруулан хэлбэл гол баатрын дотоод сэтгэхүйн ертөнцийг илэрхийлнэ.

III анги Бүжгийн цоглог шинж төрхтэй. Энэ бол ард түмний аж амьдралын нэгээхэн зураглал буюу хүний хөгжил баясал, бүжиг наадам, ололт амжилт, ахуй байдлын олон талыг илэрхийлдэг.

IV анги Өмнөх ангиудад өгүүлснийг нэгтгэн дүгнэж бататгасан хэсэг юм.



Эндээс үзвэл симфони нь хөгжил хөдөлгөөн, зөрчил тэмцэл, уянгын өрнөл, ахуй байдлын олон тал, сэтгэл хөдлөлийн туйлыг илэрхийлэх хөгжмийн том төрөл юм.

Хүн байгаль, нийгэм, сэтгэхүйн ертөнцийн бүхий л үзэгдэл, үйл явцыг хөгжмийн өнгө будгийн баялаг хэллэгээр өгүүлж чаддагаараа симфони нь сонгодог, төгс төгөлдөр гэсэн утгадаа нийцэж байдаг юм.

Төрөл бүрийн зэмсгээр нэг зохиолыг нийлж хөгжимдөх хөгжимчдийн хамтлагийг найрал хөгжим гэнэ. Симфони найрал хөгжим нь хамгийн баялаг хөг эгшиглэгээ, өнгө аястай уран илэрхийллийн өргөн их боломжтой юм.



И.Гайдн сонгодог симфонийг үндэслэгч

"И.Гайдн төрөөгүйсэн бол Моцарт ч үгүй, Бетховен ч үгүй"

П.И.Чайковский



И.Гайдн
(1732-1809)

Австрийн суут хөгжмийн зохиолч, удирдаач И.Гайдн 1732 онд төржээ. И.Гайдн амьдралын утга учир, хүний сэтгэлийн ертөнцийг гүнзгий илэрхийлж чадахуйц дан хөгжмийн том хэлбэрийн зохиол болох анхны симфонийг 1759 онд бичжээ. Ордны найрал хөгжимтэй амьдралаа холбосон гучаад жилийн хугацаанд сонат, симфонийхоо 4 ангит сонгодог загварыг боловсруулж симфони болон квартет (дөрвөл)-ийн төрлийг үндэслэн хөгжмийн урлагийн түүхэнд "Симфонийн эцэг" гэж нэрлэгдсэн юм.

Тэрээр нийт 104 симфони, 30 орчим дуурь, дан хөгжмийн 83 квартет, төрөл бүрийн хөгжмийн 50 концерт зэрэг олон бүтээл туурвисан нь хүн төрөлхтний хүртээл болж чаджээ.

И.Гайдн гүн утга санааг илэрхийлэн дүрсэлж чадахуйц өнгө дуурьсал, хөгийн зохицол бүрдсэн симфоны найрал хөгжмийн бүрэлдэхүүнийг нумт чавхдаст, модон үлээвэр, гуулин үлээвэр цохиур хөгжмийн гэж үндсэн 4 бүлэг болгон тогтоосон. Тэрээр найрал хөгжмийн шинэ бүрэлдэхүүндээ зориулж симфони, дуурь, дөрвөл зэрэг зохиолоо бичжээ. Уран бүтээлийнх нь сэдэв тариачдын ахуй амьдрал, тэдний хэзээ ч унтаршгүй өөдрөг гэрэл гэгээ, эрч хүч байсан юм.

И.Гайдны гол ололт бол дан хөгжмийн төрлийг хөгжүүлсэн явдал билээ.

94 дүгээр симфони "Сюрприз"

Энэхүү зохиол нь суут хөгжмийн зохиолч И.Гайдны 104 симфонийн "Лондоны" хэмээн алдаршсан сүүлийн 12 бүтээлийн нэг юм. И.Гайдн эдгээр зохиолуудаараа симфонийн сонгодог хэв маягийг бий болгосон билээ.

Уг симфонийн II ангийн удаан темптэй бүүвэйлэх мэт намуухан хөгжимд үзэгч, сонсогчид тайвшран амирлах тэр агшинд гэнэт нүргэлэх чимээ цочооно. Хөгжмийн зохиолч энэ хэсэгтээ зориудаар гэнэтийн бэлэг болгон литаврын (яруу хэнгэрэг) дуугаралтыг ашигласан нь "Сюрприз" хэмээн нэрлэхэд хүргэжээ.

Зохиолоо Моравын хүүхдийн дууны аялгуунаас сэдэвлэжээ. Маш энгийн аялгууг өнгө аясын олон янз байдлаар чадварлаг хувилбарлан хөгжүүлсэн байна. Ингэхдээ хөг эгшиглэгээ (мажор, минор), регистр, тембрийн ялгарамж, олон хоолойн илэрхийллийн аргуудыг ашиглажээ.



- Хөгжмөө сонсоод, ноотоор дуулаарай. Дуулахдаа легато, стаккато ашиглан хоёр янзаар дуулж, дүрслэл илэрхийлэл хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлж ярилцаарай. Хөгжмийн зохиолч ямар зорилгоор энэ хэсэгт стаккато хэрэглэсэн гэж бодож байна вэ?



- Ноот бичлэгийн 7 дахь айзамд гарч ирж буй тохиолдлын тэмдэг, үгсэн тэмдэглэгээ (G) хоёр юу илэрхийлж байна вэ?

II анги Andante



Ер нь И.Гайдн шогч, наргианч хүн байсан гэдэг. Тиймээс бодож олсон янз бүрийн зүйлсээ зохиолдоо оруулдаг байсан ажээ. Тухайлбал, баавгайн болхидуу хөдөлгөөн, эсвэл тахианы донгодох дууг дуурайн дүрсэлсэн симфониудыг нь "Баавгай", "Тахиа" хэмээн хожим нь нэрлэсэн байдаг.

Нэгэн удаа И.Гайдн анд яваад буцаж ирэх замдаа барааны захаар оржээ. Тэнд нэгэн хөл нүцгэн бяцхан хүү худалдагчийн сагсан дахь тоглоомуудыг ихэд шунан шимтэн харж байхыг ажаад, шаазан хөхөө, шүгэл, цоор, бөмбөр зэргийг худалдан авч хүүхдүүдэд тараан өгчээ. Тэдгээр хөгжмийн зэмсгүүдээр хүүхдүүд аз жаргалтайгаар тоглож, үлээж, шүгэлдэж, бөмбөрдөж байгаа нь хөгжмийн зохиолчид "Хүүхдийн симфони" бичих сэдлийг төрүүлсэн юм.



Литавр (um. timpani). 30-84 см хүртэл диаметртэй, тогоо маягийн хэлбэртэй, арьс эсвэл хуванцараар бүрж хийсэн, тодорхой эгшгийн өнлөрлөгт хөглөдөг цохивор хөгжмийн зэмсэг. Европд орчин үеийн литавртай төстэй хөгжмийн зэмсгийг XV зуунаас мэддэг болжээ. Уг хөгжмийн зэмсэг XVII зуунаас найрал хөгжмийн бүрэлдхүүнд багтсан байдаг.

В.А.Моцарт

40 дүгээр симфони

В.А.Моцарт
(1756-1791)

В.А.Моцартын уран бүтээлийн нэг гол төрөл нь симфони юм. Энэ төрлөөр нийт 49 симфони бичсэнээс 39, 40, 41 дүгээр симфони нь алдартай. Эдгээрээс хамгийн их түгсэн бүтээл нь уянгын драматик 40 дүгээр симфони юм. Энэ симфони 4 ангитай.

I анги Аллегро. Гол ая нь уянгын бөгөөд догдлонгуй шинжтэй. Энэ аялгууг хийл хөгжмийн дулаан, уянгалаг, яруу эгшиглэгээ улам тодотгож өгнө. Туслах ая нь гол аяг бодвол нэлээд гоёмсог дэгжин, бүжгийн шинж төрхтэй юм.

II анги Анданте. Хүчит салхи шуурганы дараах тогтуун, нам гүм байдлыг санагдуулам энхрий ялдам удаан аялгуугаар эхэлнэ. Энд гол ба туслах аялгууны хооронд

ялгарамж бага сонсогдоно.

III анги Менуэт хэмээн нэрлэгдэх ч шийдмэг зоримог аялгуу нь маршийн өнгө аясыг санагдуулна. Харин чавхдаст болон модон үлээвэр хөгжмийн зэмсгүүдийн харилцал маягаар эгшиглэх дунд хэсэг нь байгалийн сайхныг дүрслэн зураглажээ.

IV анги нь уг зохиолын драматик өрнөлийг оргилд нь хүргэдэг. Эрч хүчтэй эргэлдэн хуйлрах салхи мэт тэмүүлэлтэй гол аялгуу нь гоёмсог дэгжин туслах аялгуутайгаа тодорхой ялгарамж үүсгэнэ.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Ноотоо хараад дагаад аялаарай.

40 дүгээр симфонийн I анги



Моцартын симфони найрал хөгжимд чавхдаст хөгжмийн зэмсгүүд гол үүрэг гүйцэтгэдэг.

5 дугаар симфони



Л.В.Бетховен
(1770-1827)

Суут Л.В.Бетховен өөрийн хамгийн алдартай бүтээлүүдийн нэг болох 5 дугаар симфонийнхоо гол сэдэв аялгууг “Хувь заяа хаалга тогшиж байна” гэж нэрлэсэн байдаг. “Харанхуйгаас гэрэл гэгээ рүү, амьдралд тохиолдох саад тотгорыг цуцалтгүй тэмцлийн үр дүнд ялан дийлж, эрх чөлөөнд хүрнэ” гэсэн санааг уг зохиолоороо илэрхийлэхийг зорьсон.

Уг симфони тухайн цаг үедээ баатарлаг тэмцэлд уриалсан хүчирхэг дуудлага бадрангуй сэтгэлгээний дуулал болж байлаа.



- Симфонийн I ангийг анхааралтай сонсоод, аялгууны хүчирхэг динамик*, зогсолтгүй урагшлах хурд юу илэрхийлж болох талаар эргэцүүлэн бодоорой.

Гол ая 

Туслах ая 

- Ямар үйл явдлыг илэрхийлж байгаа талаар таамаглал дэвшүүлээрэй.
- Таамаглалаа түлхүүр үгс ашиглан дэвтэртээ бичнэ үү.

Түлхүүр үгс: хувьсгал, эрх чөлөө, хувь заяа, тэмцэл, зөрчил, гуулин үлээвэр, зогсолтгүй эрч хүч, зорилго тэмүүлэл, хүчирхэг нударга.



- Ноотыг ажиглаад аялгууны бүтэц, хэмнэлийн онцлог шинжийг тодорхойлоорой.
- Эхний ангийн гол сэдэв аялгууны 4 эгшигт хэмнэл симфонийн бүхий л ангид нэвт хөгждөг. Дараах сэдэв аялгуунаас зохиолын гол сэдэв аятай төстэй хэмнэлийг олоорой.

Allegro

A 

B 

C 

* Хөгжмийн дуурьслын чанга сулын тухай ойлголт

Нэрт яруу найрагч О.Дашбалбар агсан Москвад сурч байхдаа суут Бетховены 5 дугаар симфонийг сонсоод, төрсөн сэтгэгдлээрээ “Хөгжим” хэмээх шүлэг зохиосон бөгөөд түүнийгээ эрдэмтэн зохиолч Л.Түдэвт явуулсан байна. Шүлгийн хэсгээс сийрүүлбэл:

Тэнгис далай, аугаа их уул, орон хот өөрийн аялгуутай
Тэргэл саран, ургамал амьтан, хүн, чулуу өөрийн эгшигтэй
Газар дэлхийн аялгуу бүхэн нийлэн их найрал дуурьсаж
Гариг ертөнц сансрын хязгааргүй хөгжмийн аялгуунд оршиж байна.
Цэцэн билэг бус хөгжмийг би өөрийн эрхгүй гайхнам
Цэнхэрлэх алсад дуудсан гайхамшигт аялгууны цамхагт би дөхнөм
Өлгийтэй хүүхдийн жижигхэн зүрхэнд хүрч, тайвшруулах нандин урлаг
Өвчтөний эдгэршгүй шархыг, мэс хүргэлгүй анагаах хөгжмийн засал
Нандин баатарлаг, эмгэнэл, баяр жаргалыг нэгэн зэрэг илэрхийлж
Нарт ертөнцөд хүнийг уйлуулсан, инээмсэглүүлсэн хөгжимд би мөргөмү
“Гартаа хийл барьсан цагтаа хүн, муу үйл хийхгүй” гэсэн
Гайхамшигт үгийн үнэ цэнийг өнөөдөр би зүрхэндээ шингээмү.



- Хөгжмөө сонсоод И.Гайдны 94, Л.В.Бетховены 5 дугаар симфонийн найрал хөгжмийн бүрэлдэхүүнийг харьцуулаарай.
- Зохиолуудаа харьцуулан сонсоод, хөгжмийн зэмсгийн бүлгүүд найрал хөгжимд ямар үүрэгтэй оролцож байгааг тодорхойлоорой. Тухайлбал: Гоцлох, хамсрах, хэмнэл тоглох гэх мэт...



- Зургийг ажиглаад хөгжмийн толь бичиг, цахим эх сурвалж ашиглан хөгжмийн зэмсгүүдийн талаар мэдээлэл боловсруулж танилцуулаарай.
- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Дараах бүтээлүүдэд симфони найрал хөгжмийн ямар зэмсгүүд голлох үүрэг гүйцэтгэж байна вэ?
 1. В.А.Моцарт 40 дүгээр симфони I анги
 2. Л.В.Бетховен 5 дугаар симфони I анги
 3. Ф.Шуберт 8 дугаар симфони I анги
 4. Г.Берлиоз "Уран зөгнөлийн" симфони IV анги



Ф.Шуберт
(1797-1828)

Ф.Шубертын симфони бүтээл

Романтизмыг үндэслэгч хэмээн түүхэнд тодорсон, Австрийн суут хөгжмийн зохиолч Ф.Шубертын уран бүтээлийн чиг нь хүний дотоод сэтгэл, гүн бодол санаашрал, хүсэл, мөрөөдөл, утга уянгын дуулал юм.

Романтизм (XIX зуун) нь сэтгэл хөдлөлийг илүү нээлттэй илэрхийлж тогтсон дэгт баригдалгүй, чөлөөт хэлбэрээр туурвиж, зохиолын утга санааг хөтөлбөрчлөх болсноороо онцлог юм. Цуврал хэлбэртэй дуулаач болон дан хөгжмийн шинэ төрлүүд үүсч, дуурь симфони зэрэг томоохон төрлүүдээр өгүүлэгдэх утга санааг жижиг хэлбэрээр илэрхийлэх болсон байна.

Ф.Шуберт бол Л.В.Бетховен шиг хувьсгалын үеийн дууч биш, харин нийгэм улс төрийн харгислал дарангуйлал эхэлсэн шинэ цаг үеийн төлөөлөл байв. Дарангуйллын эсрэг, эрх чөлөөнийхөө төлөө тэмцэхийг хүн төрөлхтөнд уриалахад Л.В.Бетховенд хөгжмийн урлагийн хамгийн том төрөл болох симфони хэрэгтэй байсан бол хувь хүний сэтгэхүйн нарийн ертөнц рүү нэвтрэхэд Ф.Шубертэд утга уянгын дуун өгүүлэмж тохиромжтой байсан юм. Л.В.Бетховен сонгодог хөгжмийн хөгжлийн бүтэн зууныг төгсгөсөн бол Ф.Шуберт романтик хөгжмийн эхлэлийг тавьсан билээ.

Л.В.Бетховен
1770-1827



Ф.Шуберт
1797-1828

"Төгсөөгүй симфони"

Романтизмын үеийн симфони бүтээлд онцгой байр суурь эзэлдэг зохиол бол Австрийн суут хөгжмийн зохиолч Ф.Шубертын си минорын "Төгсөөгүй" хэмээх 8 дугаар симфони юм. Уг симфони 2 ангитай. Сонгодог 4 ангит симфонитой харьцуулбал үнэхээр төгсөөгүй зохиол юм. Гэвч уг зохиолын үндсэн санаа энэ хоёр ангид бүрэн дүүрэн тусгагдсан. Ийнхүү утга санаа, илэрхийлэх арга зэрэг аль ч талаараа бүрэн төгссөн 2 ангитай өвөрмөц симфони мэндэлсэн түүхтэй.

"Төгсөөгүй" симфони нь дууны өвөрмөц өгүүлэмжээр шийдэгдсэн, "Дуун симфони" гэдэг утгаараа хөгжмийн түүхэнд шинэ хуудас нээсэн юм.

Ф.Шуберт

I анги	II анги
Хурцадмал, эмгэнэлт өнгө аяс	Гэгээн мөрөөдөл, тайван бодлогошрол

I анги. Оршил хэсэг



Гол аялгуу




Туслах аялгуу



- Хөгжмөө сонсоод төрсөн сэтгэгдлээ дүрслэн бичээрэй.
- Зохиолд чиний бодлоор юуны тухай өгүүлж байна вэ?
- Чи хөгжмийн зохиолын эгшиглэх хүчийг үгээр хэрхэн илэрхийлсэн бэ? Тэр хэсгийнхээ доогуур зур.



- Зохиолынхоо дүрийг хэрхэн тодорхойлсон бэ? Зурж тэмдэглэ.
- Энэ дүрийг чи юунаас мэдэрсэн бэ?
- Зохиолын хурд чиний дүрслэлд юуг тодотгож өгсөн бэ? Тэр хэсэгтээ мөн зурж тэмдэглэ.
- Чиний зохион бичлэгт ямар өнгө будаг голлож байна вэ? Мөн тэр хэсгийнхээ доогуур зураарай.
- Ялгаж тэмдэглэсэн хэсгүүдээ уншаарай, Хөгжмөөс ямар агуулга дүрийг бүтээсэн бэ?



XIX зуун Норвегийн зураач Педер Балке. Хойд тохой



М.И.Глинка
(1804-1857)

М.И.Глинка

“Арагоны хота” симфони удиртгал

Оросын сонгодог симфонийг үндэслэгч, нэрт хөгжмийн зохиолч М.И.Глинка 1845 онд Испани орноор аялж явахдаа төрсөн сэтгэгдлээсээ үүдэн энэхүү удиртгалаа бичсэн гэдэг. Испанийн ард түмний аж амьдралыг бүхэлд нь зурагласан энэ хөгжмийг сонсоход аргагүй л нарлаг Испани орны байгалийн гоо үзэсгэлэн, цог золбоот ард түмний эрч хүч, инээд хөөр, нүд гялбам өнгөлөг дүр зураг сэтгэлд бууна.

Энэ сайхан уур амьсгалыг бүрдүүлэхэд хөгжмийн зохиолчийн бүтээлдээ авч ашигласан Арагон тосгоноос гаралтай “Хота” бүжгийн Испани аялгуу, хэмнэл, испаничуудын тоглодог кастаньет хөгжмийн зэмсэг чухал үүрэг гүйцэтгэдэг.

“Арагоны хота” удиртгал ёслол хүндэтгэлийн дохио дуудлагаар эхэлж, улмаар хота бүжгийн хэв шинжтэй, цоглог гол сэдэв ая залгана. Хөгжим бүхэлдээ гэрэл цацруулам амьдралын эрч хүч, баяр хөөрөөр бялхаж байдаг.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Эх бичвэрээс энэхүү бүтээлийн ач холбогдлыг тодорхойлж дүгнэлт хийнэ үү?
- Ноотоо хараад хэмнэлийг тогшиж үзээрэй.





- Ноотоор дуулъя. Энд та нарын сайн мэдэх суут хөгжмийн зохиолчдын алдартай бүтээлийн аялгууны хэсэг байна.
- Хэний ямар зохиол болохыг тодорхойлоорой.
- Энэ бүтээл хөгжмийн зохиолын ямар төрлөөр бичигдсэн бэ?
- Тухайн зохиолын төрөлд тохирох тодорхойлолтыг олоорой.



?

Францаар
нээх гэсэн
утгатай.
Дуурь бүжгэн
жүжгийн
эхлэл
хөгжим.

?

Сонгодог
зөрчилт
хөгжим.
Гоцлол
болоод
цөөхүүл
хөгжмийн
үндсэн төрөл.
Ихэвчлэн 3
ангитай.

?

Эртний
грек хэлний
нийцэл,
дуурьсал
гэсэн утгатай
үг. Байгаль,
нийгэм, хүний
сэтгэхүйн
ертөнцийг
илэрхийлэх
хөгжмийн
урлагийн том
төрөл.

?

Латинаар
уралдах,
италиар
нийцэл,
зохицол гэсэн
үг. Гоцлол
хөгжмийн
төгс ур
чадварыг
харуулах
гоцолбор
зохиол.

?

Өөр өөр шинж
төрхтэй, хэд
хэдэн цуврал
хэсгээс бүтсэн
хөгжмийн
зохиол.

Өөрийгөө сориорой

Дараах тайлбар ярианд хэний ямар зохиолын тухай өгүүлж байна вэ?

1 Вена дах францын элчин, генерал Бернадотт 1798 онд нэгэн алдартай хөгжмийн зохиолчид Наполеоны ялалт, алдар гавьяаны тухай тусгасан зохиол бичихийг зөвлөжээ. Энэ зөвлөгөөг тун найрсаг хүлээн авсан хөгжмийн зохиолч нэгэн симфонио Наполеон Бонапартад зориулан гарчиглаж тусгайлан бичжээ. Гэвч хөгжмийн зохиолч Наполеоныг өөрийгөө хэмжээгүй эрхт хаанд өргөмжилснийг мэдмэгцээ эгдүүцэн уурлаж симфонийнхоо нэрийг “Баатарлаг” хэмээн өөрчилжээ.



2 Нэгэн хөгжмийн зохиолч уран бүтээлийнхээ ид цэцэглэлтийн үед хоёр ангит симфони бичжээ. Энэ зохиолыг “Дуун симфони” хэмээн нэрлэсэн байдаг бөгөөд си минорын дэвсгэр хөгт бичигдсэн. Хөгжмийн зохиолч амьд ахуйдаа нэг ч симфонио тоглуулж чадаагүй байдаг. Харин түүний найз, хөгжмийн зохиолчийг нас барснаас хойш гар бичмэлийг нь олон жил хадгалж байгаад түүний дурсгалд зориулан анх тоглуулсан түүхтэй.



3 Хөгжмийн зохиолч 49 симфони зохиосон боловч сүүлчийн симфони нь 41 дүгээр симфони хэмээн дугаарлагдсан байдаг. Хамгийн алдартай симфони нь сүүлээсээ 2 дах нь бөгөөд соль минорын дэвсгэр хөгт бичигдсэн, шууд гол сэдэв аяасаа эхэлдэг.



4 Гуч гаруй дуурь зохиосон боловч симфонийн бүтээлүүд нь амжилтанд хүрч түүнийг хөгжмийн түүхэнд сонгодог симфонийг үндэслэгч хэмээн мөнхжүүлсэн байдаг. Тэрээр амьдралынхаа гучаад жилийг нэгэн алдартай вангийн хамжлагат хөгжимчдөөс бүрдсэн найрал хөгжмийн хамтлагийг удирдаж, түүнд зориулан зохиолоо туурвиж байжээ.



5 Тэр 600 гаруй дуу зохиосон гэгддэг бөгөөд хөгжмийн түүхэнд дуулаачийн цуврал хэмээх романтик хөгжмийн төрлийг үндэслэсэн. Дууны цувралуудаа өөрийнхөө амьдрал, хайр сэтгэлийн түүхээс сэдэвлэсэн байдаг. Түүний зохиосон дууны хоёр цувралын нэг нь нөгөөгийнхөө үргэлжлэл байж болохоор үйл явдал, агуулгын холбоотой байдаг.



6 Оросын хөгжмийн зохиолч, Испанийн Арагон мужид өргөн дэлгэрсэн нэгэн бүжгийн аялгуунд тулгуурлан энэхүү удиртгалаа зохиожээ. Энэ удиртгалдаа испани дүр төрх, үндэсний хөгжмийн онцлогийг харуулахын тулд гитар, мандолин, кастаньетийн дуугаралтыг симфони найрал хөгжмийн зэмсгүүдээр төлөөлүүлэн гаргажээ.



7 Хөгжмийн зохиолч өөрийн хайр сэтгэлийн түүхээс сэдэвлэн 5 ангит, уран дүрслэл бүхий симфони зохиожээ. Тэрээр энэ бүтээлээрээ шинэ хэлбэрийн хөтөлбөрт симфонийн төрлийг үндэслэгч хэмээн хөгжмийн түүхэнд мөнхөрсөн юм.



8 1791 онд Вена хотод хөгжмийн суут зохиолчийг нас барахаас өмнөхөн нэгэн нууцлаг хүн ирж “нас барагсдын хойноос гашуудан дуулахад зориулсан” зохиол бичүүлэхээр захиалга өгчээ. Ийнхүү хөгжмийн зохиолчийн хамгийн сүүлчийн томоохон зохиол болох “Реквием” зохиогджээ. Гэвч хөгжмийн зохиолч энэ бүтээлээ хараахан дуусгаж амжаагүй юм.



Монголын симфони хөгжмийн үүсэл

Монголын орчин цагийн хөгжмийн урлагийн хөгжилд гарсан нэг ололт бол симфони хөгжмийн цоо шинэ төрөл, хэлбэр бий болсон явдал юм. Монголын симфони хөгжмийн анхны гараа 1950 онд зохиогдсон хөгжмийн зохиолч Ц.Намсрайжавын “Хувьсгалт баатарлаг марш” симфони удиртгалаар эхэлсэн гэж судлаачид үздэг. Харин өрнө дахины симфонийн бүтэц, зохиомжийн жишгээр туурвигдсан монголын анхны бүрэн хэмжээний симфони бол Төрийн хошой шагналт Ардын жүжигчин Л.Мөрдоржийн “Миний эх орон” (1955) юм.

Орчин цагийн Монголын симфонийн хөгжилд С.Гончигсумлаа, Б.Дамдинсүрэн, Л.Мөрдорж, Ц.Нацагдорж, Б.Шарав, З.Хангал нарын хөгжмийн зохиолчид ихээхэн үүрэг гүйцэтгэсэн билээ. Монголын хөгжмийн зохиолчид симфони-уран сэтгэмж, зураглал, найраглал, удиртгал, чуулбар, концерт гээд олон төрөл зүйлээр уран бүтээлээ туурвидаг.



Л.Мөрдорж
(1919-1996)

Л.Мөрдорж

“Миний эх орон” симфони

Хөгжмийн зохиолч “Миний эх орон” симфонидоо эрх чөлөө, жаргалант амьдралаа тэмцэн олсон Монгол орны эрт, эдүгээ, ирээдүйг хөгжмийн хэлээр дүрсэлжээ.

Энэ симфони уламжлалт 4 ангитай, анги болгоны хурд, хүч, хөгжүүлэг, хэлбэр нь сонгодог симфонийн зүй тогтлоор бүтээгдсэн юм. Л.Мөрдорж монгол ардын дуу “Гоолингоо”, “Цомбон туурайтай хүрэн” болон хувьсгалын дуу “Магнаг үсэгтэй туг”, “Агаараар нисдэг аэроплан” зэргийг агуулгын хувьд нэгтгэн симфонийхоо гол сэдэв болгон хөгжүүлсэн байдаг.



- Хөгжмийн зохиолч “Миний эх орон” симфонийхоо сэдэв аялгууг монгол ардын дуугаар хэрхэн бүрдүүлж, үндэсний сэтгэлгээнд тулгуурласныг сонсоцгооё. Сонсохдоо аялгууны онцлог, өнгө будаг, хүчний эрс өөрчлөлт тус бүрд Яагаад? гэсэн асуулт тавьж сонсоорой.

I анги. Хувьсгалын өмнөх Монголын ард түмний гаслант амьдрал, эрх чөлөөнийхөө төлөө хийсэн шударга тэмцлийг дүрслэн харуулсан байдаг.



II анги. Эрх чөлөөгөө олж авсан ард түмний жаргалант амьдралыг “Цомбон туурайтай хүрэн” дууны тайван, чөлөөтэй, удаан, уянгалаг аялгуугаар дүрсэлдэг.



III анги. Эрх чөлөөгөө олж авсан ард олон уламжлалт баяр наадмаа хийн баясан цэнгэж буйг симфонийн уламжлалт “Скерцо” хэмээх цоглог сэргэлэн хөгжмөөр дүрслэн харуулдаг.



IV анги. Шинэ нийгмийг бүтээн байгуулж буй ард түмнийхээ хүсэл тэмүүлэл, гэрэлт ирээдүйг сүр жавхлантай илэрхийлнэ.



Дан хөгжмийн төрөл зүйл дотор симфони найраглал чухал байр эзэлдэг. Симфони найраглал нь тодорхой үйл явдал, уянгын болон гүн утга санааг илэрхийлсэн хөтөлбөрт хөгжим юм.

Ц.Нацагдорж

“Өргөөний баяр наадам” симфони найраглал



- Ноот бичлэгийг анхааралтай ажиглаад, хөгжмөө сонсоорой.
- Эрийн гурван наадмын төрлүүдийг хөгжимд хэрхэн дүрсэлсэн байна вэ?
- Хөгжмийн зохиолын зэмсэгжүүлэлтийг зураглалтай холбон ярилцаарай.



Гуулин үлээврийн сүрлэг дуугаралттай уриа дуудлагын хөгжим



Морин хуурын татлага, бий биелгээний шинж төрхтэй хөг аялгуугаар Монгол бөхийн хийморь, бөхийн сүр жавхаалаг дэвээ шавааг дүрсэлнэ.

Хүндэтгэлтэй



Шандаст хурдан хүлгийн төвөргөөн, хүүхдийн гийнгоо, уртын дууны шинжтэй аялгуу, уухай маягтай түрлэг

Хурдан



Эрхий мэргэн харваачдын уухайн түрлэг.




"Монголын сайхан орон" симфони чуулбар

Хөгжмийн зохиолч Э.Чойдогийн "Монголын сайхан орон" симфони чуулбар нь ардын дууны хөг аялгыг симфони найрал хөгжмийн эгшиглэлтээр хөгжүүлэн баяжуулж хангай, говь, уул тал, хүн ардын эрх чөлөөт жаргалант амьдралыг бахдал дүүрэн магтан дуулсан эх орны сэдэвтэй хөтөлбөрт хөгжим юм.

Энэ зохиолын аялгуу бүр нь монгол ардын дуу, бий биелгээ, морин хуурын татлагатай салшгүй холбоотой юм.



Тухайлбал дараах сэдэв аялгуунд монгол хүний сэтгэлд шингэсэн хөг эгшиг флейт, гобой, чавхдаст хөгжмийн зэмсгүүдээр дамжин монгол орны үзэсгэлэнт байгаль, ард түмний бахдам түүхийг өгүүлэх мэт хүндэтгэлтэйгээр эгшиглэнэ.



Харин хурдан бөгөөд хөнгөн цоглог бүжгийн шинжтэй дараах аялгуунаас монголчуудын ахуй амьдралын хэмнэл, хөгжил хөдөлгөөнийг олж сонсож болно. Энэ сэдэв аялгууг бишгүүр болон чавхдаст хөгжмийн зэмсгүүдэд оноожээ.



Хүний сэтгэлийн уянга, мөрөөсөл, үзэсгэлэнт байгалийн зураглалыг уртын дууны уран нугалаа чимэглэл бүхий аялгуугаар дүрсэлжээ.



- "Монголын сайхан орон" симфони чуулбарыг сонсоод ямар сэтгэгдэл төрсөн бэ?



- Э.Чойдогийн энэхүү бүтээл 1961 онд ардын хувьсгалын 40 жилийн ойгоор Монгол, Германы уран бүтээлчдийн хамтран бүтээсэн "Монголын сайхан орон" баримтат киноны хөгжим юм. Кинонд хөгжмийн гүйцэтгэх үүргийн тухай ярилцаарай.

Чуулбар хөгжим. Хоорондоо ялгаатай биеэ даасан аязуудыг нэг ерөнхий утга санаанд нэгтгэсэн олон ангит зохиолыг чуулбар зохиол гэнэ. Жишээлбэл: Монгол бүжгийн чуулбар зохиол нь олон үндэстний ардын бүжгийн аязуудыг нэгтгэсэн байдаг.

Э.Чойдогийн "Баруун монгол" бүжгийн чуулбарт "бий"-ийн хэмнэл, хөг аялгууг баяжуулснаар "Цацал-бий", "Гөөлөө", "Жуураа гэлдэн", "Агсал", "Жудар" ... гэсэн цуваа аязууд нэгдэн чуулбарыг бүрдүүлж байна.

XVIII-XIX зуунд Баруун Европт бүжгийн чуулбар зохиол оргилдоо хүрч хөгжсөн. Австрийн хөгжмийн зохиолч И.Штраус "Цэнхэр Дунай" хэмээх вальс бүжгийн чуулбарыг туурвиснаар "Вальс хөгжмийн хаан" хэмээн дэлхий дахинаа өргөмжлөгджээ.



Б.Шарав
(1952)

Б.Шарав

2 дугаар симфони

Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн Б.Шаравын олон улс оронд тоглогдсон бүтээлүүдийн нэг бол 2 дугаар симфони юм. Энэ бүтээл 4 ангитай. Хөгжмийн зохиолч уг бүтээлдээ шашны хурал номын ая дан, унзад ламын уншлага, хөөмий, цуурын аргил хоолойн хүнгэнэлт, цамын бүжгийн хэмнэл, бөөгийн дуудлага, уртын дууны ая аялгууны онцлогийг илэрхийлжээ.

Симфонийн I анги хүндэтгэл ёслолын шинжтэй бүрэн дуудлага, их хэнгэргийн нүргээнээр эхэлнэ. Хэнгэрэг лугаа нүргэлэх литаврын гоцлол, бүрэн дуудлага, гуулин үлээврүүд, цохиур хөгжмүүдийн сүрлэг дуугаралтаар их эзэн Чингисийн үеийн монголын цэргийн их сүр хүчийг илтгэн харуулжээ.




Симфонийн гол сэдэв аялгуундаа уртын дууны хэв шинж, намба төрхийг шигтгэж өгсөн бөгөөд флейт, гобой, англи бишгүүрийн эгшиглэх дуурьсал шашны хурал номын ая данг санагдуулна.



Симфонийн II ангийн хөгжим бүжгийн шинжтэй бөгөөд хол үсрэлтүүдтэй аялгууны бүтэц, гуулин үлээврүүдийн хахир ширүүн дуугаралт нь эртний цохивор хөгжмийн зэмсгүүд, бүрээ, бишгүүрийн хамсраан дор баг өмсөн бүжиглэх цамын бүжгийг санагдуулдаг.



III ангийн хөгжимд бөөгийн дуудлагын ая аялга мэдрэгдэх бөгөөд үггүй найрал дууны төгсгөлд хэнгэргийн дуу гарч, араас нь бөөгийн үглэл дуудлага сонсогдоно.



Симфонийн IV ангид цэрэг дайны хөгжим, уртын дуу, шашны хурал номын ая дан бүгд сүлэлдэн орно. Энэ ангийн литаврын гоцлолд шашны хөгжмийн дамар хэмээх зэмсгийн онцлог хэмнэл орсон байх ба цан, там-там* нэмэгдэн орж ирнэ.



- Асуултыг анхааралтай уншаарай.
- Эдгээр асуултууд хоорондоо хэрхэн, ямар холбоо хамааралтай болохыг ярилцаад асуултад хариулаарай.

?

А. Монголын хөгжмийн зохиолчид Өрнө дахины хөгжмийн хамгийн боловсронгуй төрөл хэлбэр болох симфонид ардын уламжлалт дуу хуур, өвөрмөц хөг эгшиглэн бүхий хөгжмийн зэмсэг, ая аялгыг шигтгэж, үндэсний онцлогтой монгол симфони бий болгож хөгжүүлж ирсэн. Үүнд холбогдох хэний ямар ямар бүтээлийг мэдэх вэ?

?

Б. Монголын хөгжмийн урлагт гарсан томоохон ололт болох симфонийн анхдагч хэмээгддэг, тэрээр анхны симфонидоо эрх чөлөө, жаргалант амьдралаа тэмцэн олсон ард түмэн, монгол орны эрт, эдүгээ, ирээдүйг зохиолынхоо IV ангид хөгжмийн хэлээр тусгажээ. Энд хэний, ямар бүтээлийн тухай өгүүлж байна вэ?

?

В. Монголын хөгжмийн зохиолчид симфони хөгжмийн олон төрөл зүйлээр бүтээлээ туурвиж, монгол симфонийг агуулга, хэлбэрийн хувьд баяжуулан хөгжүүлж иржээ. Симфони хөгжмийн янз бүрийн төрөл зүйлээр бичигдсэн монголын хөгжмийн зохиолчдын бүтээлүүдээс нэрлэнэ үү. Жишээ нь: Ц.Нацагдорж “Өргөөний баяр наадам” симфони найраглал гэх мэт.

*там-там -шашны ёслолын үед хэрэглэгдэж байсан өмнөд азиас гаралтай эртний цохиур хөгжмийн зэмсэг. 60-150 см диаметртэй, 8-10 мм-ийн өргөнтэй төмрийн хайлшаар хийдэг энэ зэмсгийн дугаралт там хонхыг санагдуулах ба XVIII зууны сүүл үест найрал хөгжимд хэрэглэх болжээ. Хөгжмийн зохиолчид энэ зэмсгийг үхэл, аюул гамшиг, зөгнөл, шидэт ертөнц зэргийг дүрслэхдээ голлон ашигладаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БҮЖГЭН ЖҮЖИГ

Бүжгэн жүжгийн үүсэл, хөгжил

Бүжиг нь хүмүүсийн ахуй амьдралтай салшгүй холбоотой үүсч хөгжсөн хөдөлгөөний урлаг юм. Хүн төрөлхтөн буй болсон цагаасаа эхлэн амьдрахын тулд байнга хөдөлж, хөдөлмөрлөж, тэр нь бие бялдар, оюун ухааныг нь хөгжүүлэх чухал хөшүүрэг болж ирсэн билээ. Ийнхүү хөдөлмөрийн хэмнэл нь баяр хөөр, гуниг гутрал зэрэг сэтгэл хөдлөлийн олон өнгө аясаар хөглөгдөх болсноор бүжиг болон хөгжих зам руугаа оржээ.

Харин бүжиг, бүжгэн жүжиг болон хэлбэрших явц нь дундад зууны эхээр сонгодог хэлбэрээ олсон багт наадам, шашны сэдэвт тоглолтууд сэргэн мандалтын үеийн ордны бүжиг мөн ардын бүжгийн хөдөлгөөнөөр дамжин түүхийн урт замыг туулсаар XVIII зууны сүүлч XIX зууны эхээр сонгодог хэлбэрээ олсон байна.

Аялгууг олон янзаар хувилбарлан баяжуулах бүжгийн хөгжмийн чуулбар нь бүжгийн хөдөлгөөн, зан төрхийг тусгасан бяцхан бүжгэн зохиомжууд бий болоход нөлөөлж үүнийгээ "Балет" хэмээн нэрлэх болжээ. Ballet нь "би бүжиглэж байна" гэсэн латин үгнээс гаралтай.

"Орчин үеийн балетын эцэг" хэмээн өргөмжлөгдөн нэр алдар нь сонгодог бүжгийн түүхэнд мөнхөрсөн хүн бол францын нэрт бүжиг дэглээч Ж.Новерр юм. Ийнхүү бүжгэн жүжиг нь хөгжмийн театрын бие даасан төрөл болон бусад урлагтай эн зэрэгцэн хөгжсөөр гурван зууныг элээгээд байна.

Сонгодог бүжгийн урлаг нь хүний сэтгэлийн ертөнцийг уран хөдөлгөөн, тодорхой дохио зангаа, хөгжмийн хөг аялгуу, хэм хэмжээ, дүрслэх урлагийн өнгө будгийн тохироо зэргээр илэрхийлдгээрээ урлагийн олон салбарыг нэгтгэсэн нийлмэл төрөл болдог. Бүжгэн жүжгийг зохиолч, хөгжмийн зохиолч, бүжиг дэглээч, зураач, хөгжмийн удирдаач, бүжигчид хамтарч бүтээдэг.

Сонгодог бүжиг олон төрөлтэй.



Бүжиг, хөгжмийн нийлэмжээр дүрслэл, утга агуулгаа илэрхийлж байдаг театрын урлагийн нэг төрлийг бүжгэн жүжиг гэдэг.



П.И. Чайковский
(1840-1893)

П.И. Чайковский

“Цөмөөхэй” бүжгэн жүжиг

Оросын суут хөгжмийн зохиолч П.И. Чайковский “Хунт нуур”, “Нойрсож буй гүнж”, “Цөмөөхэй” зэрэг бүжгэн жүжгүүд бичжээ. “Цөмөөхэй” бүжгэн жүжиг нь 1892 онд анх Петербургт тавигдсан 2 бүлэг, 3 үзэгдэлтэй, хүүхдэд зориулсан дэлхийн хамгийн алдартай бүтээл юм.

Энэ бүжгэн жүжгийн I үзэгдлийн цасан ширхэгүүдийн бүжиг, II үзэгдлийн Дивертисмент (бүжгийн чуулбар амттангуудын бүжиг), цэцэгсийн вальс, адажио гээд олон алдартай хэсгүүдийг сонсогчид андахгүй. Аялгууны баялаг илэрхийлэлтэй цэцэгсийн вальс нь дивертисментийн оргил болон эгшиглэдэг.



• Хөгжим сонсох үедээ ноотоо ажиглаж, тохирох хэсэг эхлэхэд дагаж аялаарай.



• Аялгуунд тохируулан өөрсдийн мэдрэмжээр хөдөлгөөн зохиож бүжиглээрэй.

Вальс



“Цөмөөхэй” бүжгэн жүжгийн II бүлгийн дивертисмент “Амттаны оронд” гэсэн нэртэй. Испани-шоколад, Араб-кофе, Хятад-цай, Орос-хатуу чихэр, Малчдын бүжиг-бяслагийг төлөөлнө.



Испани бүжиг



Араб бүжиг



Хятад бүжиг



Орос бүжиг

Дивертисмент - Балет болоод дуурьт агуулга, сэдэвтэй нь уялдуулан нэмж оруулсан хэд хэдэн өөр үзүүлбэрүүдээс бүрдсэн балетын хэсэг.



Малчдын бүжиг



- Испани, Араб, Орос бүжгийн хөгжмийг сонсоод аялгууны шинж төрх, хөгжмийн зэмсгийн сонголт, хэмнэл, хурдыг хооронд нь харьцуулан ярилцаарай.
- Хөгжмөө анхааралтай сонсоод, дараах түлхүүр үгсийг ашиглан хүснэгтийг дэвтэртээ нөхөж бичнэ үү?

Уян налархай, гялалзсан цоглог, хөгжилтэй сэргэлэн, кастаньет, чавхдаст хөгжим, шагшуур, бөмбөр, дуут мод, мольто виваче, модерато, аллегро, тэгш хэмнэлтэй, синкоптой, цэгтэй ноот

	Испани бүжиг	Араб бүжиг	Орос бүжиг
Шинж төрх			
Хөгжмийн зэмсгийн сонголт			
Хэмнэл			
Хурд			



- Зургуудыг ажиглаад, эдгээр зургаас санаа авч бүжиг дэглэе.
- Өөрийн сонирхдог бүжгийн төрлөө сонгоорой.
- Бүжгийнхээ онцлогт тохирох хөгжмийн аялгууг олж сонгоно.
- Бүжгийн хөдөлгөөн нь хөгжмийн аялгуу, хэмнэлтэйгээ нийцэж байх ёстой гэдгийг санаарай.
- Хөгжмөө анхааралтай сонсож сэтгэл хөдлөлөө илэрхийлэхдээ гар, хөл, толгой, биеийн хөдөлгөөнийг зохицуулан бүжиглээрэй.






С.Прокофьев
(1891-1953)

С.Прокофьев

“Ромео Жульетта хоёр” бүжгэн жүжиг

Оросын хөгжмийн зохиолч С.Прокофьев 1936 онд бичсэн 4 бүлэг, 9 үзэгдэлт энэ бүтээлдээ дундад зууны үеийн бурангуй амьдралын тухай У.Шекспирийн эмгэнэлт жүжгийн үндсэн зөрчлийг хөгжмийн хэлээр тод томруунаар харуулсан байна. Гэр бүлийн хоорондын удам дамжсан ургийн дайсангал нь залуу хосын гэгээлэг хайр, эмгэнэл гунигийн шалтгаан болсон ажээ.

Бүжгэн жүжигт хоорондоо ялгарамжтай зан төлөв, дүр дүрслэлийн эрс өөрчлөлт бүхий гол баатруудын аялгуун тодорхойлолтууд хөгжмийн өвөрмөц хөг дуурьслаар эгшиглэдэг. Үүгээрээ хөгжмийн зохиолч бүжгэн жүжгийн урлагт шинэчлэл хийжээ. Жишээлбэл Жульетта охины хөргийг зурагласан хэсэгт түүний гэнэн томоогүй, дүрсгүй боловч эрхэмсэг, уян дөлгөөн, мөрөөдөмтгий зэрэг олон шинжүүд илэрдэг. Энэ хэсэг зохиолын II үзэгдлийн гол цөм болох ба рондо хэлбэрт бичигдсэн байдаг.



A

Давтал хэсэг: Цовоо сэргэлэн Жульетта охины гэнэн томоогүй зан төрх.



B

I тусгаар хэсэгт Жульетта охины эрхэмсэг, уян дөлгөөхөн дүр төрх.



C

II тусгаар хэсэгт Жульетта охины мөрөөдөмтгий, бодлогошронгуй дүр байдал.



Монгол бүжгэн жүжиг

Монгол оронд 1940 оноос мэргэжлийн урлагийн байгууллага үүссэнээр Монголын үзэгчид олон үндэстний бүжиг, сонгодог бүжгийн урлагтай танилцах боломж бүрджээ. 1953 онд Ц.Раднаагийн дэглэлтээр хөгжмийн зохиолч Г.Жамъянгийн бичсэн “Манай нэгдлийнхэн” бүжгийн чуулбар, 1958 онд Д.Лхасүрэнгийн дэглэсэн С.Гончигсумлаагийн “Ганхуяг” бүжгэн жүжиг тавигдсан нь Монголын хөгжмийн театрын хөгжилд онцгой нөлөө үзүүлсэн юм.

1956 онд Б.Асафьевын “Бахчисарайн оргилолт булаг” бүжгэн жүжгийг Оросын бүжиг дэглээч А.В.Хабаева найруулан тавьсан нь Монголын тайзнаа тавигдсан сонгодог бүжгэн жүжгийн анхдагч нь байлаа. 1962 онд Монголын анхны мэргэжлийн бүжигчид Орос улсад сонгодог бүжгийн сургууль төгсөж ирснээр Монголын хөрсөнд бүжгийн урлаг хөгжих таатай нөхцөл бүрдэв.

Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн хөгжмийн зохиолч Э.Чойдог “Шарилжин дундах цэцэг”, “Мөнгөн залаа”, “Хөгжмийн эгшиг” зэрэг бүжгэн жүжгээрээ Монголын үндэстний бүжгэн жүжгийг төрөл, хэлбэр, сэдвийн хувьд өргөжүүлжээ. Харин хөгжмийн зохиолч З.Хангал “Эрдэнэсийн уулс” бүжгэн жүжгээрээ энэ төрлийн хөгжмийн хэл дуурьслыг шинэчлэн хөгжлийн шинэ төвшинд гаргасан байна.

УДБЭТ үндэстний болон дэлхийн сонгодог 50 шахам бүжгэн жүжгээр урын сангаа баяжуулж Ардын жүжигчин, Төрийн шагналт Б.Жамъяндагва, Ардын жүжигчин Ю.Оюун, О.Ганбаатар, гавьяат жүжигчин Н.Баатар, Т.Туул зэрэг алдартнуудыг төрүүлсэн түүхэн замналтай.



Э.Чойдог
(1926-1988)

Э.Чойдог

“Шарилжин дундах цэцэг” бүжгэн жүжиг

Домгийн сэдвээр бичигдсэн 1 бүлэг, 3 үзэгдэлт бүжгэн жүжиг. Бүжгэн жүжгийн хөгжмийн бичлэг, хөг аялгууны дүрслэл нь үйл явдал, утга санааг баяжуулж дүрүүдийн зан чанар, намба аясад нийцэн тохирсон байдаг.

Урангоо бүсгүйд хайр сэтгэлтэй болсон хоёр баатар хоорондоо тулалдаж, бүсгүйн хайрт залуу Галт амь үрэгдэж, цэргийн захирагч Ширүүнгарьд үйлдсэн хэрэгтээ гэмшин өөрийгөө хөнөөсөн тухай энэ бүжгэн жүжигт өгүүлжээ.



- Бүжгэн жүжгийн "Шарилжин дундах цэцэг" нэрийн утгыг агуулгатай холбон таамаглал дэвшүүлж ярилцаарай.
- Хөгжмийн хэсэг тус бүрийг сонсоод аялгууны шинж төрх, хэмнэл, өнгө аясыг зураглалаар илэрхийлээрэй.



Andantino

1

2

Ж.Чулуун

“Уран Хас” бүжгэн жүжиг



Ж.Чулуун
(1928-1996)

"Уран хас" бүжгэн жүжгийн хөгжмийг Ж.Чулуун, цомнолыг Б.Ширэндэв бичиж, Б.Жамъяндагва найруулан тавьжээ. Үлгэр домгийн сэдэвтэй энэ бүжгэн жүжиг нь гурван бүлэг, таван үзэгдэлтэй.

Уран гарт дархан Хас хэт мухар сүсэгт автсан лам нарыг хашраахын тулд өөрийн зохион бүтээсэн оньсон тоглоомуудыг ашигладаг. Эцэст нь тэрхүү оньсон тоглоомуудынхаа зарчмаар 12 жилийн амьтдыг дүрсэлсэн эрдэнийн цаг урлан, нутгийн ард олныхоо бахархлыг төрүүлж “Уран Хас” хэмээн алдаршдаг.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Ноотоо хараад дагаад аялаарай.
- Аялгууны шинж төрхийг тайлбарлан ярилцаарай.

Бүжгэн жүжиг нь дуурийн нэгэн адил удиртгал хөгжимтэй байдаг.

"Уран Хас" бүжгэн жүжгийн удиртгал хөгжим нь цог жавхаалаг, өөдрөг сэтгэлээр хөглөгдсөн яруу тансаг аялгуутай. Энэ уур амьсгалыг бүрдүүлэхэд тойронцол (рондо) хэлбэр, гэрэл гэгээлэг мажорын хөг эгшиглэгээ гол хэрэглүүр болж өгнө.



Вальс хэмнэлтэй II сэдэв нь аз жаргалаар дүүрэн сайн сайхан амьдралдаа сэтгэл хангалуун байгаа сэтгэгдлийг төрүүлдэг. Бие даасан концертын хэсэг болж олны таашаалд нийцсэн энэхүү вальс нь "Уран Хас" бүжгэн жүжгийн тансаг аялгууны сор, дээжис нь юм.



"Уран Хас" бүжгэн жүжигт нэгэн сайхан аялгуу бий. Энэ бол Хас, Хандармаа хоёрын адажио юм.



- Бүжгэн жүжиг үзэж, хөгжмийг нь сонсонгоо эргэцүүлэн бодох нь сонирхолтой ажил.



- Легато, Нонлегато, Стакатто-д ямар хөдөлгөөнүүд тохирох вэ?
- Тэдгээр хөдөлгөөнүүдээ хийгээд үз. Олон янзаар үсэр. Үсрэх хичээн хувилбар гарч байна вэ? Чи өөрийгөө бүжигчин гэж бодоорой.
- Бүжгэн жүжгээс бүжигчдийн гүйцэтгэж байгаа олон янзын хөдөлгөөн үсрэлтүүдийг тэмдэглээд хийгээрэй.
- Түүнчлэн эерэг, сөрөг дүрийн зан араншинг ямар хөдөлгөөнөөр илэрхийлдгийг мэдэж аваарай.

Сонголын сорил

П.И.Чайковский. “Хунт нуур” бүжгэн жүжгийн Бяцхан хунгуудын бүжиг

1877 онд Оросын Их театр анх тавигдсанаас хойш дэлхийн сор болсон сонгодог бүжгэн жүжгүүдийн нэгд тооцогдох болсон. Энэхүү бүжгэн жүжгийн сонирхолтой хэсгийн нэг бол “Бяцхан хунгуудын бүжиг”.



- “Хунт нуур” бүжгэн жүжгийн “Бяцхан хунгуудын бүжиг”-т П.И.Чайковский уран илэрхийллийн ямар аргыг онцлон хэрэглэсэн бэ?
- Ноотыг ажиглаад стаккато болон легато-г хөгжмөөс ялган сонсоорой.

Ж.Верди. “Риголетто” дуурийн Герцогийн дуу

Хөгжмийн зохиолч 1850 онд Венецийн “Ла Фениче” театрын захиалгаар В.Гюгогийн “Хааны зугаа цэнгэл” зохиолоос сэдэвлэн энэхүү дууриа бичсэн бөгөөд 1852 оноос эхлэн дэлхийн олон театруудын тайзнаа тавигдсан.

1987 онд найруулагч Ё.Цэрэндолгор монголын дуурийн театрын тайзнаа найруулан тавьж Ардын жүжигчин Ж.Чулуун удирдаачаар ажилласан байна. Бидний сонсох энэ хэсэг нь цээл хоолойтнуудын урын санд хүндтэй байр эзэлдэг.



- Хөгжмөө сонсоод ноот бичлэгийг ажигла. Легато, стаккато хоёр тэмдэглэгээг зэрэг хэрэглэсэн тохиолдолд юу гэж нэрлэдэг болохыг толь бичгээс харж тодорхойлоорой.
- Ж.Верди. “Риголетто” дуурийн Герцогийн дууны дүр, дүрслэлийн талаар өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж бичээрэй.

Б.Дамдинсүрэн. “Хэнтийн өндөр ууланд” хийлийн гоцлол

Монголын дуурийн урлагийг үндэслэгч, нэрт хөгжмийн зохиолч маань хийл хөгжимд зориулсан энэхүү бүтээлээ 1947 онд туурвижээ.



- Ноот бичиглэлийг ажиглаад эхний 4 айзмын аялгууны хөдөлгөөнийг график зурлагаар илэрхийлээрэй. Зураглалдаа эгшгийн өндөр болон уртаашийг харгалзаарай.

Өөрийгөө сориорой



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Өгөгдсөн түлхүүр үг ашиглан тухайн үеийн онцлог, шинжийг тодорхойлж, эргэцүүлэмж бичнэ үү.

БАРОККО ҮЕ 1600-1750

И.С.Бах "Токката ба фуга"

Замбараагүй	Чуулбар	Клавесин	А.Вивальди
Хээ угалз	Магтуу	Босоо ятга	Г.Гендель
Чамин	Месса	Орган	И.С.Бах
Хачин сонин	Кончерто гроссо	Хийл	
Зохиох			

СОНГОДОГ ҮЕ 1750-1825

В.А.Моцарт "40 дүгээр симфони"

Энгийн	Сонат	Төгөлдөр хуур	И.Гайдн
Бодит	Симфони	Симфони найрал хөгжим	В.Моцарт
Уламжлал	Концерт	Чавхдаст хөгжмийн дөрвөл	Л.Бетховен
Зүй тогтол	Квартет		

РОМАНТИЗМЫН ҮЕ 1820-1900

П.И.Чайковский "Хунт нуур" бүжгэн жүжиг

Сэтгэл хөдлөл	Баллада	Эх оронч үзэл	Ф.Мендельсон
Адал явдал	Рапсоди	Хөтөлбөрт хөгжим	Ф.Шопен
Уран сэтгэмж	Хөтөлбөрт симфони	Яруу найргийн өнгө	Р.Шуман
Сонирхолтой	Романтик дуурь	Зан байдал	П.Чайковский
Ер бусын	Симфони зураглал		А.Дворжак
Сонин хачин	Ноктюрн		К.Дебюсси
			Б.Сметана

XX ЗУУНЫ ҮЕ 1900-оноос хойш

И.Стравинский "Галт шувуу" бүжгэн жүжиг

Туршилт	Поп	С.Жоплин
Технологи	Рок дуурь	А.Шёнберг
Шинжлэх ухаан	Жазз	Ч.Айвз
Холимог соёл	Блюз	М.Равель
Шинэ дуу		Б.Барток
		И.Стравинский
		С.Прокофьев

ДУУЛГЯ

Хүүхдүүд ээ! Амьдрал бол хөгжим гэдэгтэй та бүхэн санал нэгдэнэ гэж найдаж байна.



Ангийн найзууд

Үг. О.Сундуй

Ая. С.Батболд

Хөгжилтэй

Догд-лон догд-лон анги-даа и-рэ-хэд Дот-но' угт-сан ми-ний най-зууд

То-лон' наа-дан хи-чээ-лээ давта-хад То-хой' нийл-сэн ан-гийн най-зууд

Анги-даач сур-гууль-даач ар-га гүйл-ан-дууд Алд-рай нас-ны хөг-жилт-тэй най-зууд

Гэр-гээч га-даач и-жилд-сэн ан-дууд Гэ-гээл нас-ны үүр-дийн най-зууд

Хүсэл бодлын жигүүр дэлгээд
 Хөтлөлцөн гүйсэн хөөрхөн найзууд
 Нандин нууцаа найздаа задлаад
 Нар шиг мишээсэн үеийн найзууд
 Дахилт
 Алдаж гэндсэн андыгаа хайрлаад
 Ангиараа гэмшсэн миний найзууд
 Амжилт бүхэнд баярлаж хөөрөөд
 Алгаа ташсан ангийн хүүхдүүд
 Дахилт



- Ноот бичлэгийн аль хэсэгт хэмнэл давтагдаж байна вэ?
- Дуу ямар хөгд бичигдсэн болохыг тодорхойлоорой.
- Багшийн тусламжтайгаар өөрсдийн хоолойн цараанд тохируулан гитар хөгжмийн хамсраатай дуулаарай.





- Ноот бичлэгийг ажиглаад дуулах цагааг тодорхойлоорой. Энэ дуу ямар дэвсгэр хөгт дуулагдах вэ?
- Ноот бичлэгт тусгайлан тэмдэглэсэн хэсгийг нуман холбоостой болон холбоосгүй хоёр янзаар дуулаарай. Нуман холбоосын үүргийг ярилцаарай.



Үгийн нэг үеийг олон эгшиг дамжуулан дуулах нь хүндрэлтэй тул энэ хэсэгт анхаарна уу.



"Жаргалын зам" дуурийн Халиуны дуу

Ая. Б.Дамдинсүрэн

Цоглог

Зу - заан по - гооц ой - той Зу - раг ши - сай - хан - хан - гай бай - наа

Зуун - жал - дээ ит - гэл - тэй Жур - мын олон по - ход минь та - нар - бай - наа

А А А А Жур - мын о - лон нө - хөд минь

та - нар - бай - на та - нар - бай - на

Наран саран чимэгтэй
 Намуухан сайхан хангай байна
 Насны туршид үерхсэн
 Найз олон нөхөд минь
 Та нар байна
 Үүрийн цолмон шигтгээтэй
 Өндөр сайхан хангай байна
 Үүрд хамтран дассан
 Үеийн олон нөхөд минь
 Та нар байна

Эх үрийн дуу

Үг. А.Эрдэнэ-Очир

Ая. Ш.Өлзийбаяр

Andante


Хар-гуйн Ү-зүүр өв-дөл-зөөд ирэ-хээр Хав-рын шу-вуу-дын дуунд нь
 хүү-гээ сана-наа Хал-гин пэлэл-ээж уя-ран дуу-лах Хай-рын өн-гээр өс-сөн юм даа
 ми-ний хүү Дэл-гэр догж цэ-цэг-гээд алаг-ла-хаар Дэл-хийн чи-лээх айр-лах и-жий
 гээ бод - ноо Төл-мөн эг-рэг - лээ хол-дож ойр - тох Тэнгэ-рийн ха-яаг
 им-хэр - дээд хүүнь оч-ино оо Дүүр-гэн жар-гаана аа

CODA

Эх: Налгар өдрүүд салхилаад буцахлаар
 Намрын шувуудын дуунд нь хүүгээ санана аа
 Элгэн түмэн олныхоо дундаа
 Эрдмийн гэгээг түүж л яваа миний хүү

Үр: Цаасны үүлс цайраад наашлахаар
 Цагийн сэрүүнд хонгор ижийгээ бодно оо
 Хяруу цайрсан гүвээ толгодыг
 Халууцтал инээгээд хүү нь очно оо

Хамтдаа: Сартай тэнгэрийн эрхэс хэлхсэн
 Цагаан сүүний өргөлтэй хүний хорвоод
 Саруул дэлхийн нартай хоймрыг
 Бүүвэй дуугаараа дүүргэн жаргаана аа



- Дэвсгэр хөг, айзам хэмжээний өөрчлөлтийг ажиглаад тодорхойлоорой.
- Тавц, зургаац, наймцын үсрэлтүүд хэд дэх айзамд байна вэ? Эдгээр холын үсрэлтүүдийг дуулахдаа анхаараарай.



Дуу болоод удирдаачийн гарын хөдөлгөөн нь хоорондоо салшгүй холбоотой. Хөгжмийн элементүүд болох хэмнэл, аялгуу, хурд хүчний өөрчлөлт, хүчдэл, зааг хэсэг, дуулах арга барил нь удирдаачийн дохиогоор илэрхийлэгддэг. Үүний тулд найрал дуучид дуулах уран бүтээлийнхээ онцлог, утга санааг бүрэн ойлгож мэдрэх нь чухал байдаг. Дуулахдаа нуруу цэх, мөр өргөхгүй, тэнцвэртэй зогсох, хоолойг бэлтгэж дасгал дуулах, амьсгааг хамраараа зөөлөн авч зөв зарцуулна. Аялгууг ноотоор сурах, эгшиг үсгийг уртаар, гийгүүлэгч үсгийг богино, тод дуудах, өнгө цэвэр, хэмнэлийг зөв мэдэрч бусдыг сонсож, өөрийн дуулалтыг нийцүүлж сурах хэрэгтэй.



- Хөгжмөө сонсоод, хоёр хоолойгоор ноотоор дуулаарай.
- Дуулахдаа тэмдэг тэмдэглэгээг анхааралтай ажиглан, хувиргалын тэмдэгтэй ноотуудыг зөв цэвэр дуулаарай.



Хөгжим. Ф.Шуберт

Форель



Алаг морь
Монгол ардын дуу

Найруулга Ц.Түмэнбаяр

Andante


mf А - лаг - морь - минь ээ хө А - лаг - морь - минь ээ хө

5
Айл - ын - хад о - лон а - дуунд ү - гүй морь юм аа
mf Айл - ын - хад о - лон а - дуунд ү - гүй морь юм аа

8
хо ү - гүй морь юм аа хо хо
хо ү - гүй морь юм аа хо хо

Хар морь минь ээ хө
Хар морь минь ээ хө
Хавийнхаа олон адуунд
Үгүй морь юм аа хө

Хээр морь минь ээ хө
Хээр морь минь ээ хө
Хэнийхээ олон адуунд
Үгүй морь юм аа хө



Талын Жанцан
Монгол ардын дуу

Найруулга Ц.Түмэнбаяр

Andante sostenuto

1
2
3

mf Гал - ын Жан - цан тан - ы - гаа бол - гов

mf

5
Та - риа түү - сэн то - го - руу *mp* сан - жл сан - жл


Холын Жанцан
Таныгаа болгов
Хоолоо түүсэн
Тогоруу санж л

Нутгийн Жанцан
Таныгаа болгов
Нуураа тойрсон
Тогоруу санж л



- I, II хоолойн хэмнэлийг, дараа нь III хоолойн хэмнэлийг тогшиж үзээрэй. Ямар ялгаа байна вэ?
- IIIхоолойн хөдөлгөөнийг хүлээцтэй, гүйцэд сонсож байж дараагийн айзамд шилжээрэй. .

- Тусгайлан тэмдэглэсэн хэсэгт аялгууны чимэглэлийг богино, зөв, цэвэр хийж гүйцэтгэнэ.
- Монгол ардын богино дууны онцлогийг ярилцаарай.



Сурагчийн уянга

Үг. Б.Бүжинлхам

Ая. Б.Ганболд

Вальс

Ал-рай бяц-хан нас-аар- нь дуу-гаа чим-дэг Ал-тан гэгчээ хү-с-лээ
 7 мөрөөд-лөөр дүүр-гэ-дэг Ариун нан-дин сэт-гэл-лээ баг-шаа дурс-дэг
 13 А-мин зүр-хэнд уя-а-тай ми-ний су-рагч нас аа- А аа- аа-
 20 аа- Зүрхэнд зүү-дэндч уя-а-тай
 25 миний сурагч на-с минь

Мөнгөн хонхны дуугаар нь амьдралаа чимдэг
 Мөрөөдөл дүүрэн насаа эрдмээр дүүргэдэг
 Мөнхийн гэгээн сэтгэлдээ багшаа дурсдаг
 Мөнхөд зүрхэнд уяатай миний сурагч насаа
 Хүсэл мөрөөдлийн дуугаар нь итгэлээ чимдэг
 Хүндлэл хайрын сэтгэлээр дурсамжаа дүүргэдэг
 Үерхэл нөхөрлөлийн итгэлээ эрхэмлэн нандигнадаг
 Үүрд зүрхэнд уяатай миний сурагч насаа



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийн интервалыг тодорхойлоод, дуулахдаа эгшиг хоорондын харьцааг сонсоорой.



2

20

ба ра ба ра ба ра ба ба ра ба ба ба ра ба ба

ба ба

бам бам

26

ба ра ба ба ба ра ба ба

30

ба ба ба ра ба ба ба ра ба ба ба ба ба ба

ба ба ба ба ра ба ба ба ра ба ба ба ба ба ба ба

ба ба ба бам бам бам бам бам бам



- Ноот бичлэгээс хэмнэлийн ялгааг хараад тогшиж үзнэ үү.
- Үеийг богино, тод, цэвэр хэлж дуулаарай.
- Тохиолдлын тэмдгийг анхааралтай харж зөв дуулаарай.

ХӨГЖИМДЬЕ

Гитар хөгжмийн тухай

Гитар нь зургаан чавхдастай бөгөөд даруулт гар, бэлхүүс хэлбэрт дууны хайрцагтай.

XVI зууны үед Испанид үүссэн гэж үздэг.



1860 онд Испанийн гитар урлаач Антонио дэ Торрэс Хурадо гитарын дуугаралтыг чанга болгож, хийцийг нь өөрчилсөн. Түүнийг орчин цагийн сонгодог гитарын шинж чанарыг тодорхойлсон гэж үздэг. Эдүгээ ихэнх гитарыг түүний хийцээр үйлдвэрлэдэг.



1920-иод онд акустик гитарт цахилгаан чангаруулагчийг хийх болжээ.



1931 онд Жорж Бошам ба Адольф Рикенбекер анхны цахилгаан гитарыг бүтээжээ.



Гитар сурахад зөв суух нь чухал.



Гитарын чавхдасыг хуруугаар татахаас гадна цохиураар тоглоно. Цохиурыг ихэвчлэн хуванцраар, гурвалжин хэлбэртэй хийдэг байна. Цохиурыг эрхий, долоовор хуруугаар барина.




Гитарын сул чавхдас дээр цохиураар дээшээ, доошоо цохих дасгалыг удаанаас эхлэн аажмаар хурдан хийж сураарай.

Цохилтын чиглэлийг II-доошоо, V- дээшээ гэж тэмдэглэхээс гадна чиглэл заасан сумаар тэмдэглэдэг байна.




Дасгалыг тоглохдоо удаанаас эхлэн аажмаар хурдаа нэмээрэй.




Гитарын чавхдасыг хамгийн нарийн өнгөнөөс эхлэн дугаарлаж хөглөнө. Ноотон дээрх тэмдэглэгээнээс нэг наймцаар доор эгшиглэнэ.

Гитарын чавхдасыг даралгүй (сул) тоглохыг (o) дүрсээр тэмдэглэнэ.



Гитар хөгжмөөр тоглох үед баруун гарын хурууг үсгээр нэрлэн тэмдэглэж, зүүн гарын хурууг тоогоор дугаарлана.



	0	I	II	III	IV	V	VI	VII
Ми	до	до#	ре	ре#	ми	фа	фа#	
Си	соль#	ля	ля#	си	до	до#	ре	
Соль	ре#	ми	фа	фа#	соль	соль#	ля	
Ре	ля#	си	до	до#	ре	ре#	ми	
Ля	фа	фа#	соль	соль#	ля	ля#	си	
Ми								

TAB-Tabulatur нь гитарын даралтыг тэмдэглэдэг код юм. Зургаан шугам нь гитарын зургаан чавхдасыг, шугаман дээрх цифр нь лад буюу үеийг илэрхийлнэ. Хамгийн доод талын шугамнаас 6, 5, 4 гэж тоолно. Тухайлбал: V чавхдасны III үед I октавын До ноот байрлана.





- Дараах дасгалын ноотыг анхааралтай ажиглаад, доод талын шугам буюу TAB дээр эгшгийг зөв тэмдэглэнэ үү?
- Ямар онцлогтой дасгал болохыг тайлбарлан ярилцаад хөгжимдөөрэй.

Хөгжимдөх дасгал



- Эдгээр дасгалууд нь баруун, зүүн гарын үйл ажиллагааны эвсэл, нийцлийг сайжруулах зорилготой бөгөөд хуруугаа хянаж сурахад тань тусална.
- Өнгө бүрээ зөв, цэвэр дуугаргаж сурсны дараа хурдаа нэмж тоглоно.
- Баруун гарын цохилтыг тэгшхэн, дээшээ-доошоо гэсэн дарааллаар хийнэ.
- Дараах дасгалуудыг гитарын бүх чавхдас дээр давтаж тоглоорой.



Гитарын чавхдас ба эгшгүүд

Гитарын чавхдас бүрийн эхний гурван үед байрлах эгшгүүдтэй танилцаж, гитар хөгжим дээр тоглож сураарай.


I чавхдас

E	F	G
I чавхдас сул	I чавхдас I үе	I чавхдас III үе




Musical notation (treble clef, 4/4 time):
 4/4
 TAB: 0 0 1 1 3 1 0 | 0 1 3 | 3 1 0 1 | 0


II чавхдас




III чавхдас



IV чавхдас




V чавхдас



Musical notation for the V chord in 4/4 time. The top staff shows a melody of quarter notes: G4, A4, B4, C5, B4, A4, G4. The bottom staff shows the guitar tablature: 0 0 0 2 2 2 | 3 2 3 | 3 3 3 3 2 2 2 2 | 0 2 0.

VI чавхдас



Musical notation for the VI chord in 4/4 time. The top staff shows a melody of quarter notes: G4, A4, B4, C5, B4, A4, G4. The bottom staff shows the guitar tablature: 0 1 3 | 3 1 0 | 0 0 1 1 3 3 0 0 | 3 3 1 1 0.

Англи ардын дуу

Мерригийн хурга

Musical notation for the first system of 'Merri's Song' in 4/4 time. The top staff shows a melody of quarter notes: G4, A4, B4, C5, B4, A4, G4. The bottom staff shows the guitar tablature with dashes: - - - -.

Musical notation for the second system of 'Merri's Song' in 4/4 time. The top staff shows a melody of quarter notes: G4, A4, B4, C5, B4, A4, G4. The bottom staff shows the guitar tablature with dashes: - - - -.



- ТАВ дээр ноотоо тэмдэглээрэй.
- Зөв бичсэн эсэхээ хөгжимдөж шалгаарай.



- Найзынхаа төрсөн өдрөөр гитар хөгжмөөр баярын дуу тоглож бэлэг бариарай.

Англи ардын дуу

Төрсөн өдрийн дуу

3/4

C G C

F C C

TAB



- Хүүхдүүд ээ. Та нарын сайн мэдэх дууны ноот өгөгдсөн байна.
- Дууны эхлэлийг цааш үргэлжлүүлэн бичээрэй. Үүний тулд доор өгөгдсөн ноотуудаас тохирохыг сонгож бичнэ үү.
- TAB -руу шилжүүлэн бичээд хөгжимдөөрэй.

Франц ардын дуу

Twinkle, twinkle little star

4/4

6

10

Twin - kle, twin - kle, lit - tle star, How I won - der what you are Up a - bove the world so high, Like a dia - mond in the sky Twin - kle, twin - kle, lit - tle star, How I won - der what you are



- Гитарын чавхдас тус бүр дээр байрлах ноотыг анхааралтай ажиглаад зүй тогтлыг тодорхойлж, тайлбарлана уу? Жишээ нь: мифа, си-до эгшгийн байршил....
- Чавхдас тус бүр дээр ноот бичигдээгүй хэсэгт ямар ноот байж болох талаар ярилцаад дэвтэртээ гүйцээж тэмдэглэнэ үү?
- II чавхдасны II үе, IV чавхдасны IV үе дээр байгаа хоёр эгшгийг оролцуулан дасгал зохиож хөгжимдөөрэй.

үе →

← чавхдас		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	e ¹	f ¹		g ¹		a ¹		b ¹	c ²		d ²		e ²
	b	c ¹		d ¹		e ¹	f ¹		g ¹		a ¹		b ¹
	g		a		b	c ¹		d ¹		e ¹	f ¹		g ¹
	d		e	f		g		a		b	c ¹		d ¹
	A		B	c		d		e	f		g		a
E	F		G		A		B	c		d		e	
			•		•		•		•			••	

Хөгжим. Ж.Бизе

“Кармен” дуурийн Хабанера



- Ноотоо харж хэмнэлийг тоглоорой.
- Өнгөөр тэмдэглэсэн ноотнууд гитар хөгжим дээр хаана байрлахыг тодорхойлоорой.
- Ноот тус бүр дээр цохилтын тэмдэглэгээг бичээд хөгжимдөөрэй.

Хонхны дуу



- Дөрвөлөөр хамтран хөгжимдөөрэй.

Allegro

Гитар 1

Гитар 2

Гитар 3

Гитар 4

tremolo

9

tremolo

18

2

26

31



- Хөгжимдөх ноотоо сайн ажиглаарай. Давтагдаж байгаа хэсгүүд байна уу?
- Өнгөөр ялгасан хэсгүүдийг анхааралтай ажиглаарай.
- Өөрийн хөгжимдөх хэсгийн ноотыг дэвтэртээ бичээд, гитарын ТАВ руу шилжүүлээрэй.
- Ноотон дээрх хөгжмийн тэмдэг тэмдэглэгээнүүдийг өөрийн ойлголтоор дэвтэртээ тайлбарлаж бичээрэй. Хөгжимдөх үедээ тэмдэглэгээг анхаарна уу.

Нэршил	диез	тремоло	арпеджио	фермато
Хөгжмийн тэмдэглэгээ				
Тэмдэг тэмдэглэгээний хөгжимд гүйцэтгэх үүрэг				

САНАМЖ:

- Өөрийн тоглох аялгууг ганцаарчлан сайн давтаарай.
- Бүгдээрээ хамт хөгжимдөх үедээ багшийн гарын дохиог сайн ажиглаарай.
- Гитараар хамтран хөгжимдөх үеийн дүрэм зохиож, бусдынхаа санаа бодлыг сонсон хэлэлцээрэй.
- Гитараар хөгжимдөх дүрмээ сайн мөрдөөрэй.



Баярын уянга

(Гитар, бишгүүр хөгжмийн хоршил)



Maestoso cantabile

6

12

18

mf ——— *f*

Тоглолтын цаг



- Өөрсдийн эзэмшсэн ур чадвар, сурч мэдсэнээ тайлагнан сурсан дуу, хөгжмөөр тоглолт зохион байгуулцгаая.
- Өөрийн мэдрэмжээ нээлттэй илэрхийлэхийг хичээгээрэй. Эхний удаа санаснаар чинь болж өгөхгүй байвал бууж өгөх хэрэггүй. Зоригтой оролдоод үзээрэй.

Тоглолт зохион байгуулах төлөвлөгөө



1. Зорилгоо тодорхойлно.



2. Хөтөлбөрөө гаргана.



3. Ямар дуу, хөгжим сонгохоо тогтоно.



7. Концертоо тоглоно.

Тоглолтын нэр:
.....



6. Тайзаа засч, бэлтгэнэ.



5. Дуулж, хөгжимдөж бэлтгэл сургуулилт хийнэ.



4. Тоглогдох номеруудаа найруулах, хөтөлгчийн үг бэлтгэнэ.

САНАМЖ:

Тайз заслыг хийхдээ үзэгч, сонсогчид дуу, хөгжмийг сонсонгоо түүний утга санааг төсөөлж, ойлгохоор чөлөөтэй уран сэтгэмжлэн зурж, санаагаа буулгавал илүү сонирхолтой байх болно. Хөгжмийн эгшгүүдийг уран зургийн өнгө будагтай аялгууг зураг дах төрөл бүрийн зураастай харьцуулж болно. Мөн, өнгө будгийн тусламжтайгаар янз бүрийн хөгжмийн зэмсгүүдийн дуугаралтыг харьцуулан зэмсэг тус бүрийн эгшиглэгээтэй ижил төстэй, таарч зохицох хээ угалз, чимэглэлийг зохион зурж болно.

IX АНГИ

БИД ЮУ
СУДЛАХ ВЭ?



ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОРЧИН ҮЕИЙН ХӨГЖМИЙН УРЛАГ

XX зууны хөгжмийн урлаг	70
К.Дебюсси “Сиринкс” флейт хөгжмийн гоцлол аяз.....	72
М.Равель “Болеро”.....	74
С.Рахманинов “Элегия”	76
И.Стравинский “Ариун хавар” бүжгэн жүжиг.....	77
А.Щёнберг “Пьеро саран”	79
К.Орф “Кармина Бурана” магтуу	81
Л.Бернстайн “Вестсайдын түүх” мюзикл	82
А.Шнитке “Доктор Иоханн Фаустын түүх” магтуу	84
А.Онеггер “Пасифик-231”	87
Орчин үеийн бүжгийн гарал үүсэл	89

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ХӨГЖИМ

Монголын орчин үеийн хөгжмийн үүсэл	91
Б.Шарав “Зуурдын орон” симфони чуулбар.....	92
С.Сансаргэрэлтэх “Эх дэлхийгээ аварцгаая” симфони уран сэтгэмж	93
Н.Жанцанноров “Монгол аялгуу”	94
Б.Мөнхболд “Шар тэнгисийн тарчлаан” жүжгийн хөгжим	95
Ш.Өлзийбаяр “Дөрөө” модерн бүжгэн жүжгийн хос тогорууны бүжиг	97
Х.Алтангэрэл “Төгсгөлгүй” танго бүжгэн жүжиг	98

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЭСТРАД ХӨГЖИМ

Орчин үеийн эстрад хөгжим.....	100
Монголын эстрад хөгжим	105

ДУУЛЪЯ 109

ХӨГЖИМДЬЕ 121

ХАВСРАЛТ 131

Мэдлэг сорих асуулга

136

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОРЧИН ҮЕИЙН ХӨГЖМИЙН УРЛАГ

XX зууны хөгжмийн урлаг

“Мэдээлэл технологийн өндөр хөгжлийн эрин үе” хэмээн тодорхойлогдсоор ирсэн XX зуун бол шинжлэх ухаан, техник технологийн салбарт хөгжил дэвшил авчирсны зэрэгцээ урлаг соёлын салбарт хувь хүний чөлөөт сэтгэлгээг эрхэмлэсэн шинэчлэлийн үе байв. Энэ шинэчлэлийн үйл явцад уран сайхны янз бүрийн чиглэл, урсгалууд шинээр төрсөн. Ялангуяа XX зуунаас хөгжмийн төрөл зүйл, хэллэг, хэлбэр зохиомж, бичлэгийн арга барилд эрс өөрчлөлт гарч “Шинэ хөгжим” гэсэн ойлголт, нэр томъёо бий болсон байна. Хөгжмийн хэллэгт гарсан хувьсал дуурьсал, хөг эгшиглэгээний уламжлалт тогтолцоог үндсээр нь өөрчилсөн билээ. “Урлаг бол хүний дотоод ертөнцийг нээн илрүүлэх ёстой” гэж XX зууны уран бүтээлчид үзэх болов.

Хэвшмэл загварт баригдалгүй чөлөөтэй урлан бүтээх бололцоо урлагийн ертөнцөд нээгдсэнээр урлагийн өөр, өөр тухайлбал, хөгжим-уран зураг, хөгжим-яруу найраг гэх мэт төрлүүд хоорондоо сүлэлдэн, бие биенээ баяжуулж, хөгжмийн төрөл, хэлбэр ч өөрчлөгдөн шинэчлэгдсэн юм.

Энэ зуунд пянз үйлдвэрлэж, соронзон бичлэг буюу магнитофон, аппарат, зурагт радио шинээр бүтээгдэн улмаар компьютер, дуу бичлэгийн студи бий болсон түүхтэй.



Зургийг ажиглаарай.

- Чиний бодлоор энэхүү зураг ямар санааг илэрхийлж байна вэ?
- Өгөгдсөн үгсийг уншаарай. Түлхүүр үгс ямар утгыг илэрхийлж байна вэ?
- Зураг болон түлхүүр үгсийн хооронд ямар холбоо хамаарал байна вэ?



Түлхүүр үгс:

Хөгжил, арга барил, нээлт, өөрчлөлт, ололт, эрх чөлөө, хялбар, сэтгэлгээ, эрэлт хэрэгцээ, шаардлага, эрэл хайгуул, багтаамж, хэлбэр хийц, уламжлал, шинэ санаа, зохиомж, төрөл зүйл

Аливаа хөгжил дэвшил гэдэг хүний цуцалтгүй эрэл хайгуул, чөлөөтэй бүтээн туурвих хөдөлмөрийн үр дүн байдаг.

Хөгжим бол янз бүрийн түүхэн цаг үеийн хөгжилтэй салшгүй холбоотой. Хөгжим нийгмийн түүхэн хөгжлийн явцад өөр өөр сэтгэлгээтэй, хэлбэр агуулгатай байжээ. Энэ нь хөгжмөөр ургуулан сэтгэх чадварыг, мөн хөгжмийн зэмсгийн дуурьсал сайжирснаар олон өнгийн зохицолдоог шаардсан хэрэг. Тиймээс тодорхой эрин үеийн уран бүтээлчид тухайн үеийнхээ сэтгэлгээг урлагийн хэл дээр буулгахын тулд уйгагүй эрэл хайгуул хийж, шинийг сэдсэнээр уран сайхны шинэ шинэ урсгал чиглэлүүд бий болжээ.



Дараах уран сайхны чиглэлүүдийг түүхэн үечлэлээр нь эрэмбэлнэ үү?

- Модерн урлагийн эрин үе;
- Сонгодог урлагийн эрин үе;
- Бароккогийн эрин үе;
- Романтик урлагийн эрин үе.

Хөгжмийн импрессионизм

Импрессионизм (impressionnisme) - “Сэтгэгдэл” гэсэн утга бүхий Франц үгнээс гаралтай, XIX зууны эцэс XX зууны эхээр өрнө дахины урлагт гарсан орчин үеийн уран сайхны урсгалуудын нэг юм. Дэлхийн урлаг, соёлын гол төв болсон Парис хотноо 1874 онд уран зургийн үзэсгэлэн нээгджээ. Үзэсгэлэнд нэрт зураач К.Моне “Сэтгэгдэл, Нар мандалт” гэдэг бүтээлээ тавьж үзүүлснээр “Импрессионизм” хэмээх энэ нэр томъёо анх үүссэн гэдэг.

Хөгжмийн импрессионизм нь Францын дүрслэх урлаг дахь импрессионизмын нөлөөн дор хөгжсөн бөгөөд Эрик Сати, Клод Дебюсси, Морис Равель нарын уран бүтээлд илүүтэй тусгалаа олжээ.

Импрессионистууд нарийн тансаг, илэрхийллийн арга хэрэглүүрүүд бүхий ямарваа нэгэн зөрчилгүй, сэтгэл зүйн тогтонги байдалтай зохиолуудыг туурвиж байлаа. Хөгжмийн төрөл зүйлийн хувьд симфони, төгөлдөр хуурын хүрээнд, голчлон байгалийн дүр зургийг илэрхийлсэн хөтөлбөрт бэсрэг аяз, чуулбар зохиолууд зонхилох болжээ. Мөн хөгжмийн зэмсгийн дуугаралтад ч өөрчлөлт орж, сонгодог симфони найрал хөгжмийн хэмжээ багасан, босоо ятга, флейт хөгжмийн зэмсгүүд импрессионизмын бэлгэ тэмдэг болжээ.



Клод Дебюсси
1862-1918

К.Дебюсси

“Сиринкс” флейт хөгжмийн гоцлол аяз

Байгалийн өнгө будаг, гэрлийн тусгалыг бүтээлдээ өвөрмөцөөр тусгасан импрессионист зураачдын нөлөөгөөр К.Дебюсси хөгжимд шинэ хэллэг, хэв маягийг бий болгосон юм. Тэрээр уран зурагт байдаг олон янзын өнгө будгийн хослолыг хөгжмийн авиа эгшгээр илэрхийлэхийг зорьсон.

“Бүх хөгжмийн зэмсгүүдээс хамгийн төгс нь флейт. Түүний уянгалаг яруу эгшиглэгээ нь уг зохиолын сэтгэхүйн нарийн хувирал, мэдрэмжийг бүрэн төгс гаргаж чадсан юм” гэж “Сиринкс” зохиолынхоо тухай бичсэн байдаг.

Грекийн эртний домогт Сиринкс хэмээх үзэсгэлэнт сайхан лусын дагина амьдарч байсан тухай өгүүлдэг. Тэнгэрийн бурхан Пан үзэсгэлэнт лусын дагинад дурлана. Гэвч дагина чин сэтгэлээсээ хайрладаг хүнтэй байв. Пан дагиныг хүчээр тогтоон барихыг завдаж Сиринксыг гартаа баттай барьж авсан гэж бодон нүдээ нээн хартал гарт нь хулс байхыг олж харна. Пан тэрхүү хулснаас гайхамшигтай сайхан, уянгалаг аялгуу гарахыг сонсоод ихэд гайхшрав. “Ямар ч байсан чи минийх болохдоо л болно” гээд тэрхүү аялгуут хулсан хөгжмөө үзэсгэлэнт дагиныхаа нэрээр Сиринкс гэж нэрлэхээр шийдсэн тухай өгүүлдэг.

К.Дебюсси энэхүү домгийн санааг уг аяздаа маш гүн гүнзгий сэтгэгдэл төрүүлэхээр дүрсэлсэн байдаг.

Энэ зохиол богинохон хэдий ч өгүүлэмж нь тод томруун, хөг цомнол, хэм хэмнэл, тембр, ая аялгуу, хүчдэл, тэрчлэн хөгжимчний амьсгаа, ур чадварыг ч нарийн тооцсон байдаг. Хэмнэлийн жигд тогтуун, тайван байдал нь энэ зохиолын утга санааг бүрэн илэрхийлэх бөгөөд уран зөгнөлийн ертөнцийг бүтээдэг. Пан бурхны сэтгэлийн нь угаас урсан гарах лимбэний ая эгшгээр дамжуулан К.Дебюсси газар дэлхийг адислан, агуу хайрыг мөнхлөн магтан дуулсан юм.




- К.Дебюссийн "Сиринкс", "Сарны гэрэл" зохиолуудыг харьцуулан анхааралтай сонсоорой.




- Зургийн утга санаа аялгууны ямар шинж төрх, өнгө аясаар илэрхийлэгдэж байна вэ?
- Зургаас ямар хурд, хүчийг мэдэрч байна вэ?
- Арфа болон флейт хөгжмийн дуугаралтыг харьцуулахад ямар онцлог, ялгаа байна гэж чамд бодогдсон бэ? Яагаад?

Сиринкс



Сарны гэрэл



К.Моне. "Сэтгэгдэл. Нар мандалт"



- Домгийг уншаад зураг болон сонссон хөгжмийнхөө агуулга, дүрийг илэрхийлсэн дөрвөн мөрт шүлэг зохиогоорой.
- Чиний зохиосон шүлэг, хөгжим хоорондоо хэрхэн холбогдож байна вэ?
- Аялгууны шинж төрх, хөдөлгөөний чиглэл, өнгө аяс, хурд, хүчийг график дүрслэлээр илэрхийлээрэй.



М.Равель
1875-1937


М.Равель

Болеро

Нарлаг Испани орны ардын болеро бүжгийн хэмнэлд тулгуурлан ер бусын өвөрмөц зохиомжоор туурвисан симфони бүтээл бол М.Равелийн алдарт "Болеро" юм.

Испани ардын бүжгийн онцлог хэв шинжийг агуулсан үндсэн сэдэв ая өөрийн гэсэн давтагдашгүй төрхтэй. Цохивор хөгжмийн бүлэг, тэр дундаа хоёр жижиг бөмбөрийн нэгэн хэвийн хэмнэл зохиолын эхнээс төгсгөл хүртэл ямар ч өөрчлөлтгүйгээр давтагдана.

Эхлэл хэсэг



Нэг сэдэв аялгуунд суурилан 18 удаа давтагдах вариацийн аялгуу, хэмнэл, хөг цомнол болон темп бараг өөрчлөгддөггүй. Гэвч тухай бүртээ гайхалтай, давтагдашгүй дүр төрхөөр эгшиглэдэг. Үүнийг хөгжмийн зохиолч найрал хөгжмийн баялаг өнгө будаг, дуурьслын хүч, бичлэгийн олон аргуудыг ашиглан шийджээ.

Аажмаар хүрээгээ тэлэн өрнөх хөгжим нь ганц хүний эгэл даруухан гоцлол бүжгээс олныг хамарсан сүрлэг бүжиг, сүрт жагсаал болон хувирах мэт сэтгэгдэл төрүүлдэг.



Вариаци-нэг аялгууг олон янзаар хувирган хөгжүүлж давтах маягаар зохиогдсон хөгжмийн зохиолын хэлбэр юм.



- Цохивор хөгжмөөр тасралтгүй давтагдан тоглогдох хэмнэлээр хамтдаа хөгжимдөцгөөе.
- Хөгжмийн зэмсгүүдээр хөгжимдөхдөө сэтгэл хөдлөлөө гарган дуугаралтын хүчийг аажмаар нэмээрэй.



- Найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, өнгө, найруулгад тулгуурлан онцлогийг ялгаж, сонсохыг хичээгээрэй.
- Ноотоо хараад, хөгжмийн зэмсэг тус бүрийн дуугаралтын ялгааг мэдэрч сонсоорой.

Гол аялгуу
А



Гол аялгуу
В



- Зургийг ажиглаад хөгжмөө сонсоорой. Найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, өнгө аясыг хэрхэн мэдэрснээ дүгнэж ярилцаарай.
- Давталт тус бүрийг сонсон ялгааг тэмдэглэж бичээрэй.

Зохиолын нэр...

Аялгууны шинж төрх, онцлог ...

Хөгжмийн зохиолч...

Аялгууны хурд ...

Хөгжмийн зохиолын төрөл ...

Хүчдэлийн өөрчлөлт ...

Хөгжмийн зэмсгүүдийг дарааллаар нь нэрлэх...

Бүтэц хэсэг ...

Агуулга, дүрслэл ...





С.Рахманинов
1873-1943

С.Рахманинов

“Элегия”

С.Рахманиновын уран бүтээлд төгөлдөр хуурын зохиолууд онцгой байр суурь эзэлдэг. Түүний төгөлдөр хуурын анхны бүтээлүүдийн нэг болох “Уран сэтгэмжит аязууд” цувралын “Элегия” нь хүний дотоод ертөнц, сэтгэл санааны байдлыг илтгэн харуулсан байдаг. Энэхүү бүтээлд Орос ардын уртавтар аялгуутай дууны үндсэнд тулгуурласан давалгаа мэт чөлөөтэй урсах гоёмсог аялгуу, хонхны дуугаралтыг санагдуулам дүрслэл гээд хөгжмийн зохиолчийн бүтээн туурвих онцлог тусгагджээ.



- Энэ бүтээлээс сэтгэл санааны ямар байдлыг мэдэрч байна вэ?
- Зохиолын хурдыг өөрчилбөл аялгууны шинж төрх ямар болох вэ? Туршаад үзээрэй.



- Ноот бичлэгийг анхааралтай ажиглаад, тэмдэг, тэмдэглэгээг нэрлэж бичээрэй.
- Хөгжмөө сонсоод өнгө ялган график зураглалаар илэрхийлээрэй.
- Хөгжмөөс төрсөн мэдрэмждээ тулгуурлан эссэ, шүлэг бичиж зохиолын агуулга, дүр, өгүүлэмжийг тодруулаарай.



- Хөгжмийн зэмсгийг монгол нэршлээр, зохиолын төрөл зүйлийг гадаад нэршлээр нь бичээрэй.

Хувилбар аяз	Флейт	Орган
Симфони чуулбар	Фортепиано	
Уран сэтгэмж	Арф	
Бодрол дуу	Тромбон	
Магтуу	Литавр	
Үггүй дуу	Виолончель	

И.Стравинский



И.Стравинский
1882-1971

“Ариун хавар” бүжгэн жүжиг

С.Дягилевийн захиалгаар бичигдсэн И.Стравинскийн гурав дахь балет болох “Ариун хавар” бүтээлд эртний Орос тариачдын хаврын улирлыг угтах ёс заншлын тухай өгүүлдэг.

“Ариун хавар” бүжгэн жүжиг нь хөгжмийн түүхэнд эргэлт хийхэд чухал үүрэг гүйцэтгэсэн зохиол юм. И.Стравинский урьд өмнө байгаагүй найрал хөгжмийн том бүрэлдэхүүнд зориулан бичиж, хурц тод илэрхийлэл, хэмнэлийн нарийн төвөгтэй байдал, харшлаа дуурьслыг хэрэглэж нэг талаас хатуу зэрлэгдүү, нөгөө талаас сэтгэл татахуйц сонирхолтой

бүтээл болгосон юм.

Эхлэл хэсэг
Хаврын байгаль сэргэн аажмаар
цэцэглэж буйг
зурагладаг.



Оргил хэсэг
Омгийн настайчуудын нүдэн дээр нэгэн
залуухан охин хаврыг
сэрээх зорилгоор
бүжиглэсээр, өөрийгөө
золиослоно.

Модон үлээврүүдийн
дээд, доод регистрийг
ашиглаж, хүй нэгдлийн
үеийн эртний бүдүүлэг
дүр төрх, үйл явдал, үзэгдлүүдийг
өвөрмөцөөр дүрсэлж чаджээ.



Төгсгөл хэсэг
Бүжиг, тоглоом наадам,
зан үйлийн ёслолууд
ээлжлэн улмаар үхэх
тавилан оногдсон
бүсгүйн “Агуу их, ариун бүжиг”-ээр
төгсдөг байна.



- С.Сансаргэрэлтэхийн “Эх дэлхийгээ аварцгаая” симфони уран сэтгэмжтэй харьцуулан өнөө цагт тулгамдаад байгаа асуудлыг хөндөж уран бүтээлчид өөр өөрийн цаг үед ямар арга хэрэглүүрээр, хэрхэн илэрхийлэн дүрсэлснийг эргэцүүлээрэй.



- ✓ Хөгжмийн зохиолч энэхүү бүтээлээрээ хүмүүст юу хэлэхийг хүссэн бэ?
- ✓ Бид байгаль орчинтойгоо хэрхэн харьцах ёстой вэ?
- ✓ Найрал хөгжмийн асар том бүрэлдэхүүн, хүчирхэг, нүсэр, сүрлэг дуурьсал хурц тод, ээдрээтэй, нарийн төвөгтэй хэмнэлийн илэрхийлэл нь зохиолын утга санаатай хэрхэн холбогдож байна вэ?

Асуулт тус
бүрд хариулж,
харилцан
ярилцарай.

Хөгжмийн экспрессионизм

Экспрессионизм (expressio)—илэрхийлэл гэсэн утгатай латин үг. Хүн төрөлхтөнд гай гамшиг, аюул дагуулсан дайн дажин, хүчирхийлэл, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл ноёрхсон ХХ зуунтай давхцан экспрессионист урсгал гарч ирсэн. Экспрессионизм нь хувь хүний ертөнцийг үзэх үзлийг товойлгон илэрхийлж, тухайн үеийн хүмүүсийн эмгэнэлт хувь заяаны жинхэнэ мөн чанарыг нээхийг эрмэлзэж байсан. Анх дүрслэх урлагт үүсч, дараа нь уран зохиол, хөгжим, театр, кино урлагт нэвтэрчээ

Хар дарсан аймшигт зүүдийг санагдуулам гэрэл гэгээгүй, зовиур шаналант, ганцаардмал хувь заяаг дүрслэхэд уламжлалт долоон эгшигт хөг цомлоос татгалзах шаардлага гарсан байна. Ийнхүү Шинэ Венийн дэгийг үндэслэгч А.Шёнберг өөрийн шавь А.Берг, А.Веберн нарын хамт уйгагүй эрэл хайгуул хийсний үр дүнд 12 эгшгийг ашиглан хөгжим бүтээх аргыг 1920–иод онд анх боловсруулсан байна. Энэ нь өөр өөр өндөрлөг дээр байрлах 12 эгшгийг дахин давталгүй нэгэн дараалал болгоод, эгшиг тус бүрээс нь мөн тийм зохион байгуулалттай дарааллуудыг хэвтээ, босоо бүх чиглэлд байгуулан хөгжим зохиох арга юм.

Альбер Жирогийн шүлгээр бичсэн А.Шёнбергийн “Пьеро Саран” хэмээх 21 дуутай цуврал зохиол нь энэ аргыг бүрэн хэрэгжүүлсний тод жишээ юм.




- 12 эгшгийн техникээр зохиомж хийцгээе. Ингэхдээ дараах жишээг ашиглаарай.
- Туурвисан бүтээлдээ тохирох хүчдэлийн тэмдэг, хурдыг сонгон тэмдэглээрэй. Жишээ нь:

- Октав доторх 12 эгшгийг өөрийн сонголтоор тодорхой дараалалд оруулан бичээрэй.



- Мөн толин тусгал мэт хөнтрүүлэн бичээрэй.




- Дахин түүнийгээ тонгоруулах зэргээр хувилбарлаарай.



- Бичсэнээ багшийн тусламжтай тоглож сонсоорой.
- Ямар мэдрэмж төрж байна вэ? Тухайн нийгэм цаг үетэй холбож эргэцүүлээрэй.

Додекафони - 12 эгшиг гэсэн грек үг. 12 өөр эгшгээр хөгжим бүтээх арга. Хөгжим зохиох явцад 12 эгшиг давтагдахгүй дараалж байхаар тооцоологдоно.

А.Шёнберг



Арнольд Шёнберг
(1874-1951)

“Пьеро саран”

Цөөхүүл хөгжмийн тавал (төгөлдөр хуур, хийл, Флейт, виолончель, кларнет) болон гоцлол дуучинд (сопрано хоолойд) зориулан эрс шинэлэг, экспрессионист арга барилаар бичсэн. Хөгжмийн зохиомжийн 12 хөгийн шинэлэг зарчмаар туурвисан түүний бүтээл туурвил болгон хүмүүсийг цочирдуулж байлаа. Аялгуу нь сонсогчдын хүлээж байсан шиг тийм ч “тааламжтай” сонсогддоггүй байв. Учир нь түүний хөгжим тодорхой хөг эгшиглэгээгүй, харш

дуурьсалтай байсан юм. А.Шёнбергийн “Пьеро саран” зохиолд сэтгэл хөдөлгөсөн үг хэллэг, яруу тод уншлага, бодит хашгирааныг ноот бичлэгт буулгаснаараа онцлог юм. Хөгжмийн зэмсгийг хамгийн дээд регистрт дуугаргаж, замбараагүй үсрэлт бүхий аялгуугаар утга санаагаа тодотгон илэрхийлсэн.



В.Кандинский “Зохиомж №7”

“Пьеро саран” зохиолын дуулаачийн хэсгийн аялгуу

Sehr rasche (Маш хурдан)



Ж.Пуччини

“Чио-Чио сан” дуурийн Чио-Чио саны ари



Ж.Пуччинийн “Чио-Чио сан” дуурь бол хөгжмийн импрессионист чиглэлийн зохиол юм. Япон ахуй, аж байдал, байгалийн зураглалыг дорно дахины таван эгшигт хөг цомнол бүхий хөгжмийн аялга, мөнгөн хонхны жингэнээн, ятгын уяхан ялдам өнгө аясаар илэрхийлдэг. Чио-Чио саны ари энхрий ялдам бөгөөд сэтгэл догдлуулам тасралтгүй үргэлжлэн урсах аялгуутай.

Хөгжмийн зохиолч япон хэл ярианы болон ардын дуу хөгжмийн ая аялга, хэм хэмнэлийн өвөрмөц байдлыг сайтар судалж өөрийн гэсэн онцлог арга маяг, хөгжмийн өвөрмөц хөг эгшиглэгээг бий болгосон юм.



Хоорондоо хэдхэн жилийн зайтай зохиогдсон дээрх зохиолуудын хөг эгшиглэгээ, аялгууны шинж төрх ямар их ялгаатай байгаа нь ноот бичлэгээс тодорхой харагдана.



- Хөгжмөө сонсоод ноотоо харьцуулж 12 эгшгийн журмын дагуу бичигдсэн "Пьеро Саран" зохиолын аялгууны ноотонд эгшгүүд давтагдаж байгаа эсэхийг ажиглаарай.



- Өмнөх үеийн хөгжмийн бүтээлийг орчин үеийн хөгжмийн зохиолтой харьцуулан сонсьё.
- Асуултын дагуу тэмдэглэгээ хийгээрэй.

№	Бүтээлийн нэр	Дүрийн онцлог шинж	Аялгууны шинж төрх	Хоолойн төрөл	Дагалдах хөгжмийн зэмсэг
1	Ж.Пуччини "Чио Чио сан" дуурийн Чио Чио саны ари	Япон сурвалжит бүсгүй, ёс журмыг эрхэмлэгч, уян зөөлөн	Уянгын дуулалт	Сопрано	Чавхдаст хөгжмийн зэмсэг
2	Ж.Бизе "Кармен" дуурийн Кармены товшуурт бүжгийн дуу	?	?	?	?




- Зурган мэдээллийн аргаар орчин үеийн хөгжмийг өмнөх үеийн хөгжимтэй харьцуулан ажиглаарай. Хөгжмийн бүтээлийн эгшиглэлттэй ямар холбоотой болохыг ярилцаарай.



- Үндсэн санаа, ойлголт ухагдахууныг хүснэгт, бүдүүвч ашиглан тодорхойлоорой.

№	Хөгжмийн хэл	Өмнөх үеийн хөгжимд	Орчин үеийн хөгжимд
1	Өнгө эгшгийн зохицол	Тогтвортой	?
2	Дуурьсал	Нийцтэй, тааламжтай	?
3	Хэмнэл	Энгийн, тогтуун	?



Карл Орф
1895-1982

К.Орф

"Кармина Бурана" магтуу

Карл Орф "Кармина Бурана" зохиолынхоо цомнолыг дундад зүүны үеийн шүлгийн үзэл санаанд тулгуурлан бичсэн. Оршил болон 3 үндсэн бүлэг, 25 хэсгээс бүрддэг. Энгийн бадагчилсан хэлбэртэй.

Хөгжмийн зохиолч "Кармина Бурана" магтуугаа гоцлооч, найрал дуучид, найрал хөгжмийн өргөтгөсөн бүрэлдхүүнд зориулж бичсэн байдаг. Мөн тайзны үзүүлбэрийг оруулж ирсэн нь өвөрмөц шийдэл болсон.

Хүмүүний амьдралын мөн чанар болох зогсолтгүй эргэлдэх хөдөлгөөн, мөнхийн зөрчил тэмцэл, хувьсал өөрчлөлтийг илэрхийлэхийг зорьсон.

Зохиол ертөнцийг эзэгнэгч Фортунаг магтан дуулах сүлд дууллаар эхэлж, мөн энэ хэсгээр төгсдөг.

- аажмаар хурдсах темп;
- зугуухан дээшлэх өнгө эгшгийн шилжилт;
- гуулин үлээвэр болон цохивор хөгжмийн зэмсгүүдээр өргөжин баяжих дуурьсал;
- зогсолтгүй өрнөх хүч;

Энэ бүхэн зохиолын гүн гүнзгий агуулгыг илэрхийлнэ.

- Эхлэл хэсгийн хөгжмийг сонсонгоо үндсэн сэдэв аяыг аялцгаая.



- Хөгжим сонсоход чамд ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ?
- Хэрвээ ноот дээрх нэмэлт тэмдэг тэмдэглэгээ байхгүй бол хөгжмийн шинж төрх бүрэн гүйцэд илэрхийлэгдэж чадах уу? Нэмэлт тэмдэглэгээний талаар хөгжмийн толь, цахим эх сурвалжаас тодруулж мэдээрэй.





Л.Бернстайн
1918-1990

Л.Бернстайн

“Вестсайдын түүх” мюзикл

XX зуунд дэлхий дахинаа хамгийн ихээр алдаршсан мюзиклуудын нэг юм.

У.Шекспирийн “Ромео Жульетта хоёр” эмгэнэлт зохиолоос сэдэвлэсэн энэхүү хөгжимт жүжгийн үйл явдал орчин үеийн Америкт, Нью-Йоркийн баруун хэсэгт оршин суудаг ядуусын хороололд өрнөнө. Нью-Йоркийн унаган оршин суугч залуус болон энд дөнгөж суурьшихаар ирсэн

Пуэрто-Рико гаралтай ядуу залуусын хооронд үл ойлголцол үүсч сөргөлдөнө.

Пуэрто-Рико* гаралтай бүсгүй Марияд Америк залуу Тони дурлана. Хоёр бүлэг болж талцсан залуусын сөргөлдөөнийг Тони зогсоохыг хичээх боловч түүний хамгийн сайн найз Рифф амиа алдана. Уй гашууд ухаанаа алдсан Тони эсрэг бүлгийн толгойлогч, Мариягийн ах Бернардгийн амийг хороодог. Үүнийхээ хариуг Тони амиараа төлнө. Мюзикл бие биенээ үзэн ядагч хоёр бүлгийн эвлэрлээр төгсдөг.



Мюзикл

Мюзикл (musical, англиар-хөгжмийн) дуу, хөгжим, бүжиг, драмыг хослуулан театр, киног нэгтгэсэн холимог төрөл. Англи хэлнээс үүсэлтэй нэр томьёо.

XIX зуунд хошин жүжиг (буффа), варьете, инээдмийн ший (водевиль) зэрэг театрын хэлбэрээр Америкт өргөн дэлгэрч XX зууны 20-30 оноос урлагийн бие даасан төрөл болон хөгжсөн. 1940-өөд онд мюзикл Бродвейд цэцэглэлтэндээ хүрсэн. Үүнд 1930-аад онд кинонд дуу орсон явдал нөлөөлсөн юм. Хөгжмийн зохиолчид өөрсдийн шилдэг бүтээлээ дэлгэцийн бүтээл болгосон байдаг. Тухайлбал Ж.Керны "Хөвж яваа театр", Ж.Гершвины "Чамдаа дуулья", Л.Бернстайны "Вестсайдын түүх" зэрэг мюзикл дэлхийн хэмжээний сонгодог кино болон алдаршжээ.

"Пуэрто-Рико" баян боомт гэсэн испани үг бөгөөд Карибын тэнгист байрлах жижиг арал улс болно. Ард иргэд нь АНУ-ын давхар иргэншилтэй байдаг ажээ.



- Мюзиклийн зодооны хэсэг, “Мария”-Тонигийн дуу, Мария, Тони хоёрын хоршил, “Америка”- бүсгүйчүүдийн дуу бүжгийн хэсгээс сонсоцгооё.
- Тонигийн “Мария” дууны аялгууг П.И.Чайковскийн “Ромео Жульетта хоёр” симфони удиртгалын дурлалын сэдэв аятай харьцуулаарай. Ижил төстэй зүйл байна уу?



”Мария”

Сэтгэлийн хөдөлгөөнтэй

mf и толь-ко что ветре-тил Ма-ри-ю то

и-мя ста-ло вмиг пре-крас-пей всех дру-гих и-мен Ма-ри-я

П.И.Чайковскийн “Ромео Жульетта” удиртгалын Хайр сэтгэлийн сэдэв аялгуу

Уян зөөлөн

mf



- Л.Бернстайны мюзиклийн зодооны хэсгийн сэдэв ая, П.И.Чайковскийн хөгжмийн дайсагналын сэдэв ая хоёрыг харьцуулаарай.



Л.Бернстайны мюзиклийн зодооны хэсгийн сэдэв ая

Хурдан, шийдэмгий

ff



П.И.Чайковскийн “Ромео Жульетта” удиртгалын дайсагналын сэдэв ая

Хурдан

f

Хөгжмийн авангардизм

Авангард гэдэг нь (avant-garde) тэргүүн хэсэг, манлайлах гэсэн утгатай цэрэг, улс төрийн хэллэгээс үүссэн франц гаралтай үг. Авангардизм нь ХХ зууны хөгжмийн янз бүрийн чиг хандлагуудыг ерөнхийлөн нэрлэсэн нэр томъёо. 1920-иод онд нийгмийн хөгжил зогсонги байдалд орсноор урлагийн шинэчлэлийн төлөө залуу уран бүтээлчдийн хөдөлгөөн өрнөжээ. Авангард уран бүтээлчид уран сайхны аргаар хүний ухамсрыг өөрчлөхийг зорьж байлаа. Дэлхийн II дайны дараа барууны орнуудад янз бүрийн урсгалууд олноор үүсч сонгодог урлагийн гоо зүйн хэм хэмжээ, уламжлалтай олон талаар харшилдаж байсан юм. Авангард хөгжмийн зохиолчид шинэ утга санааг үл таних яруу тод хэрэгслээр илэрхийлж шуугиан тарихыг зорин урлагийн гоо сайхан, ёс зүйн үндсийг эвдэхэд хүргэсэн эрсдэлтэй туршилтуудыг ч хийж байлаа.



А.Шнитке
1934-1998

А.Шнитке

“Доктор Иоханн Фаустын түүх” магтуу

Авангард хөгжмийн томоохон төлөөлөгч, Орос, Германы хөгжмийн зохиолч А.Шнитке өргөн цараатай агуулга, хэлбэр, ялгарамжит драматург, хөгжмийн дуурьслын өвөрмөц илэрхийлэл, олон талт хэв шинж бүхий бүтээлээрээ ялгардаг. Түүний бүтээлүүдэд хүний хувь заяа, ёс суртахууны сүйрэл, дайн, атомын бөмбөгдөлтийн эмгэнэл, хүний мөн чанар болсон сайхан сэтгэл, сайн үйлсэд тэмүүлэх тэмүүлэл тусгалаа олсон байна.

Хөгжмийн зохиолчийн хамгийн онцгой бүтээлийн нэг бол “Доктор Иоганн Фаустын түүх” хэмээх магтуу билээ. Энэ магтуугаа контратенор, контральто, тенор, басс хоолой болон холимог найрал дуу, найрал хөгжимд зориулан бичжээ. Кантат 10 хэсгээс бүрдэх ба хожим нь уг бүтээлээ дуурь болгосон байна. Энэхүү магтуунд эрт эдүгээгийн хөгжмийн олон янз хэв маяг, дуулах арга барил тусгагдсан бөгөөд үүгээрээ тодорхой зүйлийг бэлгэдэж байдаг.

Магтууны сонирхолтой агшин болох оргил хэсэгт (№7) эд баялаг, хангалуун амьдралын төлөө чөтгөрт сүнсээ худалдан, улмаар үйлдсэн нүглийнхээ гэсгээлийг хүртэж буй Фаустын үхэл, тамын элч Мефистофелийн жинхэнэ дүр төрхийг илтгэн харуулжээ. Ингэхдээ танго бүжгийн хэмнэл, дуулаачийн илэрхийллийн олон, сонин содон арга барилыг ашиглажээ.






- Хөгжмөө анхаарч сонсоорой.
- Ямар бүрэлдэхүүнд зориулагдсан байна вэ?
- Дуулалтын ямар арга барилуудыг ашиглаж байна вэ?
- Найрал хөгжимд ямар шинэлэг өнгө тембрийг нэмсэн хөгжмийн зэмсгүүдийг ашиглаж байна вэ?
- Хөгжмийн зохиолын агуулга, илэрхийллийн арга, бүрэлдэхүүн, зэмсэгжүүлэлтэд тулгуурлан дараах загвараар синквейн* шүлэг зохиогоорой.

Шүлгийн зохион байгуулалтын зарчим

- 1 дэх мөр – тухайн хүн, үзэгдэл юмсыг илэрхийлэх нэг үг (нэр үг, эсвэл төлөөний үг)
- 2 дахь мөр – тухайн хүн, үзэгдэл юмсын шинж чанар, төрх байдлыг тодорхойлох 2 үг (тэмдэг нэр)
- 3 дахь мөр – тухайн зүйлийг тайлбарлан таниулсан 3 үг (үйл үг)
- 4 дэх мөр – зохиогчийн тухайн юмс, үзэгдэлд хандах хандлагыг илэрхийлсэн 4 үгээс бүтэх өгүүлбэр.
- 5 дахь мөр – тухайн хүн, үзэгдэл юмс, сэдвийн мөн чанарыг илтгэн дүгнэх 1 үг.

Жишээ нь:



Бодит хөгжим


Хөгжмийн авангардизмыг төлөөлөх урсгалуудын нэг бол “Бодит хөгжим” юм. Хөгжмийн зохиолчид төдийгүй дуу бичлэгийн инженерүүд хөгжмийн илэрхийллийн шинэ хэрэглүүрүүд, шинэлэг дуу авиа гаргахыг эрмэлзэх болов. Бодит хөгжмийн гол зорилго нь хөгжмийн эгшгийн оронд амьдрал дээрх тодорхой дуу авиа, чимээ шуугианыг ашиглаж шинэ хөгжим бүтээх явдал байлаа. Тэд янз бүрийн шуугиан, хүний хашгирах чимээ зэргийг бичиж хальсны эргэлтийг удаашруулах, хурдасгах замаар авиа эгшгийн шинэ нэгдлийг бий болгож, түүнийгээ тодорхой дарааллаар эвлүүлэн хөгжим бүтээж байв. “Бодит хөгжим”-ийн чиглэлийн гол төлөөлөгч Пьер Шеффер, П.Булез, О.Мессиаан, А.Жоливе нар тусгай туршилтын бүлэг байгуулж “бодит хөгжим”-ийн олон зохиол туурвижээ. Ингэхдээ, хотын амьдрал болон байгалийн шуугиан, мөн хөгжмийн зэмсгийн дууг хувьсган тодорхой зохиомжид оруулж байв. Мөн Америкийн хөгжмийн зохиолч Ж.Кейж хөгжмийн зэмсгийн тембрийг баяжуулах зорилгоор

* Синквейн (анг. *cinquain*) – XX зууны эхэн үест АНУ-д Японы эртний хайку, танга шүлгийн нөлөөн дор бий болсон 5 мөрт шүлгийн хэлбэр

янз бүрийн мод, төмөр, резин, мөн өөр өөр хурдтайгаар зохиомжилсон оньсон хөдөлгүүрүүдийг ч хөгжимдөө хэрэглэж туршжээ.

XX зууны эхэн үеийн Италийн хөгжмийн зохиолч, авангард урлагийн төлөөлөгч Отторино Респиги байгаль болон орчин үеийн их хотоос төрсөн сэтгэгдлээрээ “Шувууд” чуулбар бичиж түүндээ тагтаа, тахиа, хөхөө, гургалдайн дууг ашигласан байдаг.

“Бодит хөгжим” нь хөгжмийн өнгө, дуугаралтын асар их боломжийг нээх зорилготой байсан ч хэрэг дээрээ хөгжмийн урлагийн уран сайхны ач холбогдлыг алдагдуулсан юм. Иймээс зөвхөн театр, кино, телевизийн урлагийн дууны чимэглэл болж үлдсэн ажээ.



- Зурган мэдээллийн талаар харилцан ярилцаад, дүгнэлт гаргаарай.
- Хөгжимд шинэ арга хэрэгсэл ашиглаж шинэ хөг, эгшиглэгээ, дүрслэл, илэрхийллийн өвөрмөц боломжийг эрж хайж, түүнийгээ хэрхэн туршиж байсан тухай мэдээллийг www.google.mn хаягаар орж дэлгэрүүлэн судлаарай.

Түлхүүр үгнээс богино бичвэр бүтээцгээе.



- “Авангард урлаг” сэдвийн хүрээнд авангард уран зураг болон хувцас загваруудыг цахим хаягаар аялж, үзэж танилцаарай.
- К.Пендерецкийн 52 утсан хөгжмийн зэмсгээс бүтсэн цөөхүүл найрал хөгжимд зориулсан “Хиросимын хохирогчдын дурсгалд зориулсан уй гаслан” хэмээх бүтээлийг сонсоорой.
- Дээрх бүтээлүүдтэй танилцаж, хөгжмөө сонсож, ярилцсаны үндсэн дээр дараах түлхүүр үгсийг ашиглан өөрсдийн ойлголтоор “Бодит хөгжим”-ийн талаар тодорхойлолт гаргаарай.

Түлхүүр үгс: тодорхой дуу чимээ, авиа эгшгийн нэгдэл, байгаль дээрх элдэв юмс, тодорхой дараалал, шинэ хөгжим, илэрхийллийн шинэ арга барил

1. Сурагч тус бүр өөрсдийн гаргасан тодорхойлолтыг уншина.
2. Багаар ажиллаж нэгдсэн тодорхойлолт гаргана.
3. Баг бүрээс төлөөлөгч гарч, эцсийн нэгдсэн тодорхойлолт гаргахад оролцоно.

Энэ мэтээр шат дараатай сайжруулан багийн ажлын давуу талыг ойлгож мэдээрэй.



А.Онеггер



Артур Онеггер
1892-1955

“Пасифик-231”

Техник технологийн дэвшил, машиныг тахин шүтэх орчин үеийнхний хэт өрнөлтэй амьдралын хэмнэлээс урган гарсан “Пасифик-231” бүтээл анх 1924 онд эгшиглэжээ.

“Пасифик-231” бол цагт 120 км хурдтай явдаг, хүчин чадлаараа тэр үедээ рекорд тогтоож байсан америкийн локомотив-уурын галт тэрэгний нэр юм. Удалгүй энэ бүтээл өргөн олон сонсогчдын хүртээл болж А.Онеггерын нэрийг олон улсын хэмжээнд таниулсан. А.Онеггер өөрийн зохиолын санаа, утга агуулгыг “Уурын тэрэгний яаралгүй хөдлөх амь амьсгал, чимээ, улмаар хурдаа авч эрчимтэй урагшлах үйл явцыг гайхан бахдах сэтгэлийн хөдөлгөөнтэй хосолсон бодит сэтгэгдлээс төрсөн” гэжээ.

Хөгжмийн зохиолчийн энэ зохиолдоо ашигласан вариацийн арга нь уртаас аажмаар богиносох хэмнэлийн задаргаанд суурилдаг.




- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хэмнэлийн зураглалыг ажиглаарай. Хэмнэл хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
- Зохиолын сэдэв аялгууг ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсэн байна вэ?
- Аялгууны чиглэл хөдөлгөөнийг ажиглаад зураглаарай.
- Хөгжмийн зохиолч уурын галт тэрэгний дүр дүрслэлийг хөгжмийн ямар илэрхийллийн аргууд ашиглан бүтээснийг хамтран ярилцаж нэгтгэн дүгнээрэй.




Rythmique






- Ш.Өлзийбаярын "286 дугаар галт тэрэг", А.Онеггерын "Пасифик-231" зохиолуудыг харьцуулж ярилцаарай.



- Авангардизм сэдэвтэй холбоотой ойлголт ухагдахуунуудыг цувруулан бичээрэй.
- Хоорондын холбоо хамаарлыг тогтоож шулуунаар холбоорой.
- Сэдвийн агуулгад хамааралтай ойлголтуудын олон талт уялдаа холбоог илрүүлж, мэдсэнээ эмх цэгцтэй илэрхийлэн ярьж сураарай.



- Уншаад орчин үеийн хөгжмийн ямар урсгал, зохиомжийн арга техник болохыг тодорхойлно уу.



ОРЧИН ҮЕИЙН БҮЖГИЙН ГАРАЛ, ҮҮСЭЛ

XIX зуунд бүжгийн урлаг нь сонгодог, цэнгээнт, ардын бүжиг гэсэн чиглэлээр хөгжиж байлаа. Харин Францын дуурийн дуучин Франсуаз Делсарт хүний биеийн хөдөлгөөн болон сэтгэл хөдлөлийн хоорондын холбоог судалж, сэтгэл хөдлөлөө илэрхийлсэн дурын хөдөлгөөнийг хөгжмийн аянд тохируулан гүйцэтгэх санаа дэвшүүлснээр орчин үеийн бүжгийн эх суурь тавигджээ.

Тэрээр бүжигчид, хөгжимчид, зураачидтай хамтран хүний сэтгэл хөдлөл, үйл хөдөлгөөний хурдыг XX зууны техник технологийн шинэчлэлтэй холбон судалж байлаа. XX зууны эхэн үеэс Америкт хөгжмийн шинэ хэв маяг болсон хурдан жавхаалаг хэмнэлтэй Регтайм (ragtime)-ийн аянд бүжиглэх нь тухайн үеийн хүн бүрийн хүсэл эрмэлзэл болж чадсанаар кейквок (cakewalk) хэмээх бүжгийн шинэ төрөл үүссэн байна. Кейквок (cakewalk) бүжгийг маш хөгжилтэй бүжиглэдгээрээ В.Вилльям, Ж.Волкер нар алдартай байжээ.

Кейквок бүжгийн дараа америкчууд амьтны дүр төрх, хөдөлгөөнийг дуурайсан хөгжилтэй, үсрэлттэй бүжгийг зохион бүжиглэх болсон байна. Мөрөө сэгсрэн, таазаа хөдөлгөж, чөлөөтэй байрлалаар хурдан шилжиж, тохой өвдөгний огцом цохилттой хөдөлгөөн хийж, толгойн хэсгийг дээш доош болгох нь тухайн үедээ маш өвөрмөц зүйл байлаа.


XX зуунд бүжгийн хөгжмийн төрөл олон янзаар өөрчлөгдөн солигдож байв. Жишээ нь танго, румба, фокстрот бүжгийн хөгжим рок-н-роллоор солигдож, дараа нь твист, шейк, самбо, брейк болон нийтэд түгжээ. Олон жилийн турш эстрад бүжгийн хөгжимд ноёрхож байсан Диско бүжгийн хэв маяг XX зууны II хагасаас хурдацтай тархсан юм.



чарльстон



твист



фокстрот



самбо



танго



шейк

Үггүйгээр намайг ойлго.



- Ямар ч амьтны дүр төрхийг хөдөлгөөнөөр илэрхийлэн бүжиг болгож болдог. Тахиа мэт хүзүүгээ урагш сунгаж, тас шувуу шиг дэвж болно, гэхдээ тас, тахиа хоёрын ялгааг гаргаж илэрхийлэхээ мартаж болохгүй.
- Оролдоод үзье. Муурын мяраан гэтсэн алхаа, мэлхийний дэвхрэлт, бүргэдийн дэвэлт, оцон шувууны алхаа гэх мэт хөдөлгөөнийг хийгээрэй.
- Юуны өмнө бүжгийн хөдөлгөөн аялгууны хэмнэлтэйгээ тохирч байх ёстой. Мөн хөгжмөө тун анхааралтай сонсож сэтгэл хөдлөлөө илэрхийлэх шаардлагатай.

Бүжиг дэглэе.

- Өдөр тутам давтан хийдэг хөдөлгөөнүүдээ хийж үзээрэй. Жишээ нь: гараа энгэр дээрээ солибож барих, газраас ямар нэгэн зүйлийг авах, гараараа чиглэл заах гэх мэт.
- Дараа нь хөгжмийн аянд тохируулан тэдгээр хөдөлгөөнөө эвлүүлэн өөрсдийн бүжгээ дэглээрэй. Мөн хөдөлгөөний дарааллыг өөрчлөөд үзээрэй.

Бүжгийн хэмнэлээ өөрсдөө зохиоцгооё.

- Алгаа таших, дуу авиа тод гаргах зүйл дээр цохих замаар янз бүрийн хэмнэл зохиож, түүнд тохируулан бүжиглэж сурах дасгалууд хийгээрэй.
- Мөн цээж, мөр, өвдөг дээрээ алгаараа цохиж хөгжмийн зэмсэг мэт өөрсдийн хүссэн хэмнэлээ зохиогоорой.
- Хөлийн товшилтоороо янз бүрийн орчин, орон зайд шилжин хөдөлж, хэмнэл үүсгээрэй. Хөлөөрөө шалан дээр товшилт хийн алхахдаа гараараа хөлний хөдөлгөөнөөс хоёр дахин хурдтай хөдөлгөөн хийгээрэй.
- Таалагдсан хөдөлгөөнүүдээ хэд хэдэн удаа давтан хийж, түүнийгээ бүжиг болгож үз.



Тахиа



Муур



Оцон



Далайн гахай



Баавгай

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ХӨГЖИМ

Монголын орчин үеийн хөгжмийн үүсэл


1921 оны Ардын хувьсгалын ялалт Монголын хөгжмийн урлагт хөгжлийн шинэ замыг нээсэн. Журамт цэргийн сүрлэг уухайг цуурайтуулсан "Шивээ хиагт", "Магнаг үсэгтэй туг", "Улаан туг" дуугаар монголын шинэ цагийн хөгжмийн урлаг эхлэлээ тавьсан юм. Шинэ цагийн хөгжмийн урлагийн үүсэлд алдарт дууч М.Дугаржав, үлгэрч Ө.Лувсан, дууч-жүжигчин Д.Ичинхорлоо, О.Дашдэлэг нар чухал хувь нэмэр оруулжээ.

1931 онд Улсын төв театр байгуулагдаж, хөгжмийн урлаг шинэ төрөл хэлбэрээр баяжин хөгжих нөхцөл бүрэлдэв. Энэ үед дуут жүжиг шинээр үүсэж "Учиртай гурван толгой", "Харц Дамдин, хатан Долгор", "Партизан Батхүүгийн зам дээр" зэрэг бүтээлүүд гарчээ.

1940-өөд оноос хөгжмийн зохиолчид ардын уламжлалыг баяжуулан хөгжүүлсэн олон дуу, хөгжмийн бүтээл туурвиж эхэлсэн. Хөгжмийн зохиолч Л.Мөрдорж, С.Гончигсумлаа, Б.Дамдинсүрэн, Л.Дорж, Д.Лувсаншарав нарын "Түүхт хил", "Эх орон", "Монгол морь", "Малчдын уралдаан" зэрэг нийтийн хүртээл болсон дуунууд зохиогдов.

1942 онд "Учиртай гурван толгой" анхны дуурь, 1955 онд "Миний эх орон" анхны симфони, 1958 онд "Ганхуяг" анхны бүжгэн жүжиг зэрэг хөгжмийн том хэлбэрийн бүтээлүүд гарсныг бид бүхэн мэднэ.

Ардын армийн үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим (1950), Улсын ардын дуу бүжгийн чуулга (1951), Улсын дуурь бүжгийн театр (1963), Улсын филармони (1972) байгуулагдаж хөгжмийн мэргэжилтэй боловсон хүчнүүд бэлтгэгдэж эхлэв.



- Монголын хөгжмийн урлагт гарсан хувьсал, өөрчлөлттэй холбоотой мэдээлэл цуглуулан танилцуулга бэлтгээрэй.

“Зуурдын орон” симфони чуулбар

Төрийн соёрхолт, УГЗ, Хөдөлмөрийн баатар Б.Шаравын “Зуурдын орон” бүтээл нь монголын хөгжмийн театрын түүхнээ анхны модерн бүжгэн жүжиг болсон юм. Энэ бүжгэн жүжгээ “Чойжид дагина”-ын туужаас сэдэвлэн бүтээжээ.

Хөгжмийн зохиолч бүжгэн жүжгийнхээ хөгжмийг концертын тайзнаа тоглоход зориулан 4 анги бүхий симфони чуулбар болгосон.

Чойжид дагинын тууж бол “Хүний үхэх төрөхийн мөчлөг, үйл үрийн уялдаа холбоо”-г Бурханы шашны үүднээс тайлбарласан нэн эртний гайхамшигт зохиол билээ.



Зохиолын агуулга нь, Чойжид хэмээх нэгэн эмэгтэй 36 насандаа хүндээр өвдөн үхээд, сүнс нь Эрлэгийн орноо хүрч очно. Тэнд Эрлэг номун хаантай уулзах ба түүнийг “Нэр, нас андуурагдан ирсэн байна” хэмээн хэлж, буцаж биед нь оруулан амьдруулахаар болно. Харин буцахын өмнө Эрлэг номун хаан түүнийг сүнсний зорчин өнгөрөх орон, буян нүглийг ялган шүүх, Эрлэгийн орны тухай танилцан мэдээд, хүний ертөнцөд буцсаны дараа олон түмэнд таниулахыг зарлигдаж, хэсэг хугацаанд байлгадаг. Ингээд Чойжид, зуурдын сүнсний ертөнцийн талаар ихийг мэдэж, эргэж амилсаны дараа насан турш буянтны мөрийг хөөж, дагинасын эрдмийг олохоор шийдэж байгаа тухай гардаг болно.

Зохиолынхоо агуулгатай уялдуулан хөгжмийн зохиолч найрал хөгжмийн бүрэлдэхүүндээ шашны хөгжмийн зэмсгүүд гэгддэг хонх, дармар болон цохивор хөгжмүүдийг түлхүү ашигласан байна. Бүжиг дэглэлтэндээ ч уламжлалыг эвдэн, модерн бүжгийн элементүүдийг үндэсний бүжгийн хөдөлгөөнүүдтэй хослуулсан.

Шашны хөгжмийн ая дан, цохивор хөгжмийн зэмсгүүд, ардын ая аялгууг орчин үеийн хөгжмийн бичлэгийн арга барилтай хослуулсан байдаг. Чойжид дагинын гол сэдэв аялгууг флейт, гобой хөгжмүүд гоцлох бөгөөд энэ аялгуу нь зохиолын туршид эгшиглэдэг.

Чуулбарын II ангийн хөгжим. Энэ ангийн хөгжим наймтын нэгэн хэвийн жигд хэмнэлтэй хүнд нүсэр аккордоор эхэлнэ. Хэдийгээр *mf* буюу чангавтар тоглогдох боловч аккорд болгоныг акцентаар тодотгон өгч, гуулин үлээвэрт оноосон нь цаанаа л нэг хахир хүйтэн сонсогдоно. Энэ нь үхэл ойртон ирж буйг дүрсэлжээ. Үүнтэй зэрэгцэн хонх, дармар сонсогдоно.

Moderato

25

mf

mp *mf*



С.Сансаргэрэлтэх
(1969)

“Эх дэлхийгээ аварцгаая” симфони уран сэтгэмж

Энэхүү зохиолд өнөө цаг үеийн тулгамдсан асуудал болох байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж буйг дүрсэлжээ.

Хүн төрөлхтөнд хамааралтай энэ сэдвийг хөндөхдөө Монгол ардын уртын дуу, лимбэ, морин хуурын эгшиглэгээг барууны симфони найрал хөгжим, эстрад рок хөгжмийн зэмсгүүдтэй хослуулах замаар шийдсэн нь оновчтой болсон юм.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Багт хуваагдан “Эх дэлхий, эх орны минь ирээдүй - Бидний оролцоо” сэдэвт ярилцлагыг дараах асуултуудын дагуу зохион байгуулаарай.
- Хөгжмийн зохиолын агуулга болон зураг дүрслэл бидний амьдрал дээрх ямар алдаа дутагдлыг сануулж байна вэ?
- Хөгжмийн зохиолч энэ бүтээлээрээ бидэнд юу хэлэхийг зорьсон бэ?
- Бид байгаль орчинтойгоо хэрхэн харьцах, юу хийх ёстой вэ?
- Хөгжмийн уран бүтээлийн үүрэг, зорилго чухам хэнд, юунд зориулагддаг гэж бодож байна вэ?

Хэрэв дэлхий маань ярьдагсан бол
Хамаг л зовлонгоо тоочих байсан
Хүмүүс бидний бурууг тоочиж
Хүлцэж дийлэхгүй уйлах байсан
Үнэндээ бид буруутай нь үнэн
Үр ач нараа бодоогүй нь ч үнэн
Буруу хэргээ хүлээдэггүй нь үнэн
Бусдаас өрсөж сүйтгэдэг нь ч үнэн
Тийм болохоор би дэлхийгээсээ
Тэрбум хүний өмнөөс уучлал гуйя.
Одоо бид дэлхийгээ хайрлана
Оройтсон ч гэсэн чамайгаа хамгаална.

Хөвсгөл Хатгал сум 8д ангийн сурагч Ану-Үжин



Хөгжмөө дахин сонсоод дараах асуултын дагуу ярилцаарай.



- Зохиолын агуулгыг ямар хөгжмийн зэмсгүүдээр илэрхийлж байна вэ?
- Яагаад Монгол үндэсний болон орчин үеийн хөгжмийн зэмсгийг хослуулан хэрэглэсэн гэж бодож байна вэ?
- Энэхүү симфони уран сэтгэмжид уртын дуу ямар үүрэгтэй вэ?
- Цахилгаан хөгжим, түүний хүчирхэг нүргээн чиний бодлоор юуг илэрхийлж байна вэ?

С.Сансаргэрэлтэхийн “Эх дэлхийгээ аварцгаая” симфони уран сэтгэмжийг Т.Уртнасан, З.Зуунай нарын “Хангайн магтуу” дуутай харьцуулан ижил болон ялгаатай талуудыг тодорхойл.

№	Асуулт	Ая Т.Уртнасан, үг З.Зуунай “Хангайн магтуу”	С.Сансаргэрэлтэх “Эх дэлхийгээ аварцгаая”
1	Бүтээлийн утга агуулга, хөгжмийн зохиолчийн санаа	Монгол эх нутаг, уул усаа магтан дуулсан агуулга, бахархсан сэтгэлийн илэрхийлэл,	?
2	Хөгжмийн зохиолын төрөл зүйл	Дуу	?
3	Илэрхийллийн арга, хэлбэр	Шүлэг, аялгуу, хөгжмийн хамсраа, дуулалтын хэв маяг,	?
4	Уламжлал, шинэчлэл	Монгол хөгжмийн уламжлалт 5 эгшигт хөгд бичигдсэн, орчин үеийн хөгжмийн хөнгөн хэмнэл, дуулах арга барилд тулгуурласан.	?
5	Үзэгч сонсогчдын хэрэглээ	Өөдрөг үзэл, оюуны соёлын хэрэгцээ	?
6	Зохиолын үүрэг, ач холбогдол	Монгол хүнд эх орон, хувь заяагаараа бахархах сэтгэлийг төрүүлнэ.	?



Н.Жанцанноров
(1948)

Н.Жанцанноров

“Монгол аялгуу”

Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, хөгжмийн зохиолч Н.Жанцанноров радиогийн “Малчин” нэвтрүүлэгт зориулан “Монгол аялгуу” хэмээх хөгжмөө анх зохиожээ. 1989 онд болсон Морин хуурын анхны их наадам “Монгол аялгуу” зохиолоор нээгдсэн байна.

Морин хуур хөгжмийг тавц хөгөөр буюу “фа-до”-гоор хөглөөд монгол гэр дээр салхинд тавихад маш сайхан хүнгэнэсэн авиа гардаг. Энэ зохиолд “фа-до” давхар эгшигт байнга сонсогдож байгаа нь тохиолдлын хэрэг биш юм.



- ✓ Аялгуунд нь монголын уламжлалт дуу хөгжмийн шинж төрх байна уу?
- ✓ Дэвсгэр хөг фа минор байгаа нь юутай холбоотой вэ?
- ✓ Морин хуурт ямар учраас давхар эгшгүүд тоглогдож байна вэ?
- ✓ Хэмнэлд нь монголын гэсэн онцлог байна уу?
- ✓ Монгол ахуй амьдралын илэрхийлэл хэрхэн тусгагдсан байна вэ?

Энэхүү зохиолыг та бүхэн анхааралтай сонсоод, чухам яагаад “Монгол аялгуу” хэмээн нэрлэсний учрыг хэлэлцэнэ үү.




- Хөгжмийн зохиолч жүжгийн гол дүрүүдийг ялгахын тулд дөрвөн өөр хөгжмийн хэв маягийг сонгосон байна.
- Хөгжмөө анхааралтай сонсоод, дүрүүдийн дуулалтын хэв маягийн ялгааг тодорхойлоорой. (жазз, ардын, сонгодог, поп гэх мэт)



Гол дүр Мөнхөө, Сарнай



Поп стиль



Ургамлын эзэн



?



Усны эзэн, Газрын эзэн



?



Удган мод



?



Ш.Өлзийбаяр
(1977)

Ш.Өлзийбаяр

"Дөрөө" модерн бүжгэн жүжгийн Хос тогорууны бүжиг

Хөгжмийн зохиолч Ш.Өлзийбаяр, цомнол зохиогч Д.Энхбаяр, бүжиг дэглээч Мөнгөнцэцэг нар үндэсний бий биелгээг модерн бүжигтэй хослуулсан шинэлэг өнгө аястай "Дөрөө" бүжгэн жүжгийг туурвисныг бид мэднэ. Энэхүү модерн бүжгэн жүжгийн "Хос тогорууны бүжиг" хэмээх хэсэг нь шувууд эх байгальдаа баясан цэнгэж, хосоороо бяцхан ангахайнуудтайгаа ямар их аз жаргалтай байдгийг илэрхийлжээ.



Adagio

mp

10

16



- Ноот бичлэгийг ажиглаарай. Аялгуунд жигд, үсрэлттэй, давалгаалсан, давтагдсан хөдөлгөөнүүдийн аль нь давамгайлж байна вэ? Чиний бодлоор хөгжмийн зохиолч илэрхийлэлдээ яагаад ийм хөдөлгөөнийг ашигласан бэ?
- Аялгууны дэвсгэр хөг, царааг тодорхойлоорой.
- Ямар хөгжмийн зэмсгүүдээр хөгжимдөж байна вэ?
- Хос тогорууны харилцлыг хөгжмийн зохиолч ямар аргаар харуулсан бэ?
- Хос тогорууны харилцлыг илэрхийлж сэдэв аялгууг хоёр хоолойгоор, канон хэлбэрээр дуулья.

(Канон, асуулт хариулт, регистр, октавын шилжилт, хөгжмийн зэмсэг, харилцан яриа)



Х.Алтангэрэл
(1977)

Х.Алтангэрэл

“Төгсгөлгүй” танго бүжгэн жүжиг

“Төгсгөлгүй” танго бүжгэн жүжигт орчин цагийн залуусын үерхэл нөхөрлөл, хайр сэтгэл, гэр бүл, эцэг эх, үр хүүхдийн бие биенээ харилцан хүндлэх нандин холбоо, ёс суртахууны эрхэм чанарыг дэвшүүлж тавьснаараа ирээдүй хойч үеийн хүүхэд залууст сургамжтай бүтээл болсон.

II бүлгийн II үзэгдэл. Төрсөн өдөрт уригдан ирсэн найз бүсгүйчүүд нь Сүндэрт баяр хүргэн танго* бүжиглэнэ.



Хөгжмийн зохиолч бүжгэн жүжгийн туршид гол үүрэг гүйцэтгэх танго бүжгийн амин сүнс болсон хэмнэлийг шигтгэж өгчээ.

Төрсөн өдрийн баярын уур амьсгалыг бүрдүүлэхэд аялгууны өнгөлөг бөгөөд хурц өгүүлэмж содон сонсогдоно. Сонгодог симфони найрал хөгжмийн бүрэлдэхүүнд аккордион, гитар, саксафоныг оруулж баяжуулсан нь танго бүжгийн өвөрмөц хэв маяг, өнгө төрхийг тодотгож өгөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн танго бүжгийн элементийг сонгодог бүжгийн элементтэй хослуулсан анхдагч гэдэг утгаараа хөгжмийн зохиолч Х.Алтангэрэлийн “Төгсгөлгүй” танго бүжгэн жүжиг орчин цагийн Монголын тайзны уран бүтээлд шинэлэг болж чаджээ.




* Танго (исп. tango). Аргентин үндэстний чөлөөт зохиомжтой, шийдэмгий, эрч хүчтэй, хурц тод хэмнэлтэй бүжиг. “Танго” нь африкийн “бөмбөрийн дуун доорх бүжиг” гэсэн утгатай үгнээс гаралтай. 1910 оноос Америкт 2/4, 4/4 хэмжээтэй “нэг алхамт” (нэг цохилгод нэг алхам) бүжигт энэхүү нэрийг хэрэглэх болсон. Эхэн үедээ танго бүжгийг эрчүүд бүжиглэдэг байснаа хожим хосоор бүждэг болжээ. 2009 онд танго бүжиг ЮНЕСКО-гийн хүн төрөлхтний биет бус соёлын өвд бүртгэгджээ.


Бие даан төрөлжин хөгжиж ирсэн урлагийн төрлүүд харилцан бие биенээ баяжуулан хөгжсөнөөр урлагийн бүхэллэг, төгс чанарыг нээж, таних боломжийг бидэнд олгодог.



- “Төгсгөлгүй” танго бүжгэн жүжигт урлагийн төрлүүд ямар үүрэгтэй оролцсоныг ярилцаарай.
- “Бүжгэн жүжиг бол хөгжмийн зохиол” шийдлээр мэтгэлцээн зохиогоорой. Урлагийн төрлүүд бие даан хөгжиж чадах ч хөгжимгүйгээр оршин тогтнохгүй төрөл бий юу?
- Хөгжмөө анхааралтай сонсоод хэмнэлийн зураглалыг ажиглаарай.
- Доорх хэмнэлүүдээр хөгжимдөөрэй. Аль нь танго бүжгийн хэмнэл вэ?
- Танго бүжгийн бусад бүжгээс ялгарах онцлогийг хөгжимтэй холбон тайлбарлаарай.
- Хөгжмөө сонсоод тохирох хэмнэлийг сонгон хамсран гүйцэтгээрэй.




- Дараах зураглалыг ажиглаарай. Юу илэрхийлж байна вэ?
- Хөгжмийн хэллэгт гарсан хувьсал өөрчлөлттэй холбон тайлбарлаарай.
- Хөгжмийн зохиолын бичлэгийн хэв маягийн талаар толь бичгээс уншаад өөрсдийн мэддэг зохиол дээр жишээ татан ярилцана уу.




Моноди

(дагнамал эгшиглэн)



Полифони

(нийлэл эгшиглэн)



Гомофони

(оройлго эгшиглэн)



- Гомофони бичлэгийн жишээг ноотоор дуулаарай. Та нарын сайн мэдэх бүтээлийн хэсгээс сонгон оруулсан болно. Хэний ямар нэртэй бүтээл вэ?

Гомофони



ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЭСТРАД ХӨГЖИМ

Орчин үеийн эстрад хөгжим

Үзэгч, сонсогчдыг хамгийн өргөн хүрээтэй хамарсан цэнгээний хөгжмийн төрөл бол эстрад хөгжим юм. Хөгжмийн энэ төрөл XIX зууны сүүлчээр үүссэнээс хойш XX зуунд өргөн далайцтай хөгжиж иржээ. Америкийн хар арьстнуудын үндэсний дуу хөгжмийн өвөрмөц аялга, хэм хэмнэл нь орчин үеийн эстрад хөгжмийн үндэс суурь болсон түүхтэй.

Эстрад хөгжим хөгжлийнхөө явцад олон төрөл, урсгал чиглэлээр салбарлан хөгжихдөө Жазз, Рок, Поп гэсэн үндсэн 3 чиг шугамыг барьсаар иржээ. Үүнд ихэнхдээ бүжгийн хөгжим, дууны олон төрөл, эстрад-симфони найрал хөгжимд зориулсан бүтээл болон эстрад хамтлагт зориулсан бүтээл хамаарагддаг.

Жазз

Жазз (Jazz-англиар уухай) бол XIX-XX зууны заагт Америкийн өмнөд мужид амьдардаг африкийн боолчуудын үр сад, хар арьстнуудын ардын дуу хөгжмийн зарим төрөлд үндэслэн үүссэн орчин үеийн хөгжмийн урлагийн нэг төрөл. Америкийн Шинэ Орлеан, Луизиана мужийг жаззын эх орон гэдэг. Жазз нь хөрөнгөтний ёс суртахууны эсрэг чөлөөт сэтгэлгээг эрхэмлэдэг америк залуусын эсэргүүцлийн өвөрмөц дуу хоолой болон хөгжсөн түүхтэй.

Жазз урсгалд Фокстрот, Чарльстон, Танго, Румба, Буги-вуги, Твист, Блюз, Босса-нова, Бибоп, Кантри, Регтайм, Реггей, Ритм-Блюз, Рок-н-Ролл, Биг бэнд гэх мэт төрөл зүйлүүд хамрагддаг. Жаззын үндэс суурь нь:

1. Негр ардын урлагийн нэг төрөл болох хөдөлмөрийн дуу -(Spirituals спиричуэлс-өвөрмөц хөг цомнол, давталтат хэмнэлтэй, сэтгэлийн дээд хөөрлийг илэрхийлдэг арга)


2. Blues- блюз-уйтгар гуниг, сэтгэлийн гансралыг илэрхийлсэн гунигийн дуу.

3. Ragtime- регтайм-адармаатай хэмнэл, чөлөөт аялгат төгөлдөр хуураар хөгжимдөх өвөрмөц арга барил бүхий бие даасан төрөл. Жазз хөгжмийн онцлог нь шууд зохион хөгжимдөх, уламжлалт хөгжмийн зэмсгүүдийг өвөрмөцөөр дуугаргах арга барил, баялаг хэмнэл, хөг аялгын сонин содон дуурьсал юм.



Луи Армстронг
(1901-1971)

Жаззын түүхэнд дуучин, нарийн бүрээч Луи Армстронг, Бенни Гудмен, саксафон хөгжимчин Чарли Паркер нарын нэр мөнхрөн үлджээ. 1920-иод оноос жазз нь хөгжмийн бусад төрлүүдэд нөлөөлж мэргэжлийн хөгжмийн зохиолчид сонат, балет, концерт, дуурь, симфони зэрэг хөгжмийн томоохон төрөлдөө жаззын элементийг оруулах болсон. Дайны дараа жазз хөгжим европт түгэн дэлгэрч “шинэ маягийн амьдралын” бэлгэдэл болсноор “Жаззын эрин үе” хэмээн түүхэнд нэрлэгдэн үлдсэн. Жаззын түүхэн дэх хамгийн шилдэгт тооцогддог хөгжимчдийн гурав нь Шинэ Орлеанаас гаралтай бөгөөд төгөлдөр хуурч Фердинанд, корнет хөгжимчин Жозеф Оливер, мөн нэрт жазз хөгжимчин Луи Армстронг нар юм. 1950 оноос хойш жазз хөгжимд ер бусын айзам хэмнэл, хөг эгшиглэгээ, өнгө аяс хэрэглэгдэж ирсэн.



Блюз-XX зууны эхээр Америкийн өмнөд нутагт бүрэлдэн бий болжээ. Америкийн африк гаралтай хар арьстнуудын хөдөлмөрийн харилцаа дуунаас эх үүсэлтэй. Уйтгар гуниг, сэтгэлийн гансралыг илэрхийлсэн гунигийн дуу. Блюз дуунд гитар, банжо, аман хуураар хамсраа хийж байсан ч ихэвчлэн гитарын аялгуунд уйтгар гунигаа дуулдаг байжээ. Удаан темптэй, догол хэмнэл (синкоп) зонхилсон, утга уянгын дуу юм.

Түрлэг хэсгийг нийтээрээ түрэн дуулдаг.

Гол төлөөлөгчид нь Жесси, Роберт Жонсон, Чак Берри, Б.Б.Кинг нар юм.



Б.Б.Кингийн алдарт “Stand by me” дууг сонсоцгооё.



Скот Жоплин
(1868-1917)

Регтайм - Регтайм хэмээх нэр томъёо нь “тасалдсан хэмнэл” гэсэн утгатай. Эхэн үеийн жаззын төгөлдөр хуураар хөгжимдөх өвөрмөц арга барил бүхий бие даасан төрөл. Аялгууг энгийн хэмнэлээс адармаатай, өвөрмөц хэмнэлээр баяжуулан хөгжүүлдэг тул сонсогчдын сэтгэлийг хөдөлгөдөг.

Регтайм нь XIX зууны сүүлчээр Америкт үүсч Европын орнуудад тархсан.

Гол төлөөлөгч нь Скот Жоплин. Түүний зохиосон “Агч модны навчис”, “Циркийн жүжигчин” зэрэг 600 орчим регтайм бий.



“Агч модны навчис” регтаймыг сонсоцгооё.



Кантри -1930-аад оны үеэс Кантри хөгжим нь хэд хэдэн хөгжмийн төрлүүдээс санаа авч хөгжсөн байдаг. Гол нөлөө үзүүлсэн хоёр төрөл бол европын шилжин суурьшигчдын авчирсан Кельт ардын хөгжим болон ковбойчуудын дуу хөгжим юм. Банжо, гитар, хийл, мандолин зэрэг чавхдаст хөгжмийн зэмсгүүд нь кантри хамтлагуудын хөгжмийн цөм нь болдог. Кантри хөгжим нь эдүгээ Америкийн болон дэлхийн поп урлагийн салшгүй хэсэг болжээ.

Гол төлөөлөгчид: Жимми Роджерс, “Картер фамили” хамтлаг, Жонни Кэш, Гаарт Брүүк, Билли Рэй Сайрус гэх мэт.



Жорж Страйт “Amarillo By Morning” дууг сонсоцгооё.

Рок-н-ролл-Блюз болон R&B хөгжмөөс үүсэж 1950-аад оноос хөгжмийн онцгой төрөл болон хөгжив. Рок-н-ролл нь гол төлөв залуучуудад хандаж, баяр баясгаланг төрүүлэх үндсэн зорилготой байсан. Рок-н-ролл дээр үндэслэн бүжгийн олон шинэ төрлүүд бий болсон ба мөн орчин үеийн рок хөгжим ч эндээс үүсэлтэй.

Гол төлөөлөгчид: Элвис Пресли, Билл Хейли, Эдди Кокран, Жин Винсэнт, Бадди Холли.



Рок -Найгах, чичрэх гэсэн утгатай англи үгнээс гаралтай. XX зууны дунд үеэс олон чиглэл, урсгалд хуваагдан хөгжиж ирсэн. Рок хөгжмийг электрон болон акустик гитар, басс гитар, бөмбөр, цахилгаан даралтат хөгжмийн зэмсэггүйгээр төсөөлөх аргагүй.

Поп -Баруун Европын орнуудад дэлгэрсэн бөгөөд “популярный” буюу олонд алдартай гэсэн үгийн товчилсон хэллэг юм. Поп хөгжмийн урсгал дотроо олон төрөлтэй. 1960-аад онд нэгэн уянгалаг урсгал гарч ирсэн ба түүнийг “Beat” гэж нэрлэх болжээ. “Beat” гэдэг нь “тод аялгуутай, цохих” гэсэн утгатай үг юм. Энэ төрлөөр Битлз хамтлаг анх тоглож эхэлжээ.

Илэрхийлэл сайтай аялгуу



тоглолтын өвөрмөц арга барилаараа 1960-аад оны хамгийн алдартай хамтлаг болсон. Жон Леннон, Пол Маккартни нарын зохиосон 160 гаруй дуу поп чиглэлээр бичигджээ.

Попын гол төлөөлөгчид нь Майкл Жексон, Мадонна, Жастин Тимберлэйк нарын дуучид, Битлз, АББА, Бэкстрит Бойз, Блю зэрэг хамтлаг.



Хип-хоп -1970-аад онд үүссэн гэж үздэг. Шүлэглэн үглэж, дуулж нийгмийн хурц асуудлуудыг дайчин, хурц хэмнэл бүхий хөгжмөөр илэрхийлдэг онцлогтой. Анхандаа түр зуурын маяг, чамирхал хэмээн тооцогдож байсан ч өнөө үед хөгжмийн нөлөө бүхий төрөл болоод байна.

Гол төлөөлөгч нь Ди Жей Күүл Хэрк, Жэй Зи, Эминэм, Кэни Уэст нар юм.



- Цахим ертөнцөөр аялж хамтлаг дуучдын дуулах хэв маягийн талаар мэдээлэл боловсруулж илтгээрэй.

Пол Дезмонд

Take five

Cool jazz-ын төлөөлөгч Пол Дезмонд (англ. Paul Desmond) (1924-1977) жаззын альт-саксофонч, хөгжмийн зохиолч, тэрээр Америкийн Сан Франциско хотноо төржээ. “Take Five” хэмээх алдарт дөрвөлийг зохиосон.

5/4 хэмээх өвөрмөц хэмд бичигдсэн “Take Five” зохиолоо Пол Дезмонд хамтлагийнхаа (1958-1967 оны хооронд оршин тогтнож байсан) цохивор хөгжимчин Джо Мореллогийн гоцлол байхаар бодож туурвисан ч чухам түүний альт саксофоны нэг хэвийн цэвэр тунгалаг, хөнгөн өнгө дуугаралт нь нэрд гаргасан гэдэг. Энэхүү бүтээл сонгодог зохирлын зарчмыг үл эвдэн нэг сэдэв аялгууны дотор өөр нэгэн сэдэв аялгууг хөгжүүлсэн байдгаараа өвөрмөц юм.

Cool jazz нь 1940 оны сүүл үед Америкийн баруун эргийн мужаар үүсэн бий болж би боп стилиэр хөгжимддөг цагаан арьст бопер хөгжимчдийн дунд тархсан. Энэхүү стиль 1960-аад онд хөгжлийнхөө оргилд хүрч байсан ажээ.



“Take five” жазз хөгжмийн зохиолыг сонсоорой.



- Хөгжмийн зэмсгүүдийн өнгө аяс, хөг эгшиглэгээ, үүрэг зориулалтыг ярилцана уу.




- Дараах зураглалыг ашиглан, зохиолын хэсгүүдийг хөгжмийн зэмсгийн өнгө аяс, аялгууны хөдөлгөөнөөр харгалзуулан тодорхойлно уу.


Оршил



В



А



А Гоцлол



Монголын эстрад хөгжим

Богд хаант засгийн үед орчин үеийн үлээвэр хөгжмийн зэмсэг цөөн тоогоор хаант Орос улсаас ирж байжээ. Тэр цагаас Монгол улсад үлээвэр хөгжим үүсэж хөгжсөн гэж үздэг бөгөөд үлээвэр хөгжимгүй баяр ёслол, арга хэмжээ байхгүй болж 1940-50-иад оны үед “дагшаа” гэсэн үг олонд дэлгэрчээ.

Улсын эстрад концертын товчоо 1945 онд үүсч, түүний дэргэд 1948 онд Жазз дагшаа найрал хөгжим байгуулагдсан нь Монголын Жазз, Рок, Поп хөгжмийн түүхэн замналын эхлэл гэж үздэг.

1969 онд Монголын Радиогийн дэргэдэх “Баянмонгол” чуулга, 1970 онд Монголын Рок, Поп хөгжмийн анхдагч “Соёл-Эрдэнэ” хамтлаг, түүний дараагаар “Соёмбо”, “Дөмөн”, “Залуус”, “Айзам”, “Оч”, “Өргөө”, “Мөнгөн харандаа” зэрэг олон арван хамтлагууд төрөн гарчээ.

1970-1990 он хүртэл “Мөнгөн хүрхрээ”, “Хилчин”, “Инээмсэглэл”, “Үүрийн туяа”, “Өчигдөр өнөөдөр”, “Нэмэх хасах”, “Цирк”, “Харш”, “Аясын салхи”, “Харанга”, “Хонх”, “Хурд”, “Пауз”, 1990-ээд оноос “Хөх тэнгэр”, “Титэм”, “Хар сарнай”, “Цагаан тал”, “Хар чоно”, “Чингис хаан”, “Никитон”, “Хар тас”, “Шигтгээ”, “Камертон”, “Нисванис”, “Номин талст” хамтлагууд байгуулагджээ.



- Монголын эстрад хамтлагуудыг тоглож байгаа хэв маягаар нь ангилсныг ажиглаад хамтлагуудыг нэрлээрэй.



Поп рок - ?



Регги - ?



Хард рок - ?



Спид метал рок - ?



Поп техно - ?



Прогрессив рок - ?



Арт рок - ?



Кантри - ?



Техно реп - ?

Монгол ретайм. XX зуунд "шинээр бүтээе" уриан дор янз бүрийн уран сайхны чиглэл гарч ирсэн нь өмнөх уламжлалаас өвлөн авснаа шинэлэг арга барилаар баяжуулахыг зорьж байлаа. Зарим уран бүтээлчид хөгжмийнхөө уламжлалыг сэргээн хөгжүүлж, ардын дуу хөгжим рүү хандаж, хөгжмийн хэллэг, хэмжээ хэлбэр, төрөл зүйл, зохиомж, бичлэгийн арга барилд эрс өөрчлөлт хийв.

Хөгжмийн зохиолч, жазз хөгжимчин, багш Төмөрийн Дамдинсүрэн жаззын төрлөөр олон бүтээл туурвиж найруулснаас гадна монголд анхны "Dixielend" барилыг дэлгэрүүлсэн юм. Мөн орчин үеийн жазз хөгжмийн сургалтын онол арга зүйн анхны сурах бичгийг зохиосон билээ. Тэрээр сонсогчдын дунд ардын дуу мэт түгсэн З.Доржсүрэнгийн "Ижилдээ ганцхан шарга морь" дууг орчин үеийн жазз хөгжмийн өвөрмөц арга барилаар хөгжүүлэн уламжлал шинэчлэлийг хослуулсан юм.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хэмнэлийн задаргаа, аялгууны боловсруулалт, хөгжмийн өрнөлийг сонсож, ноот бичлэгээс ажиглаж харьцуулж ярилцаарай.



Аялгууг З.Доржсүрэн

Жазз зохиомжийг Т.Дамдинсүрэн

Ижилдээ ганцхан шарга морь



- Уншаад орчин үеийн страд хөгжмийн ямар төрөл болохыг тодорхойлоорой.

?	?	?	?	?
Хар арьстнуудын ардын дуу хөгжмийн зарим төрөлд үндэслэн XIX-XX зууны эхэн үед үүссэн орчин үеийн хөгжмийн нэг төрөл.	Африк гаралтай хар арьстнуудын хөдөлмөрийн дуунаас эх үүсэлтэй хөгжмийн уламжлалт төрөл, удаан темптэй, утга яангын дуу.	Эхэн үеийн жаззын төгөлдөр хуураар хөгжимдөх хэлбэр.	Эргэлдэх, өнхрөх, найган ганхах гэсэн утгатай англи үг. Америкийн хар арьстнуудын хөгжим болох блюз, хөдөөгийн ардын дуу хөгжмийн нэгдэл дээр суурилан бий болсон хэв маяг.	Бийт, Диско, Нью романтик, Реп, Реггей, Серф, Ска гэх мэт төрлийг өөртөө багтаасан баруун Европын орнуудад ихэд дэлгэрсэн эстрад урлагийн төрөл.

Хөгжим сонсоцгооё

Дуучин Уламбаяр (Ука)

Уул

Аадар салхин дунд амьдрал хагацлын гүнд
 Агуу бас үнэн хоёр нь хувиршгүй
 Бодлын энэ ууланд бүх ертөнц оршино
 Тэнд надтай тэнгэрийн сар хайр дуулдаг юм
 Ээжийн бүүвэй энгэрийн салхинд сонсогдоно
 Эцгийн минь захиас илбэн цуурайтна
 Ээлжлэх улирлын гоо үзэсгэлэн оргилд нь бий
 Эргэх хорвоод юу үнэтэйг тэнд олох вий
 Хайртай учраад хязгаарлагдах мэт
 Гэвч хайр хязгааргүй, би мэдээгүй
 Халил оргилд байхыг чи хүсвэл
 Хормой бэлийг нь тэнд мэдрээрэй

Дуучин Б.Сарантуяа. МУГЖ,
 Б.Чойжилсүрэн

Хаврын ганц улиас

Хаврын ганц улиас нь хө
 Хайрыг минь хүлээн суугаа
 Наран цаашлах нээ цагаар
 Навчнаа хийсэн одноо
 Дуулан дуулан цангинана, зангирна
 Дуундаа дурланхан сууна

Дуучин Т.Бат-Оргил

Аж богдын харуул

Аж богдын харуул нь ээ хө
 Амгалан болоод тайван даа
 Албанд мордсон хүү тань аав минь ээ хө
 Амар болоод эсэн мэнддээ

Баруун чих минь хангинаад байх чинь хө
 Багын найз минь дурсаа юм болов уу
 Бээс ноёны бошго нь үгүй ч болоосой
 Бургаст голдоо дахин очих юм сан

Дууны уран бүтээлд мэргэжлийн хөгжмийн зохиолчдын бүтээлээс эшлэх нь бий.

- “Уул” дууны аль хэсэгт та бүхний сайн мэдэх хөгжмийн бүтээл эгшиглэж байна вэ?
- Л.Мөрдоржийн “Алтан өргөө” киноны хөгжмөөс ашигласан ямар дууг мэдэх вэ?

- Дахилтын хэсэгт орчин үеийн хөгжимд ардын хөгжмийн зэмсгүүд хэрхэн нийцэн эгшиглэж буй талаар ярилцаарай.
- Өгөгдсөн аккордыг дууны шүлгийн тохирох хэсэгт байрлуулж хөгжимдөнө үү.

Am, Em, F, Dm, Em, Am, Am, Em, F, Dm, Em, Am, F, G, Am, D, F, G, Am

- “Аж богдын харуул” дууны аккордыг гитар хөгжим дээр тоглоорой.
- Дуугаа сонсож, аялж үзээд тохирох аккордыг зөв дарааллаар сонгон хөгжимдөөрэй.
- **C, F, G, Am, Dm, Em**



- Дуунуудыг сонсоод, орчин үеийн эстрад хөгжмийн ямар урсгал, чиглэлээр дуулж байгааг тодорхойлно уу? Найзуудтайгаа саналаа хуваалцаарай.
- Дуу тус бүрийн бүтцэд тохирох үсгэн томъёоллыг сонгоорой.

A AB ABC

- Монголын хамтлаг дуучдаас сонгож, ямар урсгал, чиглэлээр уран бүтээлээ туурвиж байгаа талаар мэдээлэл цуглуулж, танилцуулга бэлтгээрэй.

Хамтдаа бүтээцгээ

- ✓ Ноотны жишээ 1, 2-ын эгшгийн хөдөлгөөн, дарааллыг анхааралтай ажиглаж зүй тогтлыг олох.
- ✓ Ноот бичлэгийн дагуу аялгууг дуулж үзээд, бие биенээсээ ялгагдах онцлогуудыг тодорхойлох.
- ✓ V жишээг ямар хувиргалын тэмдэг хэрэглэн гунигтай болгон өөрчилж болохыг турших.
- ✓ Өөрийн сайн эзэмшсэн хөгжмийн зэмсгийг сонгон, аялгууг хөгжимдөх.

Өгөгдсөн ноотны жишээнүүдийг анхааралтай ажигла. Зааврын дагуу туршаад үзье

Жишээ: 1


Жишээ: 2

Жишээ: 3

Жишээ: 4

Жишээ: 5

ДУУЛЪЯ



Сургуульдаа өргөх дуу

Үг, Ая С.Жамъянхорол

Дунд зэрэг

5 Наран ургах - аар мэл-мийг минь бая - суул - сан Нам-айг дуу-лан

11 эрд-мийн замд хө-төл - сөн Хү-сэд мөрөөд-лийн хар-гуйг тод-руул - сан Хүүх-дийн и-нээд

18 хонх-ны дуу-тай сур- тууль- минь Мянга мян-гаг төг-сөг-чийг ха-вар-тай үд - сэл

24 Мянга мян-гаг алд-райх-ныг на-мар-тай угт - сан аа _____

_____ Ар-цуп эрд-мийн гэ-гээг са-руул өр - гөө _____ минь

Намуухан төрхтэй яруухан дуутай
 Насанд минь мартаггүй оюуны сургаалтай
 Үе үеийн шавьтайгаа он цагийг үдсэн
 Үлдсэн алдар, дуудах нэртэй багш минь ээ

Мянга мянган төгсөгчийг хавартай үдсэн
 Мянга мянган алдрайхныг намартай угтсан
 Аа аа аа аа
 Алтан номын амьд бурхан багш минь ээ

Сайхан бүхнийг багш минь надад хэлж өгсөн
 Саруул бүхнийг сургууль минь надад зааж өгсөн
 Даль жигүүр ургасан түмэн төгсөгч нь
 Далай орондоо гэгээн оюунаа зориулдаг юм



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийг ажиглаад, холын үсрэлтүүдийн хоорондох интервалыг тодорхойлоорой.
- Хэмнэлийн онцлогийг ажиглаад, алга ташилтаар илэрхийлээрэй.
- Дуу ямар хөгд бичигдсэн байна вэ?



Сартай хүрэн
Монгол ардын дуу

Найруулга Ц.Түмэнбаяр

Moderate

mp
Сар - тай хүр - ний - гээ ун - аа - даа хо Сай - хан

6 са - яаг - юу - гаар ир - шэ ай хө яах вэ ай хө *pp*

1.2. 3.

Ачаатай цагаан тэмээгээрээ хө
Алсын аянд гүйлгэнэ ай хө
Амраг бяцхан Соёнбээрээ минь
Алчуураа даллах биш яах вэ ай хө

Хомтой цагаан тэмээгээрээ хө
Холынхоо аянд гүйлгэнэ ай хө
Хонгор бяцхан Соёнбээрээ минь
Хуруугаар даллах биш яах вэ ай хө



- Дууны төгсгөлийн хувилбарууд хоорондоо ямар ялгаатай байна вэ?
- Дараах өгөгдлийн дагуу дууныхаа ноотыг ажиглаарай.

1

Хэм, хэмжээ

2

Аялгууны чиглэл

3

Эгшиг хоорондын
зай

- Дараах хэмнэлийг алга ташилтаар илэрхийлээрэй.
- Хоолой тус бүрийн хэмнэлийн зураглал ямар ялгаатай байна вэ?



Сурагчийн дурсамж

Үг. П.Наранцэцэг

Ая. Г.Отгонбаяр

Andante C Am F Dm

Баяс- лыш са-руул эрд-мийн өр- төөнд Бал-чир- хан пайз-тай-гаа

4 G C Am

зэ-рэг- цэн суу- гаад. Бал- шийн за-сан хя - чээл бү- рийг Баяр

7 F Am G F G

хоор- тэй-гөөр шим-тэл су - ралш - сан Сар шай цэн - гийлэнхл-луун баг- лаар

10 Em Am F Dm G C V

Су-рагч бү-хэн багш-даа ба - риал Сур-гуу- лийн хаал-гаар шуу-гин о- рох - доо

13 F G Em Am V

И-лээд хөө - роор дүү - рэн бай - гаа Эр - домг бяц - хан су - рагч ү - сэ

15 Dm G C V

Эр - гээд сана - хал цэг - л дур - самж - тай

Хязгааргүй тэмүүлэх хүслийн өргөөнд
Хайрын зурвас нууцхан илгээсэн
Үерхэл нөхөрлөлийн гэгээн өдрүүд
Үүрд бидэндээ дурсагдан үлдэнэ

Дахилт:

Шүүдэрхэн эрдмийн алтан ордонд
Шинэхэн жигүүрээ дэлгэн дэвээд
Сүүлчийн мөнгөн хонхны дуугаар
Сурагч насаа үлдээж нислээ

Дахилт:



- Хэмнэлээр тогшиж, цэгтэй ноотны хэмжээг зөв илэрхийлээрэй.
- Ямар хөгд бичигдсэнийг тодорхойлоорой.
- Ялган тэмдэглэсэн хэсгийг нуман холбоостой, холбоосгүй 2 янзаар дуулж, ялгааг тайлбарлаарай.



- Дуулахдаа ноотны тэмдэг тэмдэглэгээг анхаараарай.
- Хоршиж байгаа өнгөө сайн сонсч, удирдаачийн гарыг анхааралтай харж дуулаарай.



Sing sing sing

Луи Прима

Sing, sing, sing, sing ev-'ry-bod-y start to sing like dee dee dee, bah
 bah bah dah. Now you're sing-in' with a swing Now you're sing-in-like
 ev-'ry- thing When the mus-ic goes a round. ev-'ry-bod-y's gon-na go to town.
 But here is one thing you should know; sing it high and sing it low Oh, sing, sing,
 sing, sing, ev -'ry-bod - y start to sing like dee dee dee, bah
 bah bah dah. Now you are sing-in' with a real good swing

Луи Прима (1910-1978) - Итали-америкийн дуучин, хөгжимчин, хөгжмийн зохиолч, жүжигчин. Тэрээр “The New Orleans Gang”, “The Gleeby Rhythm Orchestra”, “The Witnesses” хамтлагуудыг үүсгэн байгуулалцаж, уран бүтээлээрээ алдаршин, рок – н- ролл, R&B гээд орчин үеийн хөгжмийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулжээ.

Түүний алдартай дуунуудаас “Just A Gigolo (I Ain't Got Nobody)”, “Sing, Sing, Sing”, “Jump, Jive An' Wail”, “St. Louis Blues”, “Buona Sera”, “Five Months, Two Weeks, Two Days”, “Hey, Boy! Hey, Girl!”, “Oh, Marie”, “Bourbon Street Blues”, “The Lip” зэргийг нэрлэж болно.

“Sing, Sing, Sing” хэмээх дуу нь чухам “Свингийн хаан” гэгддэг Бенни Гудмены жазз найрал хөгжмийн хамтлагийн уран бүтээлд зэмсэгт хөгжмийн найруулга маягаар эгшиглэн алдаршиж, свингийн эрин үеийн сүлд дуулал болж байжээ.



What a Wonderful World

Bob Thiel

F Am B⁷ Am Gm⁷ F

I see trees of green, red ros-es too, I see them bloom

5 A⁷ Dm D⁷ C⁷ F

for me and you, and I think to my-self WHAT A WON-DER-FUL WORLD

9 Bbmaj⁷ C⁷ F Am B Am Gm⁷ F

I see skies of blue and clouds of white, the bright-bles-sed day, the

13 A⁷ Dm Db C⁷ F

dark sac-red night, and I think to my-self WHAT A WON-DER-FUL WORLD

The colors of the rainbow so pretty in the sky
 Are also on the faces of people going by
 I see friends shaking hands saying how do you do
 They're really saying I love you
 I hear babies crying, I watch them grow
 They'll learn much more, than I'll never know
 And I think to myself what a wonderful world
 Yes I think to myself what a wonderful world



- Дууны аялгуу хэд дэх хувиас эхэлж байна вэ?
- Дэвсгэр хөгийг тодорхойлоорой.
- Хэмнэлийн онцлогийг мэдэрч дуулаарай. Дуулахдаа хэмнэлийн өөрчлөлт, ялгааг анхаараарай.



- Аялгууны XIII айзмын хэмнэлийг ажиглаад, тоглож үзээрэй.
- Аялгууны аккордыг гитар болон төгөлдөр хуур хөгжмийн зэмсгээр тоглоорой.



• Дуулахдаа ноотны тэмдэг тэмдэглэгээг анхаараарай.



Хотын гэрэлт гудамжаар

Үг. Я.Энхээ

Ая. Г.Энхбаяр

5 E A

Бо-лор го-лид ту- сах сар-ны ту-яа шиг хурц-хан

9 E E A

Чимээ-гүй мэл-мэрэх ус- пы мөн-гөө бөр-гөө ца- цаад

13 G4m C2m F2m 117 E

Чийг-лэг сэр-үүн а- гаарт нэ-гэг-сийн үнэр ханхал на

17 E F4m 117 G4m A

Ха-ран-хуй үд-шийн бү- рийд Ха-рах-нү-дээ баяс- гаад

21 G4m G2 C2m F2m 117 1,2, E

Хо тын го-рэлт гу-дам- жаар ал-халж я-вах сай- хан

25 3. F2m 117 E F4m 117 E

ал-халж я-вах сай- хан ал-халж я-вах сай-хан

Орой үдшийн намуунд анир чимээгүйг цочоож
 Одод нисэв үү гэлтэй замын машин хүнгэнээд
 Урсан нисэх аялгуу нээлттэй цонхоор нэвтрээд
 Уянга хүргэх салхиар моддын орой ганхана



Ж.Гершвин

"Порги, Бесс хоёр" дуурийн Summertime

Sum-mer- time and the liv-ing is eas - y, Fish are jump- in;
 7 And the cot-ton is high Oh, your dad-dy's rich And your ma is good
 12 look - in; So hush, lit-tle ba-by, don't you cry


"Порги, Бесс хоёр" дуурь нь XX зууны хөгжмийн урлагийн эрдэнэсийн санд зүй ёсоор орсон Ж.Гершвиний томоохон бүтээлийн нэг төдийгүй, хөгжмийн түүхэнд Америкийн анхны үндэсний дуурь хэмээн мөнхөрсөн юм. Энэ дуурьт америкийн хар арьст оршин суугчдын ядуу тарчиг амьдрал, тэдний өвөрмөц ахуй нөхцөл, дотоод ертөнцийг анх удаа дэлгэн харуулж, нийгмийн эмзэг асуудлыг хөндсөнөөрөө онцлог. Дуурьт эрэмдэг, ядуу залуу Порги, царайлаг бүсгүй Бесс нарын хайр сэтгэлийн тухай өгүүлнэ. Дуурийн хөгжмийн хэллэг нь маш баялаг бөгөөд дуун өгүүлэмж давамгайлсан байдаг. Ж.Гершвин энд африк гаралтай америкийн хар арьстнуудын ардын урлагийн блюз, спиричуэлсын хэмнэл, аялгуу дуурьслын онцлог болон жаззын илэрхийллийн аргуудыг өргөн ашигласан.

Уг дуурьт Кларагийн уянгалаг бодрол дуу (ари), Порги, Бесс хоёрын хайр дурлалын хоршил (дуэт) зэрэг яруу сайхан, энхрий зөөлөн аялгаараа гайхам хэсгүүд бий.



- Хөгжмөө анхааралтай сонсоод загварын дагуу харьцуулалт хийж ярилцаарай.

Зохиолын нэрс	Хэв маяг (стиль)	Хэмнэл (ритм)	Аялгууны шинж төрх	Өнгө аяс (тембр)	Хөгжмийн зэмсэг
Ж.Гершвин "Summertime"					
Ж.Леннон "Yesterday"					



Чин хүсэл

Үг. Ц.Хүсэлбаатар

Ая. Г.Эрдэнэбаатар

Allegro ♩ - 160

Нар-лы тунга-лаг тэ-гээг ту - яа дэл-хийг гий-гүү- лээд Навч-лы шүү-дэр
6 бөн-жиг-нөн-хөн со-лонго-рох сайх- наа Ой тайга минь цэн-хэр-тэн-хэн
11 у-шиар хө-шиг- рөөд О-лон тү-мэл бид бүг-дээ-рээ ба-яр жар-гал- тай
17 Ой тай - га нь цэн-хэр- тэн у - шиар хө-шиг- рөөд О-лон тү-мэл
22 бү-гдээ- рээ ба-яр жар-гал- тай



Цэнгэлтэй эрвээхэй нисэн нисэн эргэлдээд
Цэнхэр горхи нь шулганан шоржигнон наадна
Навчит мод нь найганхан ганхан шивнэлдээд
Нарлаг хорвоо дэлхийдээ баяр жаргалтай

Номин тэнгэр нь үеийн үед цэлмэг байгаасай
Ногоон ой минь үрийн үрд тайван байгаасай
Цэцэгс жимс нь үргэлж мөнх дэлгэрч байгаасай
Цэнгэлтэйхэн ой хөвч минь тайван байгаасай



- Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалахад хүүхэд бид ямар хувь нэмэр оруулж болох талаар ярилцаад, уриалга бичиж хэрэгжүүлээрэй.
- Хэмнэлийн хүндрэлтэй хэсгүүдийг тодорхойлоод хэсэгчлэн давтаарай.
- Шүлгийн утга санаанд тохируулан ноотны дээр хүчдэлийн тэмдэг тавиад дуулж үзээрэй.



Монголын хүүхдийн дуулах дуун

Үг. Ш.Бадарч

Ая. С.Батболд

Хөгжилтэй

7 Тэнгэ-рийн на-рыг бүл-тэг- нүүлж Тэр-гэл са-рыг бөн-бөг- нүүлж

11 О-дод эрхэ-сийг тор- мол-зуулж Орч-лонг бөм-бор-тол мэл-мэ- рүүлж байна

15 Цэнгэ-лийн ман-лай баяс-га-лан Цэ-цэгт дэл-хийн жар-га-лан

Монго-лын жавх-ланта ү-сийн-хэн- Морьд эр-гэ-гэл дуулж байна

Хөх тэнгэрийг хөвсөлзүүлж
Хөлгөн уулсыг хөндөлзүүлж
Мөрөн голыг дөмөлзүүлж
Мөнхийн жаргалыг цэлэлзүүлж

Дахилт

Дээдсийн сүрийг өндөлзүүлж
Дэлхийн чихийг дэлдэлзүүлж
Долоон бурхныг доргиулсаар
Дорнын Монголыг догдлуулж байна

Дахилт



- Хэм өөрчлөгдөж байгаа хэсэгт багшийн гарын дохиог анхаарч дуулаарай.
- Хоёр хоолойн дасгалыг дуулахдаа холын үсрэлтүүдийг гарын дохио ашиглан зөв мэдэрч дуулаарай.





Edelweiss

Oscar Hammerstein II

Richard Rodgers

Moderato

C G⁷ C F C Am⁷ Dm⁷ G⁷ C G⁷

mp E - del - weiss, e - del - weiss, Ev - ery morn - ing you greet me. Small and white,

11 C F C G⁷ C G⁷ C

Clean and bright, You look hap - py to meet me. Bos - som of snow, may you bloom and

20 F D⁷ G G⁷ C Gm⁶

grow, Bloom and grow for - ev - er. E - del - weiss, *mp*

bloom and grow, E - del -

27 F⁷ A Fm⁷ A C G G⁷ C

E - del - weiss Bless my home - land for - ev - er.

weiss E - del - weiss, Bless my home - land for - ev - er



- Үгийн дуудлага зөв, цэвэр байхад анхаарч, хэмнэлийн хамсраатай гүйцэтгээрэй.
- Хоёр хоолойгоор дуулах үедээ бусдыг сонсож, багшийнхаа гарын дохиог анхаарна уу?
- Дуугаа дуулахдаа гитараар хамсран хөгжимдөөрэй.
- Хөгжимдөхдөө аккордын тэмдэглэгээг анхаараарай.



Paul McCartney

John Lennon

Yesterday

Yes - ter - day all my troub - les seemed so far a - way

Yes - ter - day all my troub - les seemed so far a - way so

Yes - ter - day all my troub - les seemed so far a - way so

Yes - ter day so far a - way so

Now it looks as though thre'here to stay. Oh I be - lieve - in yes - ter - day -

far a way. Oh I be - lieve yes - ter - day -

8

Why she had to go I don't know she would - n't say.

Why she had to go I don't know she would - n't say,

2

12

I said some-thing wrong, now I long for yes - ter - day.

I said something ver-y wrong, wrong, now I long for yes - ter - day.

I said some - thing wrong, wrong, now I long I long for yes- ter - day

long for yes - ter - day

16

Yes-ter-day love was such an cas-y game to play Now I need a place to

Yes-ter-day love was such an cas-y game to play and now I

Yes-ter-day love was such an cas-y game to play and now I

love was such a game to play and now I

20

hide a way Oh I be- lieve in yes-ter- day, hm hm Yes-ter- day!

hide! Oh I be- lieve yes-ter- day, hm hm Yes-ter- day!

hide! Oh I be- lieve yes-ter- day, hm hm Yes-ter- day!

ХӨГЖИМДЬЕ

Ц.Чинзоригийн "Хорвоод ганцхан ээждээ" дууг гитараар хөгжимдөөрэй.



- Дууныхаа утга агуулгад тохируулан тохирох хэсэгт нь хүчдэлийн тэмдэг тавиарай.
- Баруун гарын цохилт, таталтын аль нэгийг сонгож тоглоорой.
- Аккордын тэмдэглэгээг харж хамсран хөгжимдөөрэй.


- p.i.m.a - хуруугаар татаж тоглох
- Цохиураар (Пик) дээш, доош чиглэлээр тоглох. ↑ ↓



- Өгөгдсөн 5 эгшиг болон хэмнэлээр аялгууг гүйцээж зохиож бичээрэй.

Аккорд тоглох

Гитар хөгжим дээр аккорд тоглохдоо тусгай тэмдэглэгээг хэрэглэдэг. Энэ нь хэддүгээр үе дээр аль хуруугаараа тоглохыг тэмдэглэхээс гадна, хэддүгээр чавхдасыг дуугаргаж тоглохыг зааж өгдөг. Жишээлбэл: До мажорын тоникийн аккордыг анхааралтай ажиглаарай.



- C - аккордын нэр
- X - чавхдасыг тоглохгүй
- - чавхдасыг хуруугаар дарахгүй сул тоглоно.
- ① I үелээс дээр, I хуруугаар тоглоно.
- ② II үелээс дээр, II хуруугаар тоглоно.
- ③ III үелээс дээр, III хуруугаар тоглоно.



- Гитараар тоглох дууг дэвсгэр 5 шугам, TAB дээр тэмдэглэхээс гадна дууны шүлгийн дээд талд үсгэн тэмдэглэгээгээр бичиж болно. Хүүхдүүд та нарын сайн мэдэх “Нарны унага” киноны дууны шүлгийн дээр аккордын тэмдэглэгээг орууллаа.
- Дуугаа тоглохын өмнө дараах баруун гарын дасгалыг тоглоорой.









Үг Г.Жигжидсүрэн

Ая З.Хангал

"Нарны унага" киноны дуу

Am CM7
 Намрын бороо та юу шивнэв
 Am A7 Dm
 Навчис цочоож та юунд шиврээ вэ?
 Dm G7 CM7 A7
 Настай ээжийн минь сургаал үгийг
 Dm Em Am A7
 Надад та шивнэн дамжуулав уу?

Намрын бороо та юу шивнэв
 Навчис цочоож та юунд шиврээ вэ?
 Унаган нутгийн минь танил аялгууг
 Уянга дуутай хослон эгшиглэв үү?



“Хайрын түүх”

Гитарын хоршил



- Нуман холбоос, арпеджио, I вольт, II вольт, зогсоцын тэмдэг, хувиргалын тэмдэг, дахилтын тэмдгийг анхаарч тоглоорой.
- Хоолой тус бүрийн ноотыг маш сайн тоглож сурсны дараа хамтран хөгжимдөөрэй.
- Хамтран тоглох үедээ бусад сурагчдыг сайн сонсоорой.

Г1

Г2

Г1

Г2

6

10

"Элизад"

Гитарын хоршил



- Ноотон дээрх тэмдэглэгээнүүдийг анхааралтай ажиглаж, үүргийг тодорхойлоорой. Жишээлбэл: (p) болон (mf) тэмдгүүд
- 1 болон 2 дугаар гитарын ноотыг сайн ажиглаад, олж харсан зүй тогтлынхоо талаар найзуудтайгаа ярилцаарай.
- Өөрийн хөгжимдөх хэсгийг маш сайн давтаарай.
- Хоёр хоолойгоор хөгжимдөх үедээ бие биенээ сайн сонсож, багшийн гарын дохиог сайн анхаараарай.

САНАМЖ:

Эхний хоёр шугаманд 1, 2 дугаар гитарын ноот, дараагийн хоёр шугаманд 1, 2 дугаар гитарын tab бичигдсэн.

Ноотоо анхааралтай ажиглаад, олон давтагдаж байгаа хэсгийг ижил өнгөөр зурж тэмдэглээрэй. Энэ нь давтагдаж буй хэсгүүд дээр дахин ноот, гитарын тэмдэглэгээн дээр ажиллахгүй дараагийн ноотондоо шилжихэд тусална.

Moderato

Г1

Г2

TAB 3/4

Г1

TAB 3/4

Г2

6

1. 2.

TAB 2 7 3 2 2 0 7 2 0 2 0 4 2 7 0 1 3 0 1 0 3 0 3

TAB 0 2 2 7 2 1 0 0 2 2 7 0 2 2 7 0 1 7 3 2 0 7 3 2 0 7

2

12

TAB 1 3 1 0 7 7 0 4 4 0 4 0 4 0 4 0 3 1 2 7 2 2

TAB 0 2 2 7 2 0 0 2 7 7 2 2 7 7 2 2 7 7 0 2 2 7 0

18

TAB 0 7 2 1 0 1 7 2 4 4 0 0 3 1 2 7 3 2 2 0 7 2 2 2

TAB 2 1 0 0 2 2 7 0 0 2 2 7 0 2 2 7 2 1 0 0



- Айзмын эхний эгшгийг **p** хуруугаар тоглоно.
- Гурвал эгшгийг **i, m, a** хуруугаар зэрэг татаж тоглоорой.
- "Сюзанна" дууны аккордыг тоглохдоо энэ дасгалаа ашиглаарай.
- Сонирхлоороо 3 хэсэгт хуваагдан "Сюзанна" дууны 1, 2 дугаар гитар болон аккордын ноотыг хамтран хөгжимдөөрэй.



С.Фостер

Сюзанна

гитарын хоршил

Chord diagrams: G, D, G, D7, G

Chord diagrams: G, C, G, D7

2/4

G D⁷ G G

TAB A/B: 0 3 3 0 | 3 0 0 2 | 0 0 2 2 | 0 0 |

TAB B/B: 3 2 | 0 0 | 0 0 | 3 3 0 2 | 3 0 0



- Дууны шүлгийг уншаад, чухал гэж бодсон утга санааг өөрийн үгээр баяжуулан дэвтэртээ бичиж, найзуудтайгаа саналаа хуваалцаарай.
- Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх талаар өөрийн хийж чадах зүйлсийн жагсаалт гаргаж хэрэгжүүлээрэй.

Дэлхий ээж

Үг. Г.Мэнд-Ооёо

Ая. Р.Энхбазар

Am C
Эзэн бидний алтан хөмрөг
Dm E7 Am
Энгүй тансаг байгальдаа хайртай
Dm G C Am
Эрин зууны наран дэнлүү
Dm E7 Am
Эрдэмт хүний бүтээлд хайртай

F G C Am
Хүн төрөлхтнийг хэвлээсээ төрүүлж
Dm G C
Хүүгийн ёсоор элгэндээ тэвэрсэн
Dm E7 Am
Дэлхий ээж тандаа бид хайртай
Dm G C Am
Дэлхий ээж тандаа хайртай болохоор
Dm E7 Am
Дэлхий ээж та мөнх настай

Түмэн үеийн баатарлаг туульс
Төгөлдөр баян түүхэндээ хайртай
Онъсон хөлгөөр орон зайг ялсан
Оюун билигт хүмүүст хайртай
Дахилт:



- 4 хоолойн ноот тус бүр ямар онцлогтой байгааг анхааралтай ажиглаж ярилцаарай.
- Хоолой тус бүрийг тоглож үзээрэй.
- Бүх сурагчид өөрийн хэмнэлийг алдаагүй тоглож сурсны дараа хамтлагаараа хөгжимдөөрэй.

бөмбөр

дуут мод

маракас

бонго



Маракас

Латин америкийн цохивор хөгжмийн зэмсгүүдийн нэг. Хулууны хальсаар хийдэг шигшүүрэг бөгөөд хосоор нь тоглоно. Сэгсрэлтийн хүчнээс хамаарч чанга аяар дуугарна. Хоёр гараараа зэрэг эсвэл ээлжлэн сэгсэрч хөгжимдөнө.



- Дараах хэмнэлийг тоглоход хүндрэлтэй байгаа хэсгийг тэмдэглээрэй. Яагаад хүндрэлтэй байгааг ярилцаарай.
- Ямар хэмнэл олон удаа давтагдаж байна вэ?



- Аялгуунд яагаад эдгээр тэмдэглэгээнүүд бичигддэг вэ?
- Тэмдэглэгээ тус бүрийн үүргийг тодорхойлж, дэвтэртээ бичээрэй.

Фермато

Легато

Стаккато

Крешендо

Пианиссимо






















Меццофорте

Дөрөвт ноотны зогсоц

Триоль

Наймт ноотны зогсоц

Гитарын аккордууд



Хавсралт

Арнольд Шёнберг

Австрийн хөгжмийн зохиолч, хөгжимд экспрессионист урсгалыг үндэслэгч, “Шинэ венийн дэг сургууль”-ийн төлөөлөгч гэдгээрээ түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Хөгжмийн боловсролыг бие даан эзэмшиж, хөгжим зохиох болсноор “Гэгээн шөнө”, “Пеллеас Мелизанда хоёр” найраглал зэрэг анхны бүтээлүүд нь төрсөн байна. Хөгжмийн зохиолч А.Шёнберг 12 эгшгийн тогтолцоо, хөг үгүйсгэлийн зарчмыг үндэслэж, түүндээ тулгуурлан цөөхүүл симфони, “Хүлээлт” монодрам, гоцлол дуучин, цөөхүүл чуулгад зориулсан “Пьеро саран” зэрэг бүтээлүүдээ туурвисан юм. А.Шёнбергийн уран бүтээл нь орчин үеийн хөгжмийн хөгжилд хүчтэй нөлөө үзүүлсэн. Тэрээр багш, сурган хүмүүжүүлэгч байсан бөгөөд хэд хэдэн үеийн хөгжмийн зохиолчдыг бэлтгэн хүмүүжүүлсний дотор хөгжмийн зохиолч А.Берг, А.Веберн нар ордог.

Жорж Гершвин

XX зууны 20-иод оныг джаз хөгжмийн эрин үе гэж нэрлэдэг. Тэр жилүүдэд америкийн бүх урлаг жазз хөгжмийн гоо зүйн нөлөөн дор оршиж байлаа. Америкийн бүхий л хотууд жазз хөгжмийн үй олон чуулга, хамтлагаар бялхаж байв. Тэд чуулгынхаа бүрэлдэхүүнийг симфони найрал хөгжмийн зэмсгээр баяжуулан өргөтгөх болов. Ийнхүү холимог маягийн симфони-жаззын үүсэл тавигджээ. Симфони жаззын нэрт төлөөлөгч бол Америкийн хөгжмийн зохиолч Жорж Гершвин юм. Тэрээр америкийн хөгжмийн соёл бүрэлдэн тогтоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Нийт 300 шахам дуу зохиосноос “Хайрт минь”, “Дахиад давт”, “Айзамд нийцүүлж алгаа таш” зэрэг дуунууд нь дэлхий даяар алдаршжээ. Ж.Гершвин 1924 онд “Цэнхэр эгшиглэнт рапсоди” симфони-жазз хөгжим бичсэн нь хамгийн их эрэлт хэрэгцээт концертын бүтээлд тооцогддог. Улмаар “Америк эр Парист” симфони чуулбар, “Порги Бесс хоёр” дуурь бичжээ.

Зундуйн Хангал

Хөгжмийн зохиолч З.Хангал 1966 онд зохиосон “Аяны шувууд”, 1980-аад оны дунд үед зохиосон “Суварган цэнхэр уулс” киноны “Хунгийн дуу”, “Гэрлэж амжаагүй явна” киноны “Энхийн дагинас” зэрэг дуугаараа нийтийн дууны урлагт шинэчлэл хийсэн. Тэрээр янз бүрийн хөгжмийн зэмсэгт зориулсан 7 концерт туурвижээ. Түүний 1973 онд зохиосон “Төгөлдөр хуур, найрал хөгжмийн концерт” Монголын хөгжмийн зохиолчдын энэ төрлөөр туурвисан бүтээлийн анхдагч нь болсон юм. Мөн З.Хангалын хөгжмийн хөг эгшиглэгээний сэтгэлгээ өвөрмөц бөгөөд амьдралын айзам хэмнэл, монгол хүний сэтгэхүйн онцлогийг илэрхийлэх, хөгжмийн шинэ хэлбэр, арга барилыг олж, хурц хэмнэл, хөдөлгөөн, уран чөлөөт зохиомжоороо шинэлэг байж, хөгжмийн дуурьслыг орчин үеийн болгож чадсан. Энэ бүхнийг З.Хангалын “Чавхдаст хөгжмийн дөрвөл”, “Салхит шувуу” найраглал, “Төгөлдөр хуур найрал хөгжмийн концерт”, “Эрдэнэсийн уул” бүжгэн жүжиг, “Хатанбаатар”, “Тань руу нүүж явна” киноны хөгжим гэрчилнэ. 1990 онд “Чавхдаст хөгжмийн дөрвөл”, “Хийл найрал хөгжмийн концерт”, “Эрдэнэсийн уул” бүжгэн жүжгээрээ Монгол улсын Төрийн соёрхол хүртжээ.

Бямбасүрэнгийн Шарав

Монгол улсын Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Б.Шарав Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд төржээ. Тэрээр “Чингис хаан” дуурь, “Ононд хатаагдсан илд”, “Алтан ураг”, “Зуурдын орон”, “Сэрүүн намар” зэрэг бүжгэн жүжиг, гурван симфони, “Эрт унасан хяруу” мюзикл, “Мөрөөдөл”, “Чингис хаан бат оршиг” зэрэг оратори, “Замбативийн наран” (1985 онд ЮНЕСКО-ийн хөгжмийн санд орсон) “Хүмүүн”, “Миний эх орон” зэрэг магтуу, морин хуур, төгөлдөр хуур зэрэг гоцлол болон найрал хөгжмийн долоон концерт, “Их татлагууд”, “Сүхийн цагаан морь” зэрэг дөрвөн чуулбар, “Үлэмжийн ертөнц”, “Хэрлэнгийн домог”, “Зохиомж” зэрэг уран сэтгэмж,

“Сэрсэн тал”, “Их хаадын өргөөнд”, “Тэнгэрийн орон” зэрэг 10 орчим удиртгал, 30 гаруй киноны хөгжим, дан хөгжмийн жижиг хэлбэрийн 70 гаруй бүтээл, төгөлдөр хуурт зориулсан 40 гаруй бүтээл, 30 гаруй романс, 300 гаруй хүүхдийн болон нийтийн дууны бүтээл туурвижээ. Уран бүтээлээрээ 9 CD, зургаан ном эмхэтгэн хэвлүүлсэн байна.

Нацагийн Жанцанноров

Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, хөгжмийн зохиолч Н.Жанцанноров анх 1969 онд “Төрсөн нутгийн бараа” дуугаар уран бүтээлийн гараагаа эхэлжээ. Үүний дараа “Сэвтээ нь үгүй сэтгэл”, “Урангоо”, “Сэрүүн сайхан хангай” зэрэг дуунуудаараа олны танил болж улмаар мэргэжлийн дуулаачийн болон нийтийн дууны чиглэлээр 100 гаруй бүтээл туурвисан байна. Н.Жанцанноров нь ардын уламжлалт хөгжмийн сэтгэлгээгээр монгол ардын хөгжмийн зэмсгүүд болох морин хуур, ёочин, хуучир, ятга, шудрагад зориулсан концертуудыг найрал хөгжимтэй хамсруулан бичсэнээр үндсэний хөгжмийн зэмсэгт зориулсан анхны гоцлол хөгжмийн бүтээл туурвисан хөгжмийн зохиолч юм. Дан хөгжим, дуулаачийн төрлөөс гадна тайз дэлгэцийн хөгжмийн төрлөөр анх 1985 онд “Би чамд хайртай” киноны хөгжмийг зохиосон нь олны хүртээл болсон. Улмаар “Мөнх тэнгэрийн хүчин дор” хэмээх эзэн Чингис хааны тухай түүхэн киноны хөгжим, “Мандухай сэцэн хатан” зэрэг киноны хөгжмүүдийг туурвижээ.

Бирваагийн Мөнхболд

Хөгжмийн зохиолч, төгөлдөр хуурч Б.Мөнхболд “Дуут төвөргөөн” морин хуурын чуулгад зориулсан удиртгал хөгжим (2006), “Галдан бошигт” удиртгал хөгжим (2009), Лимбэ, цоорт зориулсан концерт (2010) бичсэн нь Төрийн санд хадгалагдах шилдэг бүтээлээр тус тус шалгарсан билээ. Б.Мөнхболд хөгжмийн олон төрлөөр авьяасаа сорьсны нэг нь тайз дэлгэцийн төрөл юм. Тэрээр энэ төрлөөр Р.Уильямсын “Хүслийн трамвай”, Ш.Гүрбазарын “Сарны инээд”, С.Цанаевын “Сократын сүүлчийн шөнө”, Галааридын “Шар тэнгисийн тарчлаан” зэрэг 10 гаруй жүжгийн хөгжим бичжээ.

Сангидоржийн Сансаргэрэлтэх

Монголын мэргэжлийн хөгжмийн зохиолчдын залуу үеийн төлөөллийн нэг С.Сансаргэрэлтэх нь уран бүтээлдээ модернист чиг хандлагыг баримталдаг, өөрийн гэсэн арга барил, сэтгэлгээний өвөрмөц онцлогтой хөгжмийн зохиолч юм. Тэрээр ихэвчлэн дан хөгжмийн зохиолын томоохон төрлөөр уран бүтээлээ туурвидаг. Төгөлдөр хуур, хийлийн концерт болон хоёр симфони, хийлийн гоцлол, чавхдаст хөгжмийн дөрвөл, хийл, төгөлдөр хуур, цохивор хөгжимд зориулсан хоёр концерт, “Жамух” симфони (1995), “Хархорум” симфони-уран сэтгэмж “Эх дэлхийгээ аварцгаая” симфони уран сэтгэмж зэрэг бүтээлүүд туурвижээ.

Төмөрийн Дамдинсүрэн

Хөгжимчин, хөгжмийн зохиолч, хөгжмийн найралжуулагч, багш Төмөрийн Дамдинсүрэн 1975 онд Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн “Соёмбо” жазз чуулгад төгөлдөр хуурч, даруулт хөгжимчин, тус чуулгын уран сайхны удирдагчаар ажиллахдаа жаззын төрлөөр олон зохиол бүтээл туурвиж, найралжуулснаас гадна монголд анхны “Dixieland” барилыг дэлгэрүүлсэн юм. Тэрээр орчин үеийн жазз хөгжмийн сургалтын онол арга зүйн анхны сурах бичгийг хөгжим сонирхогч залууст зориулан гаргасан байна.

Скот Жоплин

“Регтаймийн хаан” гэж өргөмжлөгдсөн хөгжмийн зохиолч. Техас мужид хөгжимчний гэр бүлд төрсөн. 1899 онд хэвлэгдсэн “Maple Leaf Rag” түүвэр зохиол нь түүний анхны том амжилт байлаа. “The easy winners”, “The Cascadas”, “The entertainer” зэрэг бүтээлүүд болон регтайм стилээр бичсэн бүжгэн жүжиг, хоёр дуурь зэргийг оролцуулаад нийт 50 гаруй бүтээл туурвижээ. “Регтайм бол сонгодог хөгжимтэй адил утга учиртай цогц юм” гэдгийг батлахад түүний хөгжим чиглэгдэж байв.

Луи Армстронг

Америкийн нэрт жазз дуучин, нарийн бүрээч. Шинэ Орлеаны борчуудын хороололд төрсөн. Тэрээр 21 настайдаа өөрийн анхны хамтлагаа байгуулж, пянз бичлэгээ хийлгэн 1930-аад оноос олны танил болсон байна. Луи Армстронг өвөрмөц сөөнгө тембртэй хоолойгоороо бусдаас ялгарч байв. Нарийн бүрээг маш чадварлаг эзэмшсэн бөгөөд амьдралынх нь туршид түүний нэг имидж болж байлаа. “Сонгодог жаззын алтан үеийн нэрт төлөөлөгчдийн нэг, дэлхийн анхны шилдэг гоцлол бүрээч” хэмээн олонд хүлээн зөвшөөрөгдсөн Луи Армстронг жаззын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.

Элвис Пресли

Элвис Пресли Америкийн Миссисипи мужийн Тьюпело хотод 1935 онд төржээ. Ачааны тэрэгний жолооч байсан Элвис Пресли рок-н-роллын од болохыг хүсэн мөрөөдөж 1956 онд “Шархалсан зүрх” дуугаа бичүүлснээр нэрд гарчээ. Улмаар олон ч кинонд тоглон дуугаа дуулж үзэгчдийг байлдан дагуулжээ. 1957 онд нэлээд олон “Алтан пянз”-ны эзэн болсон Пресли нэр алдрын оргилд хүрч “Рок-н-роллын хаан” хэмээн хүлээн зөвшөөрөгдөв. Үй олон шүтэн бишрэгчдийнх нь дуртай дууны нэг бол “Love me tender” юм.

“Битлз” хамтлаг

1960 онд Ливерпульд байгуулагдсан Английн дуулаач-дан хөгжмийн дөрвөл хамтлаг. Хамтлагийн нэр нь “Beat”- цохилт, “Beetles”- цохнууд гэсэн хоёр үгийн товчлол юм. Тэдний дух, чихээ дарсан үсний засалт нь цохнууд буюу хамтлагийнхаа нэрийг ямар нэг хэмжээгээр илтгэх өвөрмөц имидж нь болжээ. Битлз хамтлаг Рок хөгжмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн ба дэлхий дахинд рок хөгжимчид бүрэлдэн төлөвшихөд шууд нөлөөлсөн. Хамтлагийн бүрэлдэхүүнд Жон Леннон (1940-1980) ритм гитар, Пол Маккартни (1942) бас гитар, Джорж Харрисон (1943-2003) гоцлол гитар, Ринго Старр (1940) цохивор хөгжим тоглож байв. Илэрхийлэл сайтай аялгуу, тоглолтын өвөрмөц арга барил нь энэ хамтлагийг XX зууны 60-аад оны хамгийн алдартай хамтлаг болгосон. Энэ үеэс поп хөгжмийн урсгалд англичууд ноёрхох болсон юм. 1970 онд Битлз хамтлаг тарсан хойно ч тэдний уран бүтээл дэлхийн рок хөгжимчдөд нөлөөлсөөр байв. Хамтлагийн хамгийн алдартай альбом нь “Help”, “Rubber Soul”, “Revolver” зэрэг юм. Америкийн одон орончид өмнө нь нээгээд 4147, 4148, 4149, 4150 гэж дугаарлаж байсан сансрын биетүүдээ Джон Леннон, Пол Маккартни, Джорж Харрисон, Ринго Старр нарын нэрээр нэрлэж Битлзийн түүхэн гавьяаг “Одод” болгон мөнхөлсөн гэдэг.

“АББА” хамтлаг


“АББА” нь XX зууны Шведийн хамгийн алдартай хамтлаг юм. Энэ хамтлагийг санаачлагч нь Стиг Андерсон бөгөөд хамтлагаа Бенни Андерсон, Бьорн Ульвес, дуучин Анни-Фрид Лингстад, Агнета Фальстог нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. “АББА” хэмээх хамтлагийн нэр бол эдгээр гишүүдийнх нь нэрийн эхний үсгүүд юм. “АББА” нь дискотекад зориулагдсан хөнгөн хөгжмийн хамтлаг бөгөөд хөгжмийн стилийн хувьд “Евро-бит” гэж тодорхойлж болно. 1974 оны хавар Английн Брайтон хотод болсон “Евровишн” хөгжмийн наадамд тус хамтлаг “Waterloo” дуугаараа амжилттай оролцсон нь тэр даруйдаа Европын хит болжээ. Жилийн дараа “АББА”, “SOS”, “I do, I do, I do”, “Mama Mia”, “Fernan-da”, “Money, money, money” зэрэг хит дуунуудаа гаргажээ.

Dixieland (диксиленд)

XX зууны эхний хагаст Луизианад үүссэн уламжлалт жаззын хэв маяг. Дикси-орон гэсэн утгатай, Америкийн өмнөд мужийн бэлэгдэл нэр. 5-8 хүний бүрэлдэхүүнтэй, төгөлдөр хуур, басс, банджо, нарийн бүрээ, кларнет, тромбон, тенор саксафон, бөмбөр гэх мэт хөгжмийн зэмсгүүдээс бүрдсэн багавтар бүрэлдэхүүнтэй хамтлагийг Диксиленд банд гэдэг.

Монгол болон дэлхийн хөгжмийн түүхэн тойм





XX ЗУУН

XXI ЗУУН



МЭДЛЭГ СОРИХ АСУУЛГА

1. “Сэтгэгдэл, Нар мандалт” зургийг бүтээгч К.Моне аль чиглэлд хамрагдах вэ?
а.Романтизм б.Экспрессионизм в.Импрессионизм
2. К.Дебюсси “Сирикс” зохиолоо ямар хөгжмийн зэмсэгт зориулан туурвисан бэ?
а.Хийл б.Төгөлдөр хуур в.Флейт
3. М.Равелийн “Болеро” зохиолд аялгуу нь хэдэн удаа хувилбарлагддаг вэ?
а.25 б.18 в.36
4. М.Мөнхболдын “Шар тэнгисийн тарчлаан” зохиол ямар төрлөөр бичигдсэн бэ?
а.Жүжгийн хөгжим б.Дуурь в.Бүжгэн жүжиг
5. К.Орф “Кармина Бурана” зохиолын эхлэл хэсгийн аялгуу ямар цомнолд бичигдсэн бэ?
а.Мажор б.Фриг в.Минор
6. “Эх дэлхийгээ аварцгаая” симфони зураглалыг хэн зохиосон бэ?
а.Б.Шарав б.Н.Жанцанноров в.С.Сансаргэрэлтэх
7. “Хар сарнай” хамтлаг орчин үеийн хөгжмийн ямар хэв маягаар дуулдаг вэ?
а.Поп б.Гранж рок в.Техно реп
8. Шууд зохион хөгжимдөх арга, адармаатай хэмнэл, хөг аялгын содон сонин дуурьсал бүхий хөгжмийн төрөл юу вэ?
а. Жазз б. Блюз в. Поп
9. Танго бүжиг нь бүжгийн ямар төрөлд хамрагдах вэ?
а.Цэнгээнт б.Сонгодог в. Ардын
10. “Агч модны навчис” регтаймын зохиогч хэн бэ?
а. Луи Армстронг б.Скот Жоплин в. Ж.Гершвин
11. Луи Армстронг хөгжмийн ямар чиглэлийн төлөөлөгч вэ?
а.Поп б.Жазз в. Рок
12. Дуу, хөгжим, бүжиг, драмыг хослуулсан театр, киног нэгтгэсэн холимог төрлийг юу гэж нэрлэдэг вэ?
а. Жазз б.Эстрад концерт в.Мюзикл
13. А.Онеггер “Пасифик-231” зохиолдоо зохиомжийн ямар аргыг хэрэглэсэн бэ?
а. Хувилбарлан хөгжүүлэх б. Давтах
14. Найгах, чичрэх гэсэн утгатай англи үгнээс гаралтай, эстрад хөгжмийн нэг төрөл юу вэ?
а.Жазз б.Рок в.Поп
15. “Хорвоод ганцхан ээждээ” дууг хэн зохиосон бэ?
а. Ц.Нацагдорж б. Н.Жанцанноров в.Ц.Чинзориг
16. Жазз хөгжмийн өвөрмөц арга барилаар уламжлал шинэчлэлийг хослуулан бичсэн зохиолыг нэрлэ.
а. Ижилдээ ганцхан шарга б. Хангайн дуу в.Сартай хүрэн
17. XX зууны америкийн хөгжмийн эрдэнэсийн санд орсон Ж.Гершвиний жазз дуурийг нэрлэ.
а. Цэнхэр эгшиглэнт рапсоди б. Порги Бесс хоёр в.Америк эр Парист